



**ҮНДЭСНИЙ БИЕИЙН ТАМИРЫН ДЭЭД
СУРГУУЛИЙН МАГАДЛАН ИТГЭМЖЛЭЛИЙН
ӨӨРИЙН ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАН**

Улаанбаатар
2019 он

ТАНИЛЦУУЛГА

Боловсролын магадлан итгэмжлэх үйл ажиллагааны журмыг үндэслэн магадлан итгэмжлэлийн өөрийн үнэлгээний тайланг өргөн мэдүүлж байна.

Бид энэхүү тайланг Дээд Боловсролын Магадлан Итгэмжлэлийн Үндэсний Зөвлөлөөс гаргасан “Дээд боловсролын сургалтын байгууллагын магадлан итгэмжлэлийн шалгуур, шаардлага”-ыг үндэслэн бичлээ.

Сургуулийн магадлан итгэмжлэлийн өөрийн үнэлгээний тайлангийн баг дараах бүрэлдэхүүнтэйгээр ажиллав. Үүнд:

Багийн ахлагч:

Дэд захирал доктор,
проф. Л.Гүндэгмаа

Багийн гишүүд:

- Эрдмийн зөвлөлийн эрдэмтэн нарийн бичгийн дарга
доктор, проф. Д.Бордух
- Магистрын албаны дарга
доктор, проф. Р.Ганбаатар
- Чанарын баталгаажуулалтын албаны дарга
доктор, дэд проф. И.Сэржхүү
- Сургалтын албаны дарга
дэд проф. Ж.Цогоо
- Онол арга зүйн тэнхимийн эрхлэгч
дэд проф. Р.Лхамсүрэн
- Үндэсний спорт, мэргэжлийн тэнхимийн эрхлэгч
дэд проф. Б.Хэрлэн
- Биеийн тамирын эмчилгээний арга зүйн тэнхимийн эрхлэгч
докторант Ш.Бат-Эрдэнэ
- Багш
доктор Д.Баасанхүү
- Багш
доктор Н.Мягмарзул
- Багш
доктор Р.Түвшинжаргал
- Багш
докторант Д.Өлзийжаргал
- Номын санч
магистр Б.Пүрвээ

АГУУЛГА		
ОРШИЛ		Хуудас
ШАЛГУУР 1	Эрхэм зорилго, зорилтууд	13-18
ШАЛГУУР 2	Засаглал ба эрх зүйн зохицуулалт	19-28
ШАЛГУУР 3	Сургалтын хөтөлбөрийн удирдлага	29-40
ШАЛГУУР 4	Хүний нөөц	41-64
ШАЛГУУР 5	Материаллаг болон технологийн нөөц	65-81
ШАЛГУУР 6	Суралцагчдад чиглэсэн үйлчилгээ	82-91
ШАЛГУУР 7	Нийгэмд чиглэсэн үйлчилгээ	92-97
ШАЛГУУР 8	Эрдэм шинжилгээ, инноваци	98-115
ШАЛГУУР 9	Чанарын баталгаажуулалтын тогтолцоо	116-128
ХАВСРАЛТУУД		129-141

ХҮСНЭГТ ЗУРГИЙН ЖАГСААЛТ

Хүснэгт

- Хүснэгт 1 Сургуулийн эрхэм зорилгын өвөрмөц дүр төрхийн өөрчлөлт
- Хүснэгт 2 Манай сургуулийн үйл ажиллагааны зорилгуудын биелэлтийн явц (2005-2016 он)
- Хүснэгт 3 ҮБТДС-ийн стратеги төлөвлөгөө (2021 он хүртэл)
- Хүснэгт 4 Шалгуур 1 SWOT шинжилгээ
- Хүснэгт 5 Шалгуур 2 SWOT шинжилгээ
- Хүснэгт 6 Мэргэжлийн хөтөлбөр, индекс
- Хүснэгт 7 Сургалтын хөтөлбөрийн шинэчилсэн байдал
- Хүснэгт 8 Багшлахуй болон суралцахуйн үйл ажиллагааг хянаж, дүн шинжилгээ хийж, чанаржуулж буй ажлууд
- Хүснэгт 9 Оюутан суралцагчдын мэдлэгийн үнэлгээ
- Хүснэгт 10 Шалгуур 3 SWOT шинжилгээ
- Хүснэгт 11 Салбар, нэгжүүдийн хүний нөөцийн бүрдлийн түвшин (2017-2018 оны хичээлийн жилээр давхардсан тоогоор)
- Хүснэгт 12 ҮБТДС-ийн хүний нөөцийн хөгжлийн талаар хийгдсэн ажлууд
- Хүснэгт 13 ҮБТДС-ийн багш, ажилчдын 2017-2018 оны хичээлийн жилийн цалингийн шатлал бүхий зардлын төсөв
- Хүснэгт 14 ҮБТДС-ийн багш нарт үзүүлсэн тусламж, үйлчилгээ
- Хүснэгт 15 Багш нарт цалинтай чөлөө олгосон тухай мэдээлэл
- Хүснэгт 16 Шалгуур 4 SWOT шинжилгээ
- Хүснэгт 17 ҮБТДС-д одоо ашиглагдаж байгаа болон төлөвлөгдөж байгаа барилга байгууламжийн үзүүлэлтүүд
- Хүснэгт 18 Сургуулийн барилга, байгууламжийн тохижилт, урсгал болон их засварт зарцуулсан хөрөнгө
- Хүснэгт 19 Программ хангамжийн дэлгэрэнгүй жагсаалт
- Хүснэгт 20 Компьютер, тоног төхөөрөмжийн судалгаа
- Хүснэгт 21 Сургалтын компьютерийн хүчин чадал
- Хүснэгт 22 Сургуулийн дотоод сүлжээний техник хангамж
- Хүснэгт 23 Номын сангийн мэдээлэл
- Хүснэгт 24 Номын сангийн орчин нөхцөл, үйл ажиллагааны талаар авсан судалгааны дүн
- Хүснэгт 25 ҮБТДС-ийн 2010-2018 оны хичээлийн жилийн төсвийн төлөвлөгөө, гүйцэтгэл
- Хүснэгт 26 Сургуулийн төсвийн хуваарилалт
- Хүснэгт 27 Шалгуур 5 SWOT шинжилгээ
- Хүснэгт 28 2013-2018 оны хичээлийн жилд суралцагчдад чиглэсэн арга хэмжээний зардал
- Хүснэгт 29 2014-2018 оны оюутны хөгжил үйл ажиллагаанд зориулсан төсвийн хэмжээ

- Хүснэгт 30 Шалгуур 6 SWOT шинжилгээ
- Хүснэгт 31 Шалгуур 7 SWOT шинжилгээ
- Хүснэгт 32 Багш нарын хэвлүүлсэн эрдэм шинжилгээний өгүүлэл
- Хүснэгт 33 Багш, оюутнуудын эрдэм шинжилгээний хуралд хэлэлцүүлсэн илтгэл
- Хүснэгт 34 Докторантурт сурч байгаа багш нар
- Хүснэгт 35 Эрдэм шинжилгээ судалгааны төсөлт ажлууд
- Хүснэгт 36 Төслийн талаар
- Хүснэгт 37 Сургуулийн эрдэм шинжилгээний ажлын зардал
- Хүснэгт 38 ҮБТДС-ийн эрдэм шинжилгээ, судалгааны төсөлт ажлын зардал
- Хүснэгт 39 Шалгуур 8 SWOT шинжилгээ
- Хүснэгт 40 Программ хангамжийн үндсэн модулиуд
- Хүснэгт 41 Салбар, нэгжүүдийн хүний нөөцийн бүрдлийн түвшин
- Хүснэгт 42 ҮБТДС-ийн оролцсон тэмцээн, уралдааны үндсэн үзүүлэлт
- Хүснэгт 43 Шалгуур 9 SWOT шинжилгээ

Зураг

- Зураг 1 Хамт олны үнэлгээний дундаж оноо
- Зураг 2 Сургуулийн бүтэц, зохион байгуулалтын харьцуулалт (2001 он)
- Зураг 3 Сургуулийн бүтэц, зохион байгуулалт (2015 он)
- Зураг 4 Бүх шатны шийдвэр гаргах үйл ажиллагаа
- Зураг 5 Захиргааны зөвлөлийн бүрэлдэхүүн
- Зураг 6 Захиргааны шийдвэр гаргах үйл явц
- Зураг 7 Хамт олонд өгсөн үнэлгээний дундаж
- Зураг 8 Хөтөлбөрийн шинэчлэл хийгдсэн байдал
- Зураг 9 Хамт олны үнэлгээний дундаж оноо
- Зураг 10 Багш нарын бүтэц \ангиллаар ба хувиар\
- Зураг 11 Багш нарын тэнхимийн харьяалал
- Зураг 12 Профессорын баг, багшлах бүрэлдэхүүний эрдмийн зэрэг, цол
- Зураг 13 Захиргаа, аж ахуйн албан хаагчид
- Зураг 14 Багш, ажилтан нарын спортын зэрэг, цолны байдал
- Зураг 15 Хүний нөөцийн тогтвор суурьшлын судалгаа
- Зураг 16 Үндсэн багш нарын төгссөн сургууль
- Зураг 17 Сэтгэл ханамжийн судалгаа
- Зураг 18 Сэтгэл ханамжийн судалгаа
- Зураг 19 Сэтгэл ханамжийн судалгаа
- Зураг 20 Сэтгэл ханамжийн судалгаа
- Зураг 21 Сэтгэл ханамжийн судалгаа
- Зураг 22 Сэтгэл ханамжийн судалгаа
- Зураг 23 Сэтгэл ханамжийн судалгаа
- Зураг 24 Сэтгэл ханамжийн судалгаа
- Зураг 25 Цалингийн өөрчлөлт
- Зураг 26 Хамт олны үнэлгээний дундаж оноо
- Зураг 27 Материаллаг нөхцлийн зардал
- Зураг 28 ҮБТДС-ийн 2014-2018 оны үндсэн хөрөнгийн дүн
- Зураг 29 ҮБТДС-ийн бага үнэтэй түргэн элэгдэх зүйлсийн дүн
- Зураг 30 Номын сангийн үйлчилгээ
- Зураг 31 Номын фондын бүтэц
- Зураг 32 Номын сангийн үйлчилгээний судалгаа
- Зураг 33 Төсвийн төлөвлөгөө гүйцэтгэл
- Зураг 34 ҮБТДС-ийн төсвийн хуваарилалт
- Зураг 35 Хамт олны үнэлгээний дундаж оноо
- Зураг 36 Суралцагчдад үзүүлсэн үйлчилгээний зардлын өсөлтийн график
- Зураг 37 2014-2018 оны оюутны үйл ажиллагааны төсөв
- Зураг 38 Оюутны үйл ажиллагаанд зориулсан төсвийн хэмжээ
- Зураг 39 Хамт олны үнэлгээний дундаж оноо
- Зураг 40 Хэрэглэгчдийн хандалт, сэтгэл ханамж
- Зураг 41 Доктор зэрэгтэй багш нарын тоо

- Зураг 42 Эрдэм шинжилгээний өгүүлэл
- Зураг 43 Эрдэм шинжилгээний хурал
- Зураг 44 Сургалтад хамрагдсан багшийн тоо ба хэрэгжүүлсэн төслийн тоо
- Зураг 45 Төсөлд хамрагдсан багш, оюутны тоо /2018 он/
- Зураг 46 Төсөлд хамрагдсан багш, оюутны тоо /2019 он/
- Зураг 47 ҮБТДС-тай хамтарч эрдэм шинжилгээний төсөл хэрэгжүүлсэн байгууллагууд
- Зураг 48 ҮБТДС-ийн удирдлагын мэдээллийн систем
- Зураг 49 Вэб сайт
- Зураг 50 Сертификат
- Зураг 51 Батламж гэрчилгээ
- Зураг 52 Батламж гэрчилгээ
- Зураг 53 Хамт олны үнэлгээний дундаж оноо

Товчилсон үгийн тайлбар

АШУУИС	Анагаахын шинжлэх ухааны үндэсний их сургууль
БМИҮЗ	Боловсролын магадлан итгэмжлэлийн үндэсний зөвлөл
БСШУСЯ	Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын яам
БТСГ	Биеийн тамирын спортын газар
БТСОАЗС	Биеийн тамир спортын онол арга зүйн сэтгүүл
БТХТ	Биеийн тамирын хөгжлийн төв
БТЭАЗТ	Биеийн тамирын эмчилгээний арга зүйн тэнхим
БҮТЭЗ	Бага үнэтэй түргэн элэгдэх зүйлс
ДББ	Дээд боловсролын байгууллага
ДБУМС	Дээд боловсролын удирдлагын мэдээллийн систем
ЕБС	Ерөнхий боловсролын сургууль
ЗГХАБТСГ	Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлагийн биеийн тамир спортын газар
ЗГХХГ	Засгийн газрын хэрэг эрхлэх газар
МИДСБТБХ	Монголын их дээд сургуулиудын биеийн тамирын боловсролын холбоо
МИДСК	Монголын их дээд сургуулийн концерциум
МУБИС	Монгол улсын боловсролын их сургууль
МҮОА	Монголын үндэсний олимпын академи
МҮОХ	Монголын үндэсний олимпын хороо
МХБ	Мэргэжлийн хөтөлбөрийн баг
ОАЗТ	Онол арга зүйн тэнхим
ОУХМ	Олон улсын хэмжээний мастер
ОУЭШХ	Олон улсын эрдэм шинжилгээний хурал
ОХУ	Оросын холбооны улс
СА	Сургалтын алба
САШТ	Сургуулийн аварга шалгаруулах тэмцээн
СМ	Спортын мастер
ҮБТДС	Үндэсний биеийн тамирын дээд сургууль
ҮСМТ	Үндэсний спорт, мэргэжлийн тэнхим
ҮУПТ	Үйлдвэр урлалын политехник
ХБӨОГ	Халдварт бус өвчин, осол гэмтэл
ХХААХҮЯ	Хүнс хөдөө аж ахуйн хөнгөн үйлдвэрийн яам
ЧДБА	Чанарын дотоод баталгаажуулалтын алба
ШУБ	Шинжлэх ухааны байгууллага
ЭЗ	Эрдмийн зөвлөл
ЭША	Эрдэм шинжилгээний алба

ОРШИЛ

1991 оны 05 дугаар сард үүсгэн байгуулагдаж 3 багш, 38 оюутантай анхны хичээлийн жилээ эхэлж байсан Үндэсний Биеийн Тамирын Дээд сургууль эдүгээ 28 дахь хичээлийн жилдээ 30 гаруй үндсэн багш, ажилтан, цагийн 8 багштай, 750 гаруй оюутан, магистранттай үйл ажиллагаагаа явуулж байна.

Үндэсний Биеийн Тамирын Дээд сургуулийн дүрэмд зааснаар тус сургууль нь “Боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас албан ёсны зөвшөөрөл авсан хувийн өмчийн, ашгийн бус үйл ажиллагаа эрхлэх хуулийн этгээд мөн”.

Тус сургууль нь 2001, 2006 онд магадлан итгэмжлэгдсэн бөгөөд 2004, 2010 онд Монгол Улсын Дээд Боловсролын менежментийн хүрээлэнгээс шалгаруулсан “Топ-5”, “Топ-10” шилдэг менежменттэй сургуулиудын нэгээр шалгарч байсан юм.

Манай сургууль биеийн тамирын багш, спортын дасгалжуулагч, биеийн тамирын арга зүйч мэргэжлээр бакалаврын болон магистрын сургалт явуулж байгаа бөгөөд 2017-2018 оны хичээлийн жилийн байдлаар 4000 гаруй мэргэжилтэн, 340 гаруй магистр төгсгөөд байна. Сургуулийн сургалтын үйл ажиллагааны үндсэн нэгж нь тэнхимүүд бөгөөд сургалт, судалгаа, дасгалжуулалт, биеийн тамирын арга зүйн эрдэм шинжилгээ, судалгааны ажлын анхдагч нэгж нь профессорын баг, сургалтын лаборатори, мэргэжлийн баг, шавь сургалтын тусгай тоног төхөөрөмж бүхий заал, танхим, кабинетууд юм.

“Бид дэлхийн спортын чиг хандлага, үндэсний спортын өв уламжлал, биеийн тамир, спорт, эрүүл мэндийн хэрэгцээнд нийцсэн хөрвөх чадвар бүхий чанартай мэргэжилтэн бэлтгэх” сургуулийнхаа эрхэм зорилгодоо нийцүүлэн “2021 он хүртлэх ҮБТДС-ийн хөгжлийн стратегийг хэрэгжүүлэх төлөвлөгөө”-тэй ажиллаж байна.

Сургуулийн онцлог: Энэ хичээлийн жилд тус сургуульд 750 гаруй оюутан биеийн тамирын багш, спортын дасгалжуулагч, хөнгөн атлетик, гимнастик, спорт тоглоом, бокс, жүдо, самбо, чөлөөт бөх, хөл бөмбөгийн дасгалжуулагч, биеийн тамирын болон эмчилгээний биеийн тамирын арга зүйч мэргэжлээр тус тус суралцаж байна.

2002 оноос магистрын зэргийн “Биеийн тамирын боловсрол”-ын, “Спортын дасгалжуулагч”-ийн сургалт явуулж байна.

Сургуулийн бакалаврын зэргээр сурч буй оюутнууд танхимын сургалтаар 4 жил суралцах хугацаандаа хичээлээс гадуур үндэсний болон их спортын төрлөөр **долоо хоногт 4-6 цаг шавь сургалтад суралцаж спортын ур чадвар, зэрэг цолоо ахиулж дээшлүүлдэг тогтолцоо бүхий онцлог сургалттай. Хот, улс, тив, дэлхийн аваргын тэмцээнд оролцох удаан хугацааны бэлтгэл хийдэг шигшээ багийн тамирчин болон спортын авьяастай тахир дутуу, хэлгүй, дүлий зэрэг хөгжлийн бэрхшээлтэй залуучуудыг сургадаг. Паралимпод манай сургуулийн 3 төгсөгч амжилттай оролцсон.**

Тус сургуулийн оюутнууд олимпын их наадам, дэлхий, тивийн аварга шалгаруулах тэмцээнд өндөр амжилт үзүүлж, 200 гаруй медаль хүртсэнээс гадна улсын чанартай тэмцээнээс алт, мөнгө, хүрэл медаль 600 гаруйг аваад байна. Оюутнууд спортын амжилтынхаа үр дүнгээр төр засгаас олон сая төгрөгийн шагнал, урамшуулал авдаг нь сургуулийн бас нэг онцлог юм.

2018 оны байдлаар төгсөгчдөөс Хөдөлмөрийн баатар 1, Олимпын медальтан 3, Гавьяат дасгалжуулагч 4, Гавьяат тамирчин 15, Дэлхийн болон тивийн аварга олон арван тамирчин оюутнууд төрөн гарчээ.

ҮБТДС-ийн оюутнууд 2004 онд МБАТүмний XI спартакиадын шигшээ уралдаанд багаараа III байр, их дээд сургуулийн оюутны спортын I, II, III. IV 2005, 2009, 2013, 2017

онуудад “Универсиад” их наадмын тэргүүн байр, оюутны улсын аварга шалгаруулах тэмцээнд удаа дараа тэргүүн байр эзэлсэн юм.

ҮБТДС байгуулагдсанаас хойш 2 багш шинжлэх ухааны доктор, 6 багш дэд докторын зэрэг хамгаалсан ба эдүгээ орон тооны багш нараас 8 багш эрдмийн зэрэг цолтой, “Боловсролын тэргүүний ажилтан”, “Биеийн тамирын тэргүүний ажилтан”, “Эрүүлийг хамгаалахын тэргүүний ажилтан” зэрэг олон шилдэг багш нар ажиллаж байна.

Манай хамт олон магадлан итгэмжлэлд бэлтгэхдээ өөрийн үнэлгээний тайлан бичих ажлыг сургуулийн 2021 он хүртлэх хөгжлийн стратегийг тодорхойлох, улмаар магадлан итгэмжлэлийн өөрийн үнэлгээний тайлан бичиж боловсруулах, тухайн тайланг багш ажилтан, хамт олон, сургууль гэсэн дарааллаар бичсэн болно. Ийнхүү бичихдээ эхний ээлжинд магадлан итгэмжлэлийн өөрийн үнэлгээний тайлан бичих баг бүрдүүлж ажилласан.

Бид өөрийн үнэлгээний тайланг боловсруулахдаа БМИҮЗ-өөс явуулсан сургалт, заавар, зөвлөмжийг удирдлага болгон ҮБТДС-ийг 2006-2016 онд хөгжүүлэх стратеги төлөвлөгөөний хэрэгжилт, “Боловсролын магадлан итгэмжлэх үйл ажиллагааны журам”-ыг үндэслэв.

Захирлын 2016 оны 01 дүгээр сарын 11-ний өдрийн 01 тоот тушаалаар өөрийн үнэлгээний багийг Доктор (Ph.D), профессор Л.Гүндэгмаагаар ахлуулан сургалтын албаны дарга, эрдэмтэн нарийн бичгийн дарга, онол арга зүйн тэнхимийн эрхлэгч, үндэсний спорт, мэргэжлийн тэнхимийн эрхлэгч, биеийн тамир эмчилгээний арга зүйн тэнхимийн эрхлэгч, багшийн төлөөлөгч, номын санч гэсэн бүрэлдэхүүнтэйгээр байгуулан ажиллуулж эхэлсэн.

Дээд Боловсролын Магадлан Итгэмжлэлийн Үндэсний Зөвлөлөөс гаргасан “Дээд боловсролын сургалтын байгууллагын магадлан итгэмжлэлийн шалгуур, шаардлага”-ын дагуу дараах үзүүлэлтүүдээр боловсрууллаа.

Дээд боловсролын байгууллагын магадлан итгэмжлэлийн эхний үе нь өөрийн үнэлгээ хийх бөгөөд энэхүү өөрийн үнэлгээ нь тус бүрдээ шалгуур шаардлагатай болохыг харгалзан тухайн шалгуур, шаардлагад нийцүүлэн өөрийн үнэлгээний тайлан бичих багуудыг шалгуур бүрээр байгуулан тайлангаа бичсэн болно. Ингэхдээ тайлан бичих ажлыг багш нэг бүрийн өөрийн үнэлгээний тайлан, тэнхим, албад, сургуулийн гэсэн дарааллаар зохион байгуулж тэнхим, баг бүр нягтлан хэлэлцэж нэгдсэн тайлангаа бичсэн болно.



**ҮНДЭСНИЙ БИЕЙН ТАМИРЫН
ДЭЭД СУРГУУЛИЙН ЗАХИРЛЫН
ТУШААЛ**

2017 оны 12 сарын 25 өдөр

Дугаар 42

Улаанбаатар хот

Г 7
Өөрийн үнэлгээний баг байгуулах тухай


Боловсролын магадлан итгэмжлэх үндэсний зөвлөлийн 2014 оны 10 дугаар сарын 01-ны өдрийн 01 дүгээр тогтоолын 2 дугаар хавсралтаар батлагдсан Боловсролын магадлан итгэмжлэх үйл ажиллагааны журам-ыг үндэслэн ТУШААХ НЬ:

Нэг. Сургуулийн 3 дахь шатны магадлан итгэмжлэлд бэлтгэж оруулах, магадлан итгэмжлэлийн шалгуур хангаж буйд өөрийн үнэлгээ хийж дүгнэлт гаргах ажлын хэсгийг хавсралтаар баталж, өөрийн үнэлгээний багийн ахлагчаар дэд захирал /Л.Гүндэгмаа/-г томилсугай.

Хоёр. Магадлан итгэмжлэх үйл ажиллагааны хүрээнд шалгуур үзүүлэлтүүдийн нэр томъёололыг сургуулийн өвөрмөц онцлогт нийцүүлэн оновчтой тодорхойлж чанарын баталгаажуулалт хийх өөрийн үнэлгээний тайлан, хавсралт материалуудыг графикийн дагуу хугацаанд нь боловсруулан бэлтгэж магадлан итгэмжлэх үндэсний зөвлөлийн ажлын комисст хүлээлгэн өгөхийг шалгуур үзүүлэлт хариуцсан хэсэг тус бүрийн ахлагч нарт үүрэг болгосугай.

Гурав. Хэсгийн ахлагч нарыг нэгдсэн удирдлагаар хангаж ажиллахыг өөрийн үнэлгээний багийн ахлагч /Л.Гүндэгмаа/-д, үйл ажиллагааны үе шаттай төлөвлөгөө боловсруулж ажиллахыг хэсгийн ахлагч нарт тус тус үүрэг болгосугай.

ЗАХИРАЛ



Л. Алтанцэцэг

ДОКТОР(Sc.D), ПРОФЕССОР
Л.АЛТАНЦЭЦЭГ

Шалгуур №	Шалгуурын үзүүлэлтүүд	Хариуцах эзэн
Шалгуур 1	Эрхэм зорилго, зорилт	Ахлагч: Доктор Л.Алтанцэцэг Гишүүд: Д.Бордух, М.Мөнхбат, Д.Шүрэнцэцэг
Шалгуур 2	Засаглал эрх зүйн зохицуулалт	Ахлагч: Доктор Д.Бордух, Гишүүд: Дэд проф.Т.Баатар, Б.Батсайхан, Б.Мөнгөнтуяа, Б.Пүрэв
Шалгуур 3	Сургалтын хөтөлбөр шинэчлэл	Магистрын хөтөлбөрийн ахлагч: Доктор Р.Ганбаатар, Гишүүд: Д.Баасанхүү, Р.Түвшинжаргал, Ц.Цэрэнгаваа Бакалаврын хөтөлбөрийн ахлагч: Ж.Цогоо, Гишүүд: Тэнхимийн эрхлэгчид дэд проф. Ц. Баярсайхан, Д.Өлзийжаргал, М.Нямцэрэн, Д.Шүрэнцэцэг, Д. Баянжаргал, С.Мөнх-Эрдэнэ.
Шалгуур 4	Хүний нөөц	Ахлагч: Н.Мягмарзул Гишүүд: Л.Алимаа, М.Мөнхбат, Э.Золжаргал,
Шалгуур 5	Материаллаг болон технологийн нөөц	Ахлагч Л.Гүндэгмаа Гишүүд: Б.Пүрэв, Р.Түвшинжаргал, М.Нямцэрэн, Тэнхимийн эрхлэгчид
Шалгуур 6	Суралцагчдад чиглэсэн үйлчилгээ	Ахлагч: Д.Өлзийжаргал, Ж.Цогоо Гишүүд: Оюутны зөвлөлийн гишүүд
Шалгуур 7	Нийгэмд чиглэсэн үйлчилгээ	Ахлагч: Р.Түвшинжаргал Гишүүд: Тэнхимийн эрхлэгчид, оюутны зөвлөл
Шалгуур 8	Эрдэм шинжилгээ, инноваци	Ахлагч: Л.Гүндэгмаа, Гишүүд: Д.Баасанхүү, Л.Алтанцэцэг, нябо нар
Шалгуур 9	Чанарын баталгаажуулалтын тогтолцоо	Ахлагч: И.Сэржхүү Д.Баасанхүү, Гишүүд: Тэнхимийн эрхлэгчид, оюутны зөвлөл

ШАЛГУУР 1. ЭРХЭМ ЗОРИЛГО, ЗОРИЛТУУД

Эрхэм зорилго, алсын хараа нь сургуулийн онцлог байдал, үндэсний болон олон улсын хүрээнд эзлэх байр суурийг тусгасан байна.

Эрхэм зорилго, алсын харааг өдөр тутмын үйл ажиллагаандаа хэрэгжүүлж, үечилсэн байдлаар шинэчилдэг байна.

ҮБТДС-ийн эрхэм зорилго нь дэлхийн спортын чиг хандлага, үндэсний спортын өв уламжлал, нийгмийн шинэ харилцааны үеийн боловсрол, биеийн тамир, спорт, эрүүл мэндийн хэрэгцээнд нийцсэн хөрвөх чадвар бүхий чанартай мэргэжилтэн бэлтгэх таатай орчин бүрдүүлж нийгэмд үйлчлэхэд оршино.

Алсын хараа: Монгол Улсад биеийн тамир, спортын шинжлэх ухааны сургалт, судалгааны шинэ түвшинд хүрэх бодлогод суурилсан, олон улсын түвшинд хүрсэн сургууль байна.

Үзэл баримтлал: Биеийн тамир→эрүүл мэнд→спорт→амжилт

Уриа: “Итгэл-Сэтгэл-Зүтгэл”

Үнэт зүйлс: Үндэсний спортын өв уламжлал, Монгол сэтгэлгээ

Манай сургуулийн эрхэм зорилго нь бидний хөгжил дэвшлийн явц, ололт амжилт, алсын хараа, стратеги зорилт, өөрийн орны болон гадаад нөхцөл байдалтай уялдан улам нягт, илүү агууламжтай болон төгөлдөржиж ирсэн юм. Энэ тухай дараах харьцуулалтаар харуулав.

Хүснэгт 1.

Сургуулийн эрхэм зорилгын өвөрмөц дүр төрхийн өөрчлөлт

2000 он	2005 он	2016 он
Сургуулийн эрхэм зорилго нь биеийн тамир, спорт, боловсрол, эрүүл мэнд, үндэсний спортын, өргөн мэдлэгтэй, харилцааны өндөр соёлтой, тамирчдын спортын амжилт, уран чадварыг дээшлүүлэх, нийгмийн хэрэгцээ шаардлагын дагуу хөрвөх чадвартай биеийн тамирын багш, эрүүл мэндийн арга зүйч, дасгалжуулагчдыг олон улсын жишиг хандлагад нийцүүлэн бэлтгэх таатай орчныг бүрдүүлэн нийгэмд үйлчлэхэд чиглэнэ.	ҮБТДС-ийн эрхэм зорилго нь дэлхийн спортын чиг хандлага, нийгмийн шинэ харилцааны үеийн боловсрол, биеийн тамир, спорт, эрүүл мэндийн хэрэгцээнд нийцсэн хөрвөх чадвартай мэргэжилтэн бэлтгэх таатай орчин бүрдүүлж нийгэмд үйлчлэхэд оршино. Орчин үеэ сайн мэдэрсэн, зорилго, тэмүүлэл тодорхой, стратеги зорилгоо багтаасан өмнөхөөс илүү багтаамжтай томъёолол болсон гэж үзсэн.	ҮБТДС-ийн эрхэм зорилго нь дэлхийн спортын чиг хандлага, үндэсний спортын өв уламжлал, нийгмийн шинэ харилцааны үеийн боловсрол, биеийн тамир, спорт, эрүүл мэндийн хэрэгцээнд нийцсэн хөрвөх чадвартай мэргэжилтэн чанартай бэлтгэх таатай орчин бүрдүүлж нийгэмд үйлчлэхэд оршино. Манай эрхэм зорилго (mission) нь бид яаж хөгжөөд, ямар үр дүнд хүрэх, үүний тулд юу хийх ёстойг нэгтгэн томъёолсон үзэл баримтлал мөн.

2005 онд өөрчлөн сайжруулах явцдаа сургуулийн “Эрхэм зорилго”-д *Үндэсний спортын өв уламжлалын* асуудлыг орхигдуулсаныг 2016 онд дахин тусгаж, тус сургуульд хэрэгжиж буй хөтөлбөрүүдээр орчин үеийн боловсролын чиг хандлагад нийцсэн биеийн тамирын багш, спортын дасгалжуулагчид, биеийн тамир, спортын чийрэгжүүлэлтийн арга зүйчдийг чанартай бэлтгэхээр нэмэлт өөрчлөлт оруулсан.

Зорилго: Сургуулийн эрхэм зорилгод нийцсэн стратеги зорилт нь спортын даяршил, зах зээлийн харилцааны судалгаа, инновацид суурилсан чанартай сургалт явуулан нийгмийн эрэлт хэрэгцээг хангах.

Зорилт: Даяршил→Нийгмийн захиалга→Зах зээл→Өрсөлдөөн→Судалгаа→Чанар сургалт юм.

1.2. Зорилгууд тэдгээрийн биелэлтийн явц:

Биеийн тамир, спортын салбарт шинжлэх ухаан, судалгааны ололт амжилтыг нэвтрүүлэх сургуулийн эрхэм зорилгын үндэс суурь нь стратегийн зорилт юм. Бид сургуулийнхаа стратеги зорилт буюу хэтийн төлөвлөгөөт зорилтуудаа хэрэгжүүлсээр ирсэн.

Хүснэгт 2.

Манай сургуулийн үйл ажиллагааны зорилгуудын биелэлтийн явц (2005-2016 он)

Д/д	Үйл ажиллагаа	Зарцуулах төсөв (сая.төг)	Хугацаа	Гүйцэтгэл
1.	Сургалтын төлөвлөгөөнд заасан хичээлүүдээр онол, арга зүйн тулгуур сурах бичиг, 20-ийг бичиж хэвлүүлэх	Сургуулийн төсөв	2006-2016	Сургалтын төлөвлөгөөнд тусгагдсан хичээлүүдийн 80% -нь сурах бичигтэй
2.	Сургалтын үйл явцыг сургалт-эрдэм шинжилгээ-үйлдвэрлэл гэсэн тогтолцоонд шилжүүлж олон улсын болон өөрийн орны шинжлэх ухааны төсөлт ажил хэрэгжүүлэх, судалгаа хийх.	БСШУЯ, ОХУ-ын суурь судалгааны сан	2006 оноос	Олон улсын-2, Монголын Мянганы Сорилтын Сан-2, Боловсролын Хүрээлэн- 2, БТСХТ-2 төсөл хэрэгжүүлсэн
3.	Монгол улсын хүн амын бие бялдрын чийрэгжүүлэлтийн хөтөлбөрийг боловсруулах	Мянганы сорилын сангаас	2010-2012	ММСС-ийн 2 төслөөр Нийт 25 сая төгрөгийн санжүүжилт авч хэрэгжүүлсэн
4.	2008, 2012, 2016 оны Олимпод оролцох баг тамирчдыг шинжлэх ухааны үндэслэлтэй бэлтгэх арга зүйг боловсруулах	Улсын төсвөөс	2006-2016	ҮБТДС-ийн эрдэмтэд Судалгааны баг

5.	Хамтын ажиллагааны гэрээтэй Москва, Алма-Ата, Киев, Токио, Бээжингийн спортын их сургуульд багш нарын 60%-ийг мэргэжил дээшлүүлэх, гадаадын эрдэмтэн багш нарыг урьж ажиллуулах	Сургалтын төсвөөр	2006-2011	Хамтын ажиллагааны гэрээ байгуулж багш нараа оролцуулсан.
6.	Орон тооны эрдэмтэн багш нарын хувийн жинг 30%-д хүргэх.	Сургуулийн төсвөөс	2006-2016	Нийтдээ үндсэн 27 багш нараас 8 доктор буюу 29,6% -д хүрсэн.
7.	Спортын цогцолбор сургалтын төв байгуулах /газар авах, зураг төсөл хийлгэх, барилгын материалаа захиалах/	Сургуулийн төсвөөс	2014-2016 онд	Одоогоор 700 сая төгрөг зарцуулаад байна.
8.	Биеийн тамирын, эмчилгээ, нөхөн сэргээлтийн төвийг өөрийн сургуулийн дэргэд байгуулах	Гадаад дотоодын төслөөр	2010-2016 он	ММССан-ийн төслөөр Эмчилгээний чийрэгжүүлэлтийн кабинет 2016 онд байгуулсан.

Тус сургууль нь “Дээд боловсролын тухай” хуулийн 12.1.1. дэх заалт, ҮБТДС-ийн Удирдах Зөвлөлийн дүрмийн 3.1.1. дэх заалт, ҮБТДС-ийн дүрмийн 1.2 дах заалтын дагуу сургуулийн стратеги төлөвлөгөө (2021 он хүртэл) боловсруулан мөрдөж амжилттай хэрэгжүүлж байна.

Хүснэгт 3.

1.3. ҮБТДС-ийн стратеги төлөвлөгөө (2021 он хүртэл)

Стратегийн зорилго 1. Биеийн тамир, спортын судалгааны ажлын үр дүнтэй тогтолцоог бүрдүүлэх

Стратегийн зорилт 1.1 Сургалт судалгааны ажлыг явуулах эрдэм шинжилгээний төв байгуулах	Шалгуур үзүүлэлт <ul style="list-style-type: none"> МУ-ын "БТС-ын тухай", "Боловсролын тухай хууль", "Хүн амын бие бялдрын чийрэгжүүлэлтийн үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх төвийг БТСГ бусад дүүргүүдтэй хамтран байгуулахад оролцоно. Сургуулийн төсвийн орлогод судалгаа, шинжилгээ, технологийн үйл ажиллагааны төслүүдийн орлогын эзлэх хувийг нэмэгдүүлнэ.
Стратегийн зорилт 1.2 Профессор багш нарын бүтээлийг баталгаажуулах тогтолцоог бүрдүүлэх	Шалгуур үзүүлэлт <ul style="list-style-type: none"> Биеийн тамир, спортын салбарын болон бусад салбарын олон улсын түвшинд хэвлэгдсэн эрдэм шинжилгээний өгүүлэлийн тоог 10-аас доошгүй хувьд хүргэнэ. Сургуулийн болон эрдэмтэн багш нарын бүтээлийг оюуны өмчийн газраар баталгаажуулна.
Стратегийн зорилт 1.3 Сургалт судалгааны ажлыг явуулах хамтын ажиллагааг нэмэгдүүлэх	Шалгуур үзүүлэлт <ul style="list-style-type: none"> Байгууллагуудтай хийсэн гэрээний төсөл, захиалгат ажлыг нэмэгдүүлнэ.

Стратегийн зорилго 2. Сургалтын тогтолцоог нийгмийн эрэлт хэрэгцээнд нийцүүлэн чанаржуулах, оновчтой болгох

<p>Стратегийн зорилт 2.1 Сургалтын агуулга, хөтөлбөр, төлөвлөгөөг оновчтой болгох, сургалтын тогтолцоог боловсронгуй болгох</p>	<p>Шалгуур үзүүлэлт</p> <ul style="list-style-type: none"> • Сургалтын хөтөлбөр, хичээлийн агуулгын уялдааг сайжруулж, боловсронгуй болгоно. • Сургалтын үр дүнг дээшлүүлж багш, оюутны зохистой харьцаа тогтооно. • Нийт оюутны ахисан түвшинд суралцагчдын тоо нэмэгдэнэ. • Төгсөгчдийн ажил эрхлэлтийн хувийн жинг өсгөнө.
<p>Стратегийн зорилт 2.2 Сургалтын чанарын баталгааг сайжруулах.</p>	<p>Шалгуур үзүүлэлт</p> <ul style="list-style-type: none"> • Нийт бакалаврын хөтөлбөрүүдийг шат дараалан үндэсний хэмжээнд магадлан итгэмжлүүлнэ. • Олон улсын түвшинд байгууллагаа магадлан итгэмжлүүлнэ.

Стратегийн зорилт 3. Биеийн тамирын багш, спортын мэргэжилтэн бэлтгэх үйл ажиллагааг өргөжүүлэх

<p>Стратегийн зорилт 3.1 "Токио 2020"-ын олимпын баг тамирчдыг амжилттай оролцуулахад шинжлэх ухааны үндэслэлтэй бэлтгэх арга зүйг боловсруулах ажлын хэсэгт оролцох</p>	<p>Шалгуур үзүүлэлт</p> <ul style="list-style-type: none"> • Улсын болон хувийн хэвшлийн клуб, дэвжээ, спортын байгууллагуудын өндөр зэрэгтэй тамирчдын бэлтгэл дасгалжуулалтад оролцож, шигшээ багийн тамирчдын ур чадвар нэмэгдүүлнэ.
<p>Стратегийн зорилт 3.2 Оюутны спортын ур чадварыг дээшлүүлэх "Шавь сургалт"-ын бүтэц, зохион байгуулалтыг боловсронгуй болгох</p>	<p>Шалгуур үзүүлэлт</p> <ul style="list-style-type: none"> • Монгол Улсад шилдэг тамирчдыг бэлтгэх тогтолцоог бүрдүүлж, тив, дэлхий, олимпод оролцох тамирчдын тоог нэмэгдүүлнэ.

Стратегийн зорилт 4. Багш, ажилчид, оюутны нийгмийн баталгааг дэмжих

<p>Стратегийн зорилт 4.1 Багш ажилчид тогтвортой ажиллах, хөгжих орчин нөхцлийг сайжруулах</p>	<p>Шалгуур үзүүлэлт</p> <ul style="list-style-type: none"> • Багш нарыг дотоод, гадаадад мэргэжил дээшлүүлэх, эрдмийн цол хамгаалахад нь дэмжлэг үзүүлэх, үндсэн багш нар дотор эрдэмтдийн эзлэх хувийн жинг 10-15%-д хүргэнэ. • Сургуульд мөрдөгдөх дүрэм, журмыг боловсронгуй болгоно.
<p>Оюутан залуучуудын сурах боломж нөхцлийг сайжруулж, мэргэжлийн ур чадвараа дээшлүүлэхэд тэтгэлэг бусад дэмжлэг үзүүлэх</p>	<p>Шалгуур үзүүлэлт</p> <ul style="list-style-type: none"> • Элсэлтийн чанарыг сайжруулснаар элсэгчдийн тоо нэмэгдэнэ. • Оюутанд үйлчлэх албан болон албан бус бүтэц тогтворжсон байна. • Төгсөлтийн дараах албаны сургалтын үйл ажиллагаа сайжирсан байна.

Стратегийн зорилт 5. Биеийн тамир, спортын сургалт-дасгалжуулалт-эрдэм шинжилгээний цогцолборыг барьж байгуулах

<p>Стратегийн зорилт 5.1 Спортын цогцолбор сургалтын төвийн барилга</p>	<p>Шалгуур үзүүлэлт</p> <ul style="list-style-type: none"> • Спортын цогцолбор төвийн ерөнхий төлөвлөгөө, зураг хийгдэж, шав тавигдана.
--	--

барих төсөл боловсруулах, холбогдох зураг эскиз хийлгэх, хөрөнгө оруулалтын эх үүсвэрийг шийдэх	<ul style="list-style-type: none"> Цогцолборын зарим барилга баригдаж эхэлнэ.
Спортын цогцолбор сургалтын төвийн дэргэдэх биеийн тамирын эмчилгээ, нөхөн сэргээлтийн эмнэлэг байгуулах	<p>Шалгуур үзүүлэлт</p> <ul style="list-style-type: none"> Тамирчин оюутнуудыг бэртэл гэмтлээс урьдчилан сэргийлэх, нөхөн сэргээлтийн төвтэй болно.


Энэхүү стратеги зорилтыг хэрэгжүүлэх төлөвлөгөөг хэрэгжих хугацаа, зарцуулах төсөв, арга хэлбэрээр нь нарийвчлан боловсруулсан юм. Уг төлөвлөгөөг хавсралтаас үзнэ үү.

Бид магадлан итгэмжлэлийн шалгуур үзүүлэлт бүрээр хамт олны санал асуулгаар үнэлгээ өгч зохих дүгнэлтүүдийг гаргасан юм.

Эрхэм зорилго, зорилт шалгуурыг сургуулийн хамт олон, багш нараас 1-4 оноогоор үнэлүүлж дундаж оноог гарган үзэхэд 3,37-3,63 буюу хангалттай гэсэн үнэлгээ гарсан байна (Зураг № 1). Гэвч шалгуур доторх үзүүлэлтүүдээс хэдийгээр хангалттай боловч бусад дэд шалгуураас доогуур - “3,37” үнэлгээг “Эрхэм зорилго” дэд шалгуурт өгсөн байна. Тухайлбал, “*Үндэсний хэв маяг, үндэсний спортын сургалтын өв уламжлал дээр суурилсан*” гэсэн саналууд алга болсныг шүүмжилжээ.

Уг нь анхны “Эрхэм зорилго”-д энэ санаа тусгасан байсан бөгөөд өмнөх магадлан итгэмжлэлийн шалгалтын явцад шинжээчдийн “хэтэрхий нуршсан байна” гэсэн шүүмжлэлээр хасагдсан юм. Энэ нь бидний цаашид анхаарвал зохих асуудал мөн.

Зураг 1.



SWOT шинжилгээ

<p>Давуу тал:</p> <ul style="list-style-type: none"> - Үндэсний спортын өв уламжлал сургалтын арга зүйд суурилсан. - Спортын анхны ууган сургууль бөгөөд орчин үеийн спортын сургалтыг явуулдаг. - Дасгалжуулалтын чиг хандлагыг тусгасан сургалтын хөтөлбөртэй. - Спортын өндөр зэрэг цолтой багш нар хичээл заадаг. - Сургуулийн стратеги төлөвлөгөөг дэлхийн болон Монгол улсын спортын хөгжлийн төлөв, дээд боловсролын чиг хандлагад нийцүүлэн боловсруулсан. - Сургуулийн стратеги зорилго, зорилтуудаа шинэчилэн боловсруулсан. - Сургуулийн алсын хараа, эрхэм зорилго, стратегийн зорилго, зорилтуудын уялдаа холбоо сайн хангагдсан. 	<p>Сул тал:</p> <ul style="list-style-type: none"> - Сурагчдын ерөнхий мэдлэгийн түвшин тааруу - Багш, оюутнууд спортын бэртэл гэмтэл авах магадлал өндөр - Спорт цогцолбор байгуулах санхүүжилтийн асуудал бүрэн шийдэгдээгүй
<p>Боломж:</p> <ul style="list-style-type: none"> - МУ-ын "БТС-ын тухай", "Боловсролын тухай хууль", "Хүн амын бие бялдрын чийрэгжүүлэлтийн үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх төвийг БТСГ бусад дүүргүүдтэй хамтран байгуулах боломжтой. - Спортын даяаршил ба зах зээлийн харилцааны өнөө үеийн онцлог нөхцөл байдалд зохицсон хөрвөх чадвартай. - Сургуулийн төсвийн орлогод судалгаа, шинжилгээ, технологийн үйл ажиллагааны төслүүдийн орлогын эзлэх хувийг нэмэгдүүлэх боломжтой. - Сургуулийн стратеги төлөвлөгөө болон стратегийн зорилго, зорилтуудыг боловсруулахад оролцогч талуудын оролцоог сайн хангасан тул амьдралд хэрэгжихүйц болсон. 	<p>Эрсдэл:</p> <ul style="list-style-type: none"> - Төгсөгчдийн тоо буурах - Эдийн засгийн хямралаас болж ажлын байр хомсдсоноос төгсөгчдийн ажлын байраар хангагдах нөхцөл буурах - Оюутанд үйлчлэх албан бус бүтцийг бүрдүүлэхэд талуудын оролцоо жигд бус байх

Анхаарах зүйлс, сайжруулах арга зам:

1. Багш нар эрхэм зорилгоо сайтар судалж, бүрэн хэрэгжүүлэх үйл ажиллагаандаа анхаарч ажилладаг ч оюутнуудын дунд эрхэм зорилгыг сурталчилан таниулах үйл ажиллагааг тогтмолжуулах, хяналт тавих нь учир дутагдалтай байгаа нь асуумж судалгааны дүнгээс харагдсан.

2. ҮБТДС-ийн хамт олон эрхэм зорилгоо хэрэгжүүлэхийн тулд хөгжлийн стратегийн 3 чиглэлийг сонгон авсан. Эдгээр стратеги чиглэл нь тодорхой цаг хугацаа, тоон үзүүлэлтүүдээр хэмжигдэхүйц байх тул 2021 он хүртлэх мастер төлөвлөгөөнд хяналт тавих, зохицуулалт хийх хэрэгтэй юм. Үүний тулд эрхэм зорилго ба стратеги зорилгын хоорондын уялдааг хангах, сайжруулах арга замыг дээшлүүлэхэд илүү анхаарах шаардлагатай.

ШАЛГУУР 2. ЗАСАГЛАЛ БА ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТ

Сургууль нь стратегийн хэтийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх, оролцогч талуудын хэрэгцээг хангахуйц зохион байгуулалтын бүтэц, засаглал, эрх зүйн зохицуулалттай ажиллаж, үйл ажиллагааны чанар, үр өгөөжтэй байдлыг хангадаг байна.

2.1. Засаглал. Сургууль, салбар, нэгжүүдийн үйл ажиллагааны уялдаа холбоо, эрх мэдэл, үүрэг хариуцлагын хуваарилалт, зохион байгуулалтын бүтэц нь стратеги төлөвлөгөөнийхөө хэрэгжилтийн баталгааг хангахуйц байна. Оролцогч талууд бүтэц, үйл явцад идэвхтэй оролцдог байна.

ҮБТДС нь засаглалын хувьд ардчилсан зарчмын үндсэн дээр үйл ажиллагаагаа явуулдаг хамтын удирдлагатай бие даасан хуулийн этгээд юм.

ҮБТДС-ийн хэмжээнд засаглал, эрх зүйн зохицуулалтын үндэс нь “Боловсролын тухай хууль”, “Дээд боловсролын тухай хууль”, “Биеийн тамир, спортын тухай хууль”, “Үндэсний Их Баяр Наадмын тухай хууль”, “Биеийн тамир, спортын талаар төрөөс баримтлах бодлого”, “Дээд боловсролын стандарт”-ууд зэрэг төрийн хууль, тогтоомжууд байна.

Өнөөгийн Үндэсний Биеийн Тамирын Дээд Сургууль 1991 оны 5 дугаар сарын 1-нд анхны хувийн дээд сургуулийн зөвшөөрөл авч байх үедээ “Монголын Үндэсний Биеийн Тамирын Дээд Сургууль” нэртэй байсан бөгөөд 1996 онд тус сургууль нь мэргэжлийн чиглэлээр төрөлжин бөхийн төрлөөр мэргэших “Шонхор” Дээд Сургууль, үндэсний спортын өв уламжлалд суурилсан “Үндэсний Биеийн Тамирын Дээд Сургууль” гэсэн хоёр дээд сургууль болон албан ёсоор бие даасан юм.

Сургуулийн бүтцийн ахиц өөрчлөлт: Сургууль бие даасан статустай болж биеийн тамир, спортын багш-дасгалжуулагч, биеийн тамирын эмчилгээний арга зүйч мэргэжлээр мэргэжилтэн бэлтгэн гаргах болсноор сургуулийн удирдлага, зохион байгуулалтын бүтцийг сургуулийн мэргэжлийн чиглэл, хэтийн төлвийг бодолцон өөрчлөх шаардлага гарсан юм.

Мөн энэ үеэр “Дээд Боловсролын тухай” хууль батлагдан гарсан нь сургуулийн бүтцийг (менежментийг) зайлшгүй шинэчлэх нэг үндэс болсон. Ийнхүү сургуулийнхаа бүтцийг сургалтын алба, түүний харьяа Онол, арга зүйн; Үндэсний спорт, мэргэжлийн; Биеийн тамирын эмчилгээ, арга зүйн гэсэн 3 тэнхимтэй байхаар сонгож авсан юм. Сургуулийн энэхүү бүтэц нь тухайн үеийн Монголын Дээд Боловсролын Менежментийн Хүрээлэнгээс шалгаруулдаг шилдэг менежменттэй “ТОП-5” дээд сургуульд багтах нэг үндсэн үзүүлэлт болсон юм.

Цаг үеийн шаардлагаар сургуулийн бүтэц, зохион байгуулалтад зарим өөрчлөлт орж байсан боловч сургуулийнхаа менежментийн бүтцийг үндсэндээ хадгалж ирсэн нь бүтцийн суурийг анхнаас нь оновчтой шийдвэрлэсэнтэй холбоотой гэж үздэг.

Зураг 2



Зураг 3




ҮБТДС 2001, 2006 онд Боловсролын Магадлан Итгэмжлэлийн Үндэсний зөвлөлөөр байгууллагын магадлан итгэмжлэлд орж 2016 он хүртэл ахисан түвшинд магадлан итгэмжлэгдсэн юм.

Сургуулийн удирдлагын бүх шатанд шийдвэр гаргах, түүний хэрэгжилтийг үнэлж, дүгнэх үйл ажиллагаанд багш, ажилчин, суралцагчдын санал хүсэлтийг харгалзан тусгадаг байдал уламжлагдан чанартай явагдаж байна.

Сургуулийн дүрэм, журамд шийдвэр гаргах болон үнэлж дүгнэх үйл ажиллагаанд санал оруулах, ажлаа улирал, жилээр үнэлүүлж дүгнүүлэх, тайлагнах талаар тодорхой заалтууд байгаа нь олон нийтийн оролцооны эрх зүйн үндэс болно.

- Захирал бүрэн эрхийнхээ дагуу сургуулийн хэтийн болон өдөр тутмын үйл ажиллагааг удирдах бөгөөд өөрийн эрх мэдлийн хүрээний асуудлаар тушаал гаргана. Түүнчлэн захиргааны зөвлөлийг удирдан сургуулийн төсвийн төлөвлөлт, гүйцэтгэлд дүн шинжилгээ хийж дүгнэлт, шийдвэр гаргана.
- Захирлын дэргэд 7 хүний бүрэлдэхүүнтэй Захиргааны Зөвлөл ажиллах бөгөөд уг зөвлөл нь сургуулийн бүтэц, зохион байгуулалт, санхүүгийн үйл ажиллагааг зохицуулах дүрэм, хөдөлмөрийн дотоод журам, сургуулийн нэгжийн удирдлагын тайлан, ажлын үр дүнг хэлэлцэж санал, дүгнэлт гаргах үүрэгтэйгээр ажилладаг.
- Дэд захирал нь сургуулийн санхүүгийн үйл ажиллагаа, хүний нөөц, дотоод хяналтын асуудлаар дүн шинжилгээ хийж, хэрэгжилтэд хяналт тавих, шаардлагатай асуудлаар саналаа боловсруулан Захиргааны Зөвлөл, Захиралд мэдүүлэн шийдвэр гаргуулах эрх, үүрэгтэйгээр ажиллана.
- Эрдмийн зөвлөл нь сургуулийн сургалт, эрдэм шинжилгээний чиглэл тогтоох, түүний онол, арга зүйн түвшин, үр дүнг хэлэлцэж санал дүгнэлт, шийдвэр гаргаж биелэлтэд хяналт тавих үүрэгтэйгээр ажилладаг.
- Сургуулийн бакалавр, магистрын хөтөлбөрийг хэрэгжүүлэх бүхий л үйл ажиллагаа нь сургуулийн үндсэн нэгж болох сургалтын албанд төвлөрнө.
- Сургуулийн зохион байгуулалтын болон сургалтын үйл ажиллагааг хэрэгжүүлэх үндсэн нэгж нь тэнхим байна. Тэнхимийн эрхлэгчийг хамт олны саналыг үндэслэн захирлын тушаалаар томилно.
- Тус сургууль 3 тэнхимтэй, тэнхим бүр мэргэжлийн чиглэлийн танхим, заал бүхий материаллаг баазтайгаар үйл ажиллагаагаа явуулж байна. Тэнхим бүр судалгааны багтай.
- ҮБТДС нь өөрийн бүрэлдэхүүндээ спортын сургалттай ахлах сургуультай бөгөөд тус сургуулийн ерөнхий эрдмийн болон спортын сургалт, дасгалжуулалт нь БСШУС-ын яамнаас баталсан тусгай төлөвлөгөөгөөр явагддаг.
- Сургалтын алба, санхүү, хяналтын алба, ахлах сургууль, номын сан, сэтгүүлийн зөвлөл зэрэг нэгжийн удирдлага нь өөрийн хариуцсан нэгжийг өдөр тутмын удирдлагаар хангаж, хүлээсэн үүргийнхээ дагуу гүйцэтгэсэн ажил, үр дүн, хэрэгжилтийг Захиргааны Зөвлөлийн өмнө бүрэн хариуцна.



2.2. Захиргаа: Сургуулийн захиргаа нь эрхэм зорилго, зорилтуудыг хэрэгжүүлэхэд өдөр тутмын үйл ажиллагааг чиглүүлж, дэмжлэг үзүүлнэ. Салбар, нэгж, багш, ажилтнуудын багшлахуй, суралцахуйг дэмжин ажиллаж, тэдний сэтгэл ханамжийг дээшлүүлдэг байна.

ҮБТДС-ийн Удирдах Зөвлөлийн 2016 оны 6-р сарын 6-ны өдрийн тогтоолоор “ҮБТДС-ийн дүрэм”-ийг шинэчлэн баталж өөрийн үйл ажиллагаатай холбоотой дүрэм, журмуудыг боловсруулан зохих үүргийнх нь дагуу ажиллуулж байна.

Эдгээр дүрэм, журмууд нь сургуулийнхаа стратеги зорилтыг хэрэгжүүлэх, хамт олныхоо ажиллах, сурах бүх талын боломж нөхцлийг бүрдүүлэхэд чиглэж байдаг юм. Тухайлбал:

Удирдах Зөвлөл: Сургуулийн Удирдах Зөвлөлийн үйл ажиллагааны зорилго нь сургуулийг зохион байгуулалт, санхүү, материаллаг баазын хувьд бэхжүүлэх, мэргэжлийн хөтөлбөрийн шаардлагыг хангах, сургалтын төлбөрийн хэмжээг тогтоох, сургуулийн сургалт, эрдэм шинжилгээ, спорт, хүмүүжлийн ажлын хэтийн чиглэл, бодлого, стратегийг тодорхойлох, түүний хэрэгжилтэд хяналт тавих, захирлын үйл ажиллагаанд үнэлэлт дүгнэлт өгч, дэмжлэг, туслалцаа үзүүлэхэд оршино.

ҮБТДС-ийн дүрэм: ҮБТДС-ийн алсын хараа, эрхэм зорилго, уриа, үнэт зүйлс, сургалтын үйл ажиллагааны үндсэн чиглэл, удирдлага, зохион байгуулалт, сургуулийн стратеги зорилттой холбоотой харилцааг зохицуулахад дүрмийн зорилго оршино.

Сургуулийн Эрдмийн Зөвлөл нь сургуулийн дүрмийн хүрээнд сургалт-эрдэм шинжилгээний ажлын чиглэлийг тогтоож, түүний онол, арга зүйн түвшин, ач холбогдол, үр дүнг хэлэлцэж, санал, дүгнэлт гаргах зорилго бүхий хамтын удирдлагын нэгж мөн.

Захиргааны зөвлөл:

- Сургалт, судалгааны бодлого, хөтөлбөр, төлөвлөгөөний хэрэгжилтийг хэлэлцэж санал дүгнэлт гаргах,

- Сургуулийн бүтэц, зохион байгуулалт, орон тоо, цалин, нэмэгдэл урамшууллын хэмжээнд өөрчлөлт оруулах асуудлыг хэлэлцэж, санал, дүгнэлт гаргах,
- Дотоод журам, заавруудыг батлах, нэмэлт өөрчлөлт оруулах,
- Тэнхим, нэгжүүдийн тайлан ажлын үр дүнг хэлэлцэж, санал дүгнэлт гаргах,
- Төлөвлөгөөт ажлын хэрэгжилт, гүйцэтгэлийн хяналтыг зохион байгуулах,
- Багш, ажилтан, суралцагчийг төрийн дээд болон бусад шагналд нэр дэвшүүлэх, тодорхойлох чиг үүрэгтэй.

Захирал: ҮБТДС-ийн хөгжлийн ойрын болон хэтийн төлөвлөгөөг хэрэгжүүлэн, “Дээд боловсролын тухай хууль”, “Хөдөлмөрийн тухай хууль” болон бусад хууль тогтоомжид нийцүүлэн сургуулийн өдөр тутмын үйл ажиллагааг удирдан зохион байгуулах үндсэн чиг үүрэгтэй.

Дэд захирал: ҮБТДС-ийн эдийн засгийн үйл ажиллагаатай холбоотой бүхий л арга хэмжээг хэрэгжүүлэн сургуулийн хөрөнгө оруулалт, санхүүгийн эх үүсвэрийг нэмэгдүүлэх, төсөл, хөтөлбөр хэрэгжүүлж ажиллахаас гадна хүний нөөц, дотоод хяналт, гадаад харилцааны асуудлыг хариуцан зохион байгуулах, шийдвэрийг хэрэгжүүлэх үүрэгтэй.

Сургуулийн дотоод журам нь “Хөдөлмөрийн тухай хууль”, “Боловсролын тухай багц хууль”, бусад хууль тогтоомж, сургуулийн дүрмийн хүрээнд захиргаа, багш, ажилтан, оюутны хөдөлмөрийн харилцаа, байгууллагын дотоод үйл ажиллагааг зохицуулна.

“Багш, ажилтны ёс зүйн дүрэм”-ийн зорилго нь сургалтын үйл ажиллагааг хэрэгжүүлэх явцад багш, суралцагчдын хооронд үүсэх ёс суртахууны харилцааг зохицуулж, багшийг ёс зүйн зөрчлөөс сэргийлэх, мэргэжлийн нэр төрийг нь хамгаалахад оршино.


Чанарын дотоод баталгаажуулалтын алба нь сургуулийн стратеги зорилт, сургалтын стандарт, хөтөлбөрийн хэрэгжилтэд дотоод хяналт, хяналт-шинжилгээ хийх замаар чанарын үнэлгээ өгч баталгаажуулах үүрэгтэй.

ҮБТДС-ийн сургалт, эрдэм шинжилгээ, санхүү, хангалтын үйл ажиллагааг захирал, захиргааны зөвлөл, алба, тэнхимүүд, шат бүрдээ хариуцан сургуулийн дүрэм, дотоод журмыг мөрдлөг болгон захирлын төвлөрсөн удирдлага дор ажилладаг.

Захиргааны зөвлөл нь сургуулийн өдөр тутмын үйл ажиллагааг мэргэжлийн удирдлагаар хангах хамтын удирдлагын байгууллага бөгөөд бүрэлдэхүүндээ сургалтын албаны дарга, тэнхимийн эрхлэгчид, дотоод хяналт, чанарын баталгаажуулалтын албаны дарга, эмч, ахлах нягтлан бодогч нарыг оролцуулан тогтмол хуралдаж, сургуулийн сургалт-эрдэм шинжилгээ, эдийн засаг, материаллаг бааз, багшлах болон удирдах боловсон хүчний зэрэг бодлогын чанартай тулгамдсан чухал асуудлуудыг хэлэлцэн шийдвэрлэдэг.

Захиргааны зөвлөл нь сургуулийн хэв шинжид тохирсон бүтэц бүрэлдэхүүнтэйгээр үйл ажиллагаагаа явуулж байна.

Захиргааны Зөвлөлийн бүрэлдэхүүн




Захиргааны зөвлөл нь дараах үндсэн чиг үүрэгтэйгээр ажиллаж байна.

- Сургуулийн стратеги төлөвлөгөөг хэлэлцэх, хэрэгжилтийг хянаж, тодотгол хийх, зөвлөмж гаргах,
- Сургуулийн бүтэц, зохион байгуулалт, хүний нөөц, гадаад, дотоод хамтын ажиллагааны бодлогыг тодорхойлох,
- Мэргэжлийн шинэ хөтөлбөр, инноваци, хөрөнгө оруулалтын бодлого, төсөл дэвшүүлэх,
- Сургуулийн нэр хүнд, соёл, ёс зүйн хэм хэмжээний хэрэгжилтэд хяналт тавих,
- Удирдах албан тушаалтан, албадын дарга, тэнхимийн эрхлэгч нарын ажлын гүйцэтгэл, тайланг хэлэлцэнэ.

Сургуулийн удирдах зөвлөл, Эрдмийн зөвлөл нь хурлаасаа тогтоол гаргах, захирал нь тушаал, албан даалгавар, захиргааны зөвлөл протокол гаргаж дээрх шийдвэрүүдийн хэрэгжилтийг хангах, биелэлтэд хяналт тавих үүргийг эрх, үүрэг бүхий нэгжүүд хариуцна.

Захиргааны шийдвэр гаргах үйл явц



2.3. Хамтын ажиллагаа: Эрхэм зорилго, чиг үүргийн хэрэгжилтийг дэмжих, сайжруулах чиглэлээр дотоод ба гадаад хамтын ажиллагааг тууштай хэрэгжүүлдэг байна.

Монгол Улсад биеийн тамирын боловсрол, спортын шинжлэх ухааны сургалт, судалгааг дэлхийн жишигт хүргэх бодлогод суурилсан мэргэжилтэн бэлтгэх таатай орчин бүрдүүлэх нэг нөхцөл нь сургуулийн дотоод, гадаад хамтын ажиллагаа юм. Сургуулийн дотоод, гадаад хамтын ажиллагааг хөгжүүлэх үзэл баримтлал, зорилгыг сургуулийн дотоод дүрэмд тодорхой тусгаж өгсөн байгаа.

Дотоод, гадаад хамтын ажиллагааны чиглэл, хэлбэр, сонголтыг хийхэд Захиргааны зөвлөл, тэнхимүүд үндсэн үүрэгтэйгээр ажилладаг.

Сургуулийн дотоод, гадаад хамтын ажиллагаа нь сургалтын; эрдэм шинжилгээ, судалгааны; биеийн тамир, спортын салбарт хамтран ажиллах, мэргэжилтэн бэлтгэх; мэргэжил дээшлүүлэх гэсэн үндсэн чиглэлүүдээр хэрэгжиж байна.

Сургалтын хамтын ажиллагаа: Манай сургуулийн үндсэн үйл ажиллагаа нь танхимын сургалт ба үйлдвэрлэлийн дадлага гэсэн 2 хэлбэртэй. Тус сургуулийн онцлогоос хамааран үйлдвэрлэлийн дадлага нь багшлах дадлага, дасгалжуулалтын дадлага, биеийн тамир, эмчилгээнний арга зүйчийн буюу мэргэжлийн дадлага гэсэн хэлбэрээр явагддаг.

Дадлагын үндсэн түншлэгч буюу дэмжигч байгууллага нь ЕБС, эмнэлгийн анхан шатны болон аймаг, нийслэл, дүүргийн эмнэлгүүд, зэвсэгт хүчин, хүчний байгууллагуудын биеийн тамир, спортын нэгжүүд байдаг юм. Эдгээр байгууллагуудтай хамтын ажиллагааны (дадлага хийлгэх) гэрээтэй ажилладаг.

Дадлагын төрөл

- Багшлах дадлага
- Дасгалжуулалтын дадлага
- Биеийн тамир, эмчилгээний арга зүйчийн дадлага

Дадлага хийх байгууллагууд

- Хот, хөдөөгийн ерөнхий боловсролын сургуулиуд
- Спорт хороо, клуб, шигшээ баг
- Аймаг, дүүрэг, хотын нэгдсэн эмнэлгүүд, нөхөн сэргээлтийн төв, рашаан сувилал, хувийн эмнэлэг

Тус сургууль нь БНХАУ, БНСУ, Япон зэрэг орнуудтай оюутан, магистрант харилцан солилцон сургаж байна.

Эрдэм шинжилгээ, судалгааны хамтын ажиллагаа: Бид багш, оюутнуудаа үндэснийхээ их, дээд сургуулиуд болон ОХУ, БНХАУ, БНСУ, Япон зэрэг орнуудын их, дээд сургуулиудын магистрантур, докторантурт сургах, хамтарсан төсөл хэрэгжүүлэх хэлбэрээр хамтран ажиллаж байна. Тодруулбал: МУБИС, Хүмүүнлэгийн ухааны их Сургууль, АШУҮИС-ийн докторантурт манай багш нар эрдмийн зэрэг хамгаалж байна. Түүнчлэн ОХУ-ын Ломоносовын нэрэмжит Москвагийн Их сургуулийн докторантурт манай сургуулийн багш нар эрдмийн зэрэг хамгаалж байгаагаас гадна тус сургуулийн Антропологийн хүрээлэн, Японы хүүхдийн эрүүл мэндийн Үндэсний төв, Цукуба Их сургуультай хамтран төсөл хэрэгжүүлж байна.

Манай сургууль сургалт, эрдэм шинжилгээ, судалгаа, төсөлт ажлууд дээр төрийн ба төрийн бус байгууллагуудтай байнгын хамтын ажиллагаатай байдаг.

ҮБТДС-ийн хамтын ажиллагаатай төрийн ба төрийн бус байгууллагуудыг багцлан өгүүлье.

Хамтран ажилладаг төрийн байгууллагууд:

- БСШУСЯ, түүний харьяа Биеийн тамир, спортын хөгжлийн төв, Спортын эрдэм шинжилгээ, судалгааны төв, лабораториуд, аймаг, нийслэл, дүүргүүдийн Биеийн тамир, спортын газрууд, спортын төрөлжсөн сургалттай дунд сургуулиуд, аймаг, нийслэлийн боловсролын газрууд, Ерөнхий боловсролын дунд сургуулиуд,

- Эрүүл мэндийн яам, түүний харьяа улсын нэгдсэн эмнэлгүүд, аймгийн нэгдсэн эмнэлгүүд, төв орон нутгийн амралт сувиллын газрууд,
- Шинжлэх ухааны академи, эрдэм шинжилгээний хүрээлэнгүүд, Шинжлэх ухаан, технологийн сан

Хамтран ажилладаг төрийн бус байгууллагууд:

- Монголын үндэсний олимпын хороо
- Монголын паралимпын хороо
- Монголын үндэсний олимпын академи
- Оюутны спортын холбоо
- Спортын шинжлэх ухаан, биеийн тамирын боловсролын холбоо
- Спортын төрөлжсэн холбоо, шигшээ баг, хороо, клубууд
- Монголын оюутны холбоо
- Спортын ивээн тэтгэгч байгууллага, компаниуд, ажил олгогч байгууллагууд
- Төгсөгчдийн холбоо, бусад олон нийтийн санаачлагын байгууллагууд зэрэг болно.


2.4. Эрх зүйн зохицуулалт: Сургууль нь бүх нэгж, хамт олон, хувь хүн бүрийн оюуны болон академик эрх чөлөөг хангасан, мэргэжлийн ёс зүй ба шинжлэх ухааны судалгаа, боловсролын үйл ажиллагааны нийтлэг хэм хэмжээнд тулгуурласан, сахилга, хариуцлага, аюулгүй байдлын горимыг тогтоон тодорхойлсон эрх зүйн зохицуулалттай, мөн тодорхой хугацаанд нээлттэй хянан сайжруулдаг байна.

“Боловсролын тухай хууль”, “Дээд боловсролын тухай хууль”, Дээд боловсролын талаар, түүний дотроос биеийн тамир, спортын талаар төрөөс баримтлах бодлого, эдгээр хууль, бодлоготой холбогдуулан боловсролын болон биеийн тамир, спортын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас гаргаж байгаа тогтоол, шийдвэрүүд нь сургуулийн хэмжээнд зайлшгүй байх бодлого, эрх зүйн зохицуулалтын баримт бичгүүдийг боловсруулах үндэс болдог юм.

Бид эдгээр баримт бичгүүдийг боловсруулах, бүрдэл болгохдоо, сургуулийн онцлог, хамт олны саналыг үндэслэн Удирдах зөвлөл, Эрдмийн зөвлөл, Захиргааны зөвлөл, тэнхим, олон нийтийн байгууллага, хамт олноор хэлэлцүүлж эцсийн шийдвэр гаргах зарчмыг баримталдаг.

Ийм зарчмаар боловсруулан хүчин төгөлдөр мөрдөж байгаа 30 гаруй дүрэм, журам байна. Эдгээрийг “Албан хөтөч” (шийдвэр, дүрэм, журам) нэрээр тусгайлан эмхэтгэсэн болно. Боловсруулалтын хувьд тухайн үеийн хууль, дүрэм, журмын заалтууд хүчин төгөлдөр үйлчилж байгаа нөхцөлд тэдгээрт нийцсэн байна. Нэмэлт өөрчлөлт оруулахдаа тухайн цаг үеийн орчин нөхцөлтэй уялдуулдаг.

Зураг 7.



Зургаас харахад ҮБТДС-ийн “Засаглал”, “Хамтын ажиллагаа” зэрэг дэд шалгуурууд **3,74 - 3,79** гэсэн өндөр үнэлгээг авсан бол “Эрх зүйн зохицуулалт”, “Зохион байгуулалт” шалгуурт **3,53** гэсэн үнэлгээг өгсөн байна. Эрх зүйн зохицуулалт, зохион байгуулалт зэргийг дээшлүүлэхэд багш нараас дараах санал гаргасан байна. Үүнд: Багш нарын ажлын ачаалал харилцан адилгүй байна, цөөн цагтай багш нарт нэмэлт ажил даалгах, багш нарыг үнэлэх шалгуурыг сайжруулах, эрх зүйн бичиг баримтыг сайжруулах, өөрчлөлт гарсан тохиолдолд цаг тухайд нь мэдэгдэх, удирдлагын системийн дотоод сүлжээг сайжруулах зэрэг санал гарчээ.

Хүснэгт 5

SWOT шинжилгээ

Давуу тал:	Сул тал:
<ul style="list-style-type: none"> • Холбогдох хууль, дүрэм журамд нийцсэн дээд боловсролын сургалт, эрдэм шинжилгээ, спортын үйл ажиллагааг явуулах хууль, эрх зүйн орчинг сургуульдаа бүрдүүлж чадсан. • Сургуулийн үйл ажиллагааг удирдан зохион байгуулах чадварлаг менежментийн баг, менежментийн бүтцийг бүрдүүлсэн. • Гадаадын их, дээд сургуулиудтай хамтын ажиллагааны гэрээ байгуулсан. 	<ul style="list-style-type: none"> • Дэлхийн улс орнуудын ижил төстэй дээд сургуулиудын чиг хандлага, дотоодын нийгэм эдийн засгийн өөрчлөлтийг сургуулийн дүрэм журамдаа нэмэлт өөрчлөлт оруулахгүй байх • Сургуулийн сургалт, эрдэм шинжилгээ, спортын дүрэм, журмын боловсруулалт буюу хууль эрх зүйн зохицуулалтын баримт бичгийн боловсруулалт сайн бүрдсэн хэдий ч зарим тохиолдолд мөрдөгдөхгүй байна.

<ul style="list-style-type: none"> • Спортын үйл ажиллагаа эрхэлдэг дотоод байгууллагуудтай өрсөлдөх биш, хамтран ажиллах зарчмаар ажилладаг. 	
<p>Боломж:</p> <ul style="list-style-type: none"> • Сургууль нь байгууллагын магадлан итгэмжлэлд урьд нь орж байсан туршлагатай. • Өөрийн бүрэлдэхүүндээ спортын сургалттай ахлах сургуультай тул дээд боловсролын сургалтаараа залгамж холбоог бүрдүүлэх боломжтой. • Сургуулийн бэхжүүлж чадсан хамтын ажиллагаатай гадаадын их, дээд сургуультай хамтран эрдэм шинжилгээний хурал зохион байгуулах, багш, оюутныг гадаадын их, дээд сургууль руу богино хугацаагаар илгээх замаар судалгаа, шинжилгээний ажлыг дэмжих боломжтой. 	<p>Эрсдэл:</p> <ul style="list-style-type: none"> • Ижил төрлийн сургалтын үйл ажиллагаа явуулж буй өрсөлдөгч сургуулийн тоо нэмэгдэж байгаа • Сургуульд сайн засаглалыг бэхжүүлэхэд багш нарын оролцоо дутмаг • Чанарын дотоод баталгаажуулалтын алба байгуулагдсан сайн талтай боловч хараат бус, бие даасан үйл ажиллагаа явуулахгүй, зөвхөн дээрээс өгсөн зааврын дагуу ажилладаг.

ШАЛГУУР 3. СУРГАЛТЫН ХӨТӨЛБӨРИЙН УДИРДЛАГА

Сургууль нь үндэсний болон олон улсын стандарт, мөн хөдөлмөрийн зах зээлийн шаардлагад нийцсэн сургалтын хөтөлбөрийг боловсруулан хэрэгжүүлж, чанартай үйлчилгээ үзүүлдэг байна.

3.1 Үйл ажиллагааны журам, үүрэг хариуцлага: *Сургууль нь сургалтын хөтөлбөрийг боловсруулах, баталгаажуулах, хэрэгжүүлэх явц, үр дүнг хянах, үнэлэх, чанарыг баталгаажуулах бодлого, эрх зүйн зохицуулалтыг хариуцсан хороодыг байгуулж хөтөлбөрийн багуудын ажлын уялдааг хангаж, удирдан зохион байгуулдаг.*

Тус сургууль нь 2013-2014 оны хичээлийн жилийг хүртэл, 10 мэргэжлийн индекс, хөтөлбөрийг мөрдөж, сургалтын үйл ажиллагааг явуулж ирсэн. “Мэргэжлийн чиглэл, индекс шинэчлэн батлах тухай” Боловсрол, соёл шинжлэх ухааны яамны сайдын тушаал (2014 он, №А/78) гарсантай холбогдуулан бид сургуулийнхаа хэв шинж, уламжлал, залгамж чанар, биеийн тамир, спортын салбарын мэргэжлийн хэтийн хэрэгцээ, шаардлагыг харгалзан 2014-2015 оны хичээлийн жилээс үйл ажиллагаандаа дараах мэргэжлийн хөтөлбөр, индексийг шинээр хэрэгжүүлэн ажиллаж байна. Үүнд:

Хүснэгт 6.

Мэргэжлийн хөтөлбөр, индекс


№	Сургалтын хөтөлбөр	Хөтөлбөрийн индекс	Сургалтын агуулгын багтаамж /Багц цаг/	Төгсөгчдөд олгох боловсролын зэрэг	Хэдэн оноос хэрэгжүүлж эхэлсэн
1	Багш, биеийн тамирын боловсрол /өдөр, эчнээ/	011410	120 кр	Бакалавр	1991 он
2	Менежмент	041302	120 кр	Бакалавр	ШУБ-ын сайдын тушаал 1996.03.09
3	Аялал жуулчлалын менежмент	041304	120 кр	Бакалавр	ШУБ-ын сайдын тушаал 1996.03.09
4	Спортын дасгалжуулагч	101401	120 кр	Бакалавр	1991 он
5	Биеийн тамирын арга зүйч	101401	120 кр	Бакалавр	Гэгээрэл, Сангийн сайдын тушаал 1997он, БСШУ-ны сайдын 2011 он

6	Багш, биеийн тамирын боловсрол	E01141001	30 кр	Магистр	БСШУЯ-ны сайдын тушаал 2002.07.01
7	Спортын дасгалжуулагч	E10140101	30 кр	Магистр	БСШУЯ-ны сайдын тушаал 2008.03.27
Хөрвөх сургалт					
8	Багш, биеийн тамирын боловсрол	011410	30 кр	Бакалавр	2017 он

Хөтөлбөрийн баг, зохицуулагчдын чиг үүргийн оновчтой байдал, хэрэгжилтийн түвшин

Хөтөлбөрийн багийн үндсэн үүрэг нь тэнхимүүдээр дамжуулан хөтөлбөрийн бүрэлдэхүүний иж бүрдлийг хангуулах, хамгийн чухал нь сургалтын төлөвлөгөө, хичээлийн хөтөлбөрийг тэргүүн ээлжинд шинжлэх ухааны үндэслэлтэй боловсруулахад чиглэгдэнэ. Энэ шаардлагыг хангасан сургалтын төлөвлөгөө, хичээлийн хөтөлбөрийг эхний ээлжинд мэргэжлийн багш нарын оролцоотойгоор дэд хороод тэнхимийн хэмжээнд боловсруулан Хөтөлбөрийн Хороогоор /“Хөтөлбөрийн баг”-аар/ хянуулан, мэргэжлийн зөвлөгөө өгөх эрдэмтдийн бүлгийн саналыг тусган боловсруулав.


Зураг 8



	<p>тамирын боловсрол”, “Менежмент”, “Аялал жуулчлалын менежмент”, “Спортын дасгалжуулагч”, “Биеийн тамирын арга зүйч хөтөлбөрүүдээр “Сургалтын төлөвлөгөө”-нүүдийг боловсруулж эрдмийн зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн захирлын 2014 оны 08-р сарын 25-ны 19 тоот тушаалаар баталж, тус хичээлийн жилээс мөрдөн ажиллаж байна.</p>	
<p>Хөтөлбөрийн Хороо-9 хүний /төлөөллийн/ бүрэлдэхүүнтэй</p> <p>1.Хөтөлбөрийн Хорооны дарга-ҮБТДС-ийн захирал</p> <p>2.Даргын туслах-Хөтөлбөрийн албаны дарга</p> <p>Гишүүд:</p> <p>1.ЭЗ-ийн төлөөлөл-Эрдэмтэн н/б-ийн дарга</p> <p>2.СА-ны төлөөлөл-Сургалтын албаны дарга</p> <p>3.ЧДБА-ны төлөөлөл-Чанарын дотоод баталгаажуулалтын албаны дарга</p> <p>4.ОАЗТ-ийн эрхлэгч</p> <p>5.ҮСМТ-ийн эрхлэгч</p> <p>6. БТЭАЗТ-ийн эрхлэгч</p> <p>7.Төгсөгчийн төлөөлөл</p>	<p><u>Дэд хороод</u></p> <p>1. ОАЗТ-ийн дэд хороо</p> <p>2. ҮСМТ-ийн дэд хороо</p> <p>3. БТЭАЗТ-ийн дэд хороо</p>	<p>Бакалаврын боловсрол- МХБ</p> <p>1. Багш,биеийн тамирын боловсролын МХБ</p> <p>2. Спортын дасгалжуулагчийн МХБ</p> <p>3. Биеийн тамирын арга зүйчийн МХБ</p> <p>4. Аялал, жуулчлал, Спортын менежментийн МХБ</p> <p>Магистрын боловсрол- МХБ</p> <p>1. Багш,биеийн тамирын боловсролын МХБ</p> <p>.Спортын дасгалжуулагчийн МХБ</p>



Хөтөлбөр боловсруулах, баталгаажуулах, хэрэгжүүлэх, хянах, сайжруулах үйл явцын мөчлөг:



Хөтөлбөрийн чанарын үнэлгээ, дотоод баталгаажуулалтын тогтолцооны төлөвшил, үйл ажиллагааны үр дүнгийн түвшин

Хөтөлбөрийн чанарын баталгаажилт:

Хөтөлбөрийн хэрэгжилт, чанар, үр дүнг хөтөлбөрийн хороо хагас жил тутам үнэлж, сургуульдаа тайлагнаж байна. Энэхүү үнэлгээний хүрээнд доорх чиглэлээр судалгаа хийж, дүгнэн шинжилнэ. Үүнд:

- Сэтгэл ханамжийн үнэлгээ /оюутан, төгсөгчдөөс/
- Явцын үнэлгээ /оюутны ахиц дэвшилд үе шаттай хийх/
- Гүйцэтгэлийн үнэлгээ /ажил олгогч, мэргэжлийн хөндлөнгийн үнэлгээ/
- Үр нөлөөний үнэлгээ / мэргэжлийн салбар дахь нөлөөллийн үнэлгээ/
- Хөтөлбөрийн санхүүгийн байдлын шинжилгээ үнэлгээ
- Хөтөлбөрийн чанарын үнэлгээ

Судалгааны үндсэн дээр магистр, бакалавр, Спортын дасгалжуулагч, Биеийн тамирын багш, Биеийн тамирын арга зүйч бэлтгэх сургалтын хөтөлбөр хоорондын уялдаа холбоосын зураглалыг гаргах, БТС-ын салбарын хүний нөөцийг тасралтгүй хөгжүүлэх систем бий болгоно.

Хичээлийн хөтөлбөрийн агуулга, бүтэц, дэс дараалал, хичээл хоорондын холбоосын зураглал гаргана. Хичээлийн хөтөлбөрийг дүгнэж, ололт амжилт, алдаа дутагдалд дүн шинжилгээ хийх байдлаар хөтөлбөрийг чанаржуулна.

Тэнхимүүд хөтөлбөрийн хэрэгжих үйл явцыг байнга хянаж, дүгнэн шинжлэх ба чанарын дотоод баталгаажуулалтын баг улирал бүрд үнэлгээ хийж, хөтөлбөрийн хороодын хамтарсан хурлаар үр дүн, ололт дутагдлыг хэлэлцэн, цаашдын төлөвлөгөөнд тусган ажилдаа бүтээлчээр хэрэгжүүлнэ.

ҮБТДС нь хичээлийн жилийн эхэн болон төгсгөлд хийдэг сургалт арга зүйн тайлангийн хурлаар багш бүр зааж буй хичээлдээ анализ хийн хичээлийн үр дүнг хэлэлцэж, ирэх хичээлийн жилийнхээ зорилго, зорилтоо тодорхойлдог.

3.2 Хөтөлбөрийн зорилт, агуулга

Сургалтын хөтөлбөрүүд нь суралцагчдыг үндэсний болоод олон улсын стандартад нийцсэн боловсрол эзэмших, бүтээлч сэтгэлгээтэй, хариуцлагатай, насан туршдаа суралцан хөрвөх чадвартай мэргэжилтэн болж төлөвших зорилгыг хангах цогц үйлчилгээ үзүүлэхэд чиглэсэн байна.

Хөтөлбөрүүдийн хэрэгжилтийн талаарх олон нийтийн үнэлгээний түвшин

Бид хөтөлбөрүүдийн талаарх олон нийтийн үнэлгээ /судалгааг/ сургуулийнхаа хамт олны, төгсөгчдийн, суралцагчдын гэсэн гурван үндсэн чиглэлээр явуулсан бөгөөд 4 баллын үнэлгээгээр авч үзвэл хамт олны болон суралцагчдын үнэлгээ 3.61-3,67 байна. /Зураг 9/

ҮБТДС-ийн сургалтын хөтөлбөрийг БСШУЯ-ны А/78, А/52, А/370 тоот тушаалуудын дагуу өөрчлөн шинэчилсэн байдал	
2014 оноос өмнө	2014 оноос хойш
1. Биеийн тамир, спортын 6 мэргэжлээр батлагдсан төлөвлөгөөний дагуу шаардлагатай мэргэжилтэнг бэлтгэж байна.	1. БСШУЯ-ны сайдын 2014 оны 3 дугаар сарын 13-ны өдрийн А-78 тоот тушаалаар 5 мэргэжлээр элсэлт авч, сургах тусгай зөвшөөрөл авав.
2. Сургалтын төлөвлөгөөнд Ерөнхий суурь хичээл-30%, Мэргэжлийн суурь хичээл-30%, Мэргэшүүлэх хичээл-40% гэсэн харьцаатай байсан.	2. БСШУЯ-ны сайдын 2014 оны 9 дүгээр сарын 12-ны өдрийн А-370 тоот тушаалаар 2 мэргэжлээр элсэлт авч, Магистрын сургалт эрхлэх тусгай зөвшөөрөл авав.
3. БТС-ын салбарт хүний нөөц, мэргэжилтний хэрэгцээ их шаардлагатай байсан тул элсэгчдийн тоонд хязгаарлалт хийдэггүй байсан.	3. БСШУЯ-ны сайдын 2017 оны 6 дугаар сарын 29-ны өдрийн А-52 тоот тушаалаар Биеийн тамирын арга зүйч мэргэжлээр элсэлт авч, сургах тусгай зөвшөөрөл авав.
	4. МУ-ын ЗГ-ын тогтоолоор Хөрвөх сургалтыг эрхлэх зөвшөөрөл авав. /2014.09.03/
	5. Шинэ багц хөтөлбөрт шилжсэнээр сургалтын 8 багц хөтөлбөрийг сайжруулж шинэчлэн боловсруулж мөрдөж байна.
	6. Шинэ багц хөтөлбөрт шилжсэнээр сургалтын хөтөлбөр: Ерөнхий суурь хичээл-32%, Мэргэжлийн суурь хичээл-28%, Мэргэшүүлэх хичээл-40% гэсэн харьцаатай болсон.
	7. БСШУЯ-ны сайдын 2014 оны А-78 тоот тушаалаар мэргэжлийн чиглэл, индексийг шинэчлэн, хөтөлбөрийг шинэчлэн боловсруулсан. /2014.03.13/
	8. ЗГ-ын хэрэгжүүлэгч агентлаг, БТСГ-ын, БСШУЯ, Нийслэлийн Боловсролын Газрын хүний нөөцийн бодлоготой уялдуулан мэргэжилтэн бэлтгэх бодлогыг баримталж байна.

БСШУЯ-ны сайдын 2014 оны А/174 тоот тушаалын 2.8-д: Төгсөгчдийн эзэмших ур чадварыг “Хувь хүний болон мэргэжлийн ур чадвар, дадал төлөвшилт /5 чадвар”, “Хүмүүстэй харилцах чадвар /3 чадвар /, “Мэргэжлийн хичээлээр эзэмших мэдлэг, чадвар /сургууль тодорхойлно/” гэж тодорхойлдог. Төгсөгчдийн ур чадвар дараах байдлаар илэрхийлэгдэнэ.

БТС-ын мэргэжлийн бакалавр зэрэгтэй төгссөн, Биеийн тамир, Спорт, Боловсролын салбарын ажилтны нийтлэг үүрэг гүйцэтгэх чадвартай мэргэжилтэн байна.

Төгсөгч нь дараах ур чадвар, чадамж эзэмшсэн байна.

- Суралцагчийн нас сэтгэхүй, бодит орчин нөхцөлд тохирсон сургалтын арга барил, арга технологийг ашиглах;
- Хүүхдийг таньж мэдэх, сурах хэрэгцээ, спортын сонирхол, авьяасыг нь судлах;
- Сургалтын өөр өөр орчинд суралцагчийн сурах үйл ажиллагааг дэмжих;

- Суралцагчдыг ялгаварлан гадуурхахгүйгээр хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийг тэгш хамруулан сургах;
- Сургалтыг бие хүний үнэт зүйлсийг төлөвшүүлэхтэй хослуулах;
- Сургалтын явцад суралцагчийн эрүүл мэндийг хамгаалах, тэднээр техникийн аюулгүй байдал, гал түймрээс хамгаалах дүрмийг сахиулах;
- Дасгал гүйцэтгэх үед бэртэл гэмтлээс урьдчилан сэргийлэх, дасгал хийх дүрэм журмыг сахиулах;
- Биеийн тамирын дасгал хөдөлгөөн, байгалийн хүчин зүйл /нар, ус, агаар/-ийг ашиглан хүний бие бялдрыг чийрэгжүүлэн хөгжүүлэх, бие махбодын эрхтэн системийн үйл ажиллагааны байдлыг зөв тодорхойлж эмгэг, согог, өвчлөлийн байдалд нь тохируулан биеийн тамирын дасгал хөдөлгөөнөөр эрүүлжүүлэх;
- Эрүүл мэндийн доголдолтой сурагчид, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн сургалт, хүмүүжлийн ажлыг удирдан зохион байгуулах, тэдний дунд тэмцээн уралдаан зохион байгуулах, шүүх чадвартай байх;
- Биеийн тамирын хичээлээр дамжуулан спортын авьяастай суралцагчийн эцэг эхтэй холбоо тогтоох, тэдэнд гэр бүлийн зүгээс туслах;
- Хичээлээс гадуурх уралдаан тэмцээн сургалт - хүмүүжлийн ажлыг төлөвлөх, удирдах;
- Анги удирдах /ангид хичээл заах/ үйл ажиллагааг хэрэгжүүлэх;
- Ангийн баримт бичиг /журнал, хувийн хэрэг, ажиглалт, тэмдэглэл, мэдээ/ хөтлөх;
- Сургалт заах аргын нэгдэл болон заах аргын бусад хэлбэрийн үйл ажиллагаанд оролцох, бусад багш нартай хамтран ажиллах;
- Багшийн мэргэжлийн ёс зүйн шаардлагыг эрхэмлэн сахиж, биелүүлэх;
- Боловсролын стандарт хөтөлбөрийн дагуу суралцагчдад заах хичээлийнхээ бичиг үсгийн боловсролыг бүрэн эзэмшсэн;
- Хичээлдээ суралцагчийн хөгжлийг бодитой үнэлэх орчин үеийн аргыг хэрэглэх;
- Мэдээлэл харилцааны технологийг хэрэглэж хичээлээ явуулах;
- Биеийн тамирын багш нь командлах ур чадвартай дуу хоолой чанга, команд өгөхдөө тодорхой зөв хэмнэлтэй, бие бялдрын гадаад үзэмждээ байнга анхаарах, дасгал хөдөлгөөнийг хүүхдэд ойлгомжтой байдлаар тайлбарладаг, техникийн хувьд өөрийн биеэр зөв гүйцэтгэх.

3.3. Багшлахуйн арга зүй ба ажлын ачаалал:

Сургалтын технологи нь суралцагчдын суралцах үйлийг тэдний бүтээлч үйл ажиллагаанд тулгуурлан, сурч боловсрохын зүй тогтлын дагуу зохион байгуулах, бие даан ажиллах боломжийг бүрдүүлэхэд чиглэсэн байна.

Мэргэжлийн талаар:

- Философи сэтгэлгээний шинжлэх ухаан, танин мэдэхүйн асуудлууд, үндсэн ойлголт, арга зүйн хандлагуудыг өнөөгийн байгаль, нийгмийн танин мэдэхүйн

ээдрээтэй үзэгдлүүдтэй холбон орчин үеийн онол, практикийн түвшинд тайлбарлах мэдлэг, чадвар, дадлага, судалгааны материалтай байх

Заах арга зүй

1. Шинжлэх ухааны судалгааны аргазүйн гол үзэл баримтлал болон үндсэн асуудлуудыг судлах чиг хандлага
2. Шинжлэх ухааны судалгааны арга зүйн үүсэл, мөн чанар, гүйцэтгэх үүрэг, түүхийн асуудлууд, ахуй, танин мэдэхүй, хүн, нийгэм, нийгмийн оюун санааны амьдрал зэрэг үндсэн асуудлуудаас судлах арга зүй
3. Энэхүү хөтөлбөрт заасан эх зохиолуудыг бие даалган судлуулах арга барил
4. Хөтөлбөрт томьёолсон сэдвүүдээр бие даасан ажил, илтгэл бэлтгэж, семинар ярилцлага хийх арга зүй
5. “Шинжлэх ухааны судалгааны арга зүй” хичээлийн агуулга, заах арга зүйд гарч байгаа өөрчлөлтүүдийг мэдэрч, үйл ажиллагаандаа шинэчлэл хийх, боловсронгуй болгох арга барил
6. Сургалтын идэвхтэй ба хөгжүүлэх аргууд
7. Төсөлд суурилсан арга
8. Магистрын мэдлэг болон лекцээр олж авсан мэдээлэлд тулгуурлан философийн онол, арга зүйн мэдлэг бүтээх үйл явцыг удирдаж чаддаг байх
9. Багш магистрантуудтай хамтран жижиг, дунд бүлэг болж багаар ажиллаж хэвших
10. Мэдээлэл түгээх болон оролцооны идэвхтэй аргуудын зохих мэдлэг, дадалтай байх.

Бусад

- Сургалтын материал, /сурах бичиг, холбогдох ном зохиол, лекцийн тэмдэглэл, бүдүүвчилсэн товч, семинарын сэдэв/-ийг шинэлэг хэлбэрээр бэлтгэх, тэдгээрийг ашиглах аргыг магистрантуудаар бие даалган ажиллуулах арга барил
- магиструудад зориулсан тодорхой, энгийн хялбарчилсан гарын авлага, бүтээл, цуглуулсан материалууд
- Хичээлээр олсон мэдлэг, чадварыг үнэлэх зохистой шалгуурууд сонгон авч магистр нэг бүрийг бодитой үнэлэх арга зүй зэрэг болно.

Багшлахуй болон суралцахуйн үйл ажиллагааг хянаж, дүн шинжилгээ хийж, чанаржуулж буй ажлууд

Хүснэгт 8

№	Багшлахуй	Суралцахуй
1	Багш нар сургалтын үйл ажиллагааг жигд чанартай явуулахын тулд харилцааны соёл, сэтгэл зүйн боловсролоо байнга дээшлүүлнэ. Сургалтын алба хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд багш бэлэн байгаа эсэхийг улирал тутамд дүгнэж, заавар зөвлөгөө өгнө.	Оюутан сургалтын олон талт үйл ажиллагаанд нэгэн жигд, үр бүтээлтэй оролцохын тулд бие болоод сэтгэлзүйн бэлтгэлтэй байж, сургалтын төлбөр тооцоог цаг хугацаанд нь төлж, цаг ашиглалт сайтай, суралцах нөхцөл боломжоор бүрэн хангагдсан байх зайлшгүй шаардлагатай.
2	Багш бүр нээлтэй болон үзүүлэх хичээлийг улиралд 1 удаа заана. Уг	Оюутан улирлын явцад мэдлэг чадвар, дадлын үнэлгээнд сорилын 30 оноо,

	хичээлд сургуулийн удирдлага, сургалтын албаны төлөөлөл, тухайн цаг дээр хичээлд сууж, сургах-сурах 2 талын үйлийн онол арга зүй, ур чадварт дүн шинжилгээ хийж, үнэлгээ өгнө. Энэ хичээлд сууснаар хичээл хоорондын уялдаа сайжирч, заах арга зүй, багшлах ур чадвар нэмэгдэж, багш нар харилцан туршлага солилцох боломж нээгдэх ач холбогдолтой.	явцын 30 оноо, шалгалтын 40 оноо цуглуулж, үнэлгээний голч дүнг тооцуулна. Голч дүн нь нийт суралцах хугацааны үнэлгээ бөгөөд дипломын хавсралтад бичигдэж баталгаажна. Иймд оюутан улирал бүрд голч дүнтэйгээ танилцаж, зөвшөөрдөг журамтай.
3	ҮБТДС-ийн захирлын шийдвэрээр залуу багшийг дадлага туршлагатай ахмад багштай хамтран ажиллах нөхцөлийг бүрдүүлэн богино хугацаанд чадваржуулах үр өгөөжтэй ажил зохион явуулдаг.	Оюутанд суралцах хугацаандаа ухамсартай, хариуцлагатай сурахыг даалган “Сургуулийн удирдлага-багшийн удирдлага-өөрийн удирдлага” гэсэн гурвалсан гэрээ байгуулдаг бөгөөд энэхүү гэрээ нь төгсөх хүртэл хүчин төгөлдөр байдаг.
4	Хичээлийн жилд багш нарт эрдмийн зэрэг, цолоо ахиулах, санхүүгийн болон бусад дэмжлэг үзүүлэх зэргээр ажил, амьдралд нь бодит туслалцаа үзүүлдэг. Мөн багш нарын мэргэжил дээшлүүлэх төрөл бүрийн сургалтыг ажлын байранд нь зохион байгуулдаг.	Оюутанд тэнхимийн сургалтаар тусгай мэргэжил эзэмшүүлэхийн зэрэгцээ, тэднийг зөв эерэг хандлагатай өв тэгш хүмүүжилтэй үндэсний сэхээтэн болгох чухал зорилгын үүднээс мэтгэлцээн, илтгэх урлаг бусад танин мэдэхүй, соён гэгээрэхүйн ач холбогдолтой клубүүд, сургалт, уулзалт, ярилцлагыг оюутан хариуцсан багш төлөвлөн явуулдаг.
5	БТС-ын байгууллагуудын Хүний нөөцийн албатай хамтран багш нарыг үйлдвэрлэл дээр ажиллуулах, өөрийн болон гадны хөрөнгө оруулалт бүхий хамтарсан төсөл судалгаанд оролцуулах, технологийн дэвшил, шинжилгээ судалгааны ажилд суралцуулах, мэргэшсэн, зөвлөх багшийн сургалтад суулгах, гадаад, дотоодын мэргэжил дээшлүүлэх сургалтад урт богино хугацаагаар явуулах зэрэг олон талт ажлыг тогтмол зохиож байна.	Оюутны суралцах хугацаанд танилцах, багшлах болон дасгалжуулалтын дадлагыг ҮБТДС-ийн захирлын тушаалаар ЕБС, Спорт клуб, БТС-ын байгууллага, нэгжүүд дээр хуваарилагдан хийдэг. Төгсөгчдийн улсын болон диплом хамгаалах шалгалтад сургуулийн удирдлага, тэнхимийн багш нар мөн БСШУСЯ, БТСГ-ын, байгууллагуудын мэргэжилтэн нарын хамтарсан комисс суудаг.

3.4. Оюутны үнэлгээ

“Оюутны үнэлгээ” ажлын хүрээнд хөтөлбөр хэрэгжүүлж байгаа багш нарын сургалтын арга зүй, хичээлийн агуулга, үр дүнгийн талаар суралцагч оюутнуудаар дүгнүүлдэг болж эхэлсэн.

Оюутан суралцагчдын мэдлэгийг үнэлэхдээ:

БСШУЯ-ны сайдын 2003 оны 158-р тушаалын “Дээд боловсролын зэрэг олгох сургалтад багц (кредит) цагийг хэрэглэх, суралцагчдын мэдлэг, чадварыг дүгнэх

журам"-ыг үндэслэн ҮБТДС-ийн багш, оюутны мэдлэг чадварыг доорх хүснэгтийн дагуу үнэлнэ. Улирал бүрийн эцэст голч оноог гаргана.

Хүснэгт 9

Оноо (рейтинг)	Үсгэн үнэлгээ	Үнэлгээний оноо
90-100	A	4.0
80-89	B	3.0
70- 79	C	2.0
60-69	D	1.0
00-59	F	0.0

Суралцагчдын бие даан суралцах чадварын төлөвшилт

- Бие даалтын цагийг хичээлийн хуваарьт тусгаж өгснөөр багш оюутны харилцаа, хамтран ажиллах нөхцөл, боломж нэмэгдэж, ирц идэвх сайжран, эвсэг хамт олон бүрэлдэж, сурлагын чанар ахих зэрэг эерэг сайн нөлөө үзүүлж байна.
- Бие даан суралцах чадвараа дээшлүүлэн, уралдаан тэмцээн, эрдэм шинжилгээ онол практикийн хурал, төсөл хөтөлбөрт идэвх чармайлттай сайн оролцсон 4.0-оос дээш голч дүнтэй оюутнуудад /Шилдэг оюутан сурагчдыг шалгаруулах журмын дагуу/ мөнгөн урамшуулал олгох ажлыг төлөвлөж байна.
Энэ нь амжилтыг нь баталгаажуулан, улам сайн сурах урам зориг өгнө гэж тооцож байна.

3.5. Төгсөлтийн баримт бичиг

Бакалаврын зэргийн төгсөлтийн шалгалтаа амжилттай өгсөн оюутанд ҮБТДС-ийн төгсөлтийн шалгалтын комиссын шийдвэрийг үндэслэн захирлын тушаалаар мэргэжил, боловсролын зэрэг, түүнийг гэрчлэх диплом, энгэрийн тэмдэг олгоно. Тухайн зэргийн диплом нь төгсөлтийн шалгалтын комиссын даргын гарын үсэг, ҮБТДС-ийн тамгаар баталгаажих ба дугаар, болон бүртгэлийн дугаартай байна. Мөн диплом нь хавсралттай байх ба хавсралтад суралцсан хугацаанд судалсан хичээлүүд тэдгээрийн кредит цаг, голч дүнг бичсэн байна. Хавсралт нь баталгаажсан байна. Дээд боловсролын зэргийг зөвхөн сургалт явуулах тусгай зөвшөөрөлд тусгайлан заагдсан тухайн мэргэжлээр олгоно.

Төгсөгчдийн тухай мэдээллийг заасан хугацаанд боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлнэ.

Магистрын зэргийн болзол хангасан суралцагчийг төгсөлтийн комиссын шийдвэрийг үндэслэн захирлын тушаалаар тухайн зэргээр сургуулиа төгссөнийг баталгаажуулан мэргэжил, боловсролын зэрэг хүртээн, түүнийг гэрчлэх баримт нотолгоо болох диплом, энгэрийн тэмдэг олгоно.

Магистрын зэргийн диплом нь ҮБТДС-ийн Удирдах Зөвлөлийн дарга, захирал, төгсөлтийн комиссын даргын гарын үсэг, ҮБТДС-ийн тамга, тэмдгээр баталгаажих ба дугаар, бүртгэлийн дугаартай байна.

Диплом нь хавсралттай байх ба хавсралтад эзэмшсэн үндсэн болон хавсарга мэргэжил, гүнзгийрэн судалсан чиглэл, суралцсан хугацааны хичээлүүд, тэдгээрийн багц цаг, голч дүн ба оноог бичнэ. Хавсралтыг сургалтын албаны даргын гарын үсэг, тамгаар баталгаажуулна.

Диплом, хавсралтын загварыг боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаар батлуулан олгож байна.


Магистрант сургалтын багц цагаа хугацаанд нь цуглуулсан боловч магистрын ажлыг бичих цагаа биелүүлж амжаагүй бол ҮБТДС-ийн магистрын сургалтыг дүүргэсэн тухай захирлын тушаал гаргаж гэрчилгээ олгоно. Тухайн багц цаг бүхий энэхүү гэрчилгээг авснаас хойш магистрантад 3 жил хүчин төгөлдөр байх ба дээрх хугацаанд эрдэм шинжилгээний багц цагаа гүйцээн магистрын ажлаа бичиж хамгаалах эрхтэй байна.

3.6 Сургалтын хөтөлбөрийг тасралтгүй сайжруулах

Сургуулийн сургалтын бодлого, сургалтын арга хэлбэр, технологи, сургалтын хөтөлбөрийг шинэчлэхдээ хөдөлмөрийн зах зээлийн хэрэгцээ шаардлага болон өндөр хөгжилтэй орнуудын нийтлэг жишигт нийцүүлэх чиглэлийг баримталж ирлээ. Хичээлүүдийн агуулга, стандарт тодорхойлолтыг 1996 онд анхны хувилбараар боловсруулсан бөгөөд түүнээс хойш хугацаанд өөрчлөн сайжруулах арга хэмжээ авч ажилласан. Түүнчлэн хөтөлбөрийн агуулгад багтсан мэргэжлийн хичээлүүдийг гадаад, дотоод орчны өөрчлөлттэй уялдуулан байнга шинэчлэх, боловсронгуй болгох арга хэмжээ авч байна.

2009 онд Хүний нөөцийн менежмент мэргэжлийн магистрын хөтөлбөрийг шинэчлэн боловсруулж батлуулсан бөгөөд үүний дагуу багш бүр өөрийн хариуцан заадаг хичээлүүдийн агуулгын стандарт, тодорхойлолтуудыг шинэчилж, батлуулан мөрдөж байна. Хамгийн сүүлд сайжруулалт хийсэн мэргэжлийн хичээлийн агуулгын стандарт, тодорхойлолтуудыг электрон хэлбэрээр сургуулийн вэб сайтад байрлуулаад байна.

ҮБТДС-ийн хамт олон сургалтын хөтөлбөр, шинэчлэлд дараах үнэлгээг өгсөн байна. Хамт олны Шалгуур 3-ын сэтгэл ханамжийн байдал буюу өөрийн үнэлгээний байдлаас үзэхэд хөтөлбөрийн хороо, хөтөлбөрийн зорилго зэрэг нь бусад дэд шалгууруудаас дээгүүр (3,67) үнэлгээг авсан байна.



Хөтөлбөрийн агуулга арга зүй, сургалтын технологид 3,61, харин хөтөлбөрийн үнэлгээ, хөтөлбөрийн чанарын дотоод баталгаажуулалтад 3,50 оноог тус тус өгчээ. Хамгийн доогуур үнэлгээг /3,44 оноо/ сургалтын бусад үйл ажиллагаанд өгсөн байна. Цаашид сургалтын бусад үйл ажиллагааг анхаарах нь зүйтэй гэсэн дүгнэлт гарч байгаа юм.

SWOT шинжилгээ

Давуу тал
(Strength)

- Сургалтын хөтөлбөрийг сургуулийн эрхэм зорилго зорилтыг биелүүлэхэд чиглүүлсэн нь ажлын бүтээл, үр дүн болон нөлөөг сайжруулсан байна
- Хөтөлбөрийг хэрэгжүүлэх санхүүгийн нөөцийн зарцуулалт өнөөгийн шаардлагын хэмжээнд хүрснээр, сургуулийн эдийн засгийн үр ашгийг дээшлүүлэх боломж бүрдсээр байна.
- Олон улсын стандарт, мөн хөдөлмөрийн зах зээлийн шаардлагад нийцсэн сургалтын хөтөлбөрийг боловсруулан хэрэгжүүлж, чанартай үйлчилгээ үзүүлж чаддаг.
- Биеийн тамир, спортын салбарын мэргэжлийн хэтийн хэрэгцээ, шаардлагыг харгалзан 2014-2015 оны хичээлийн жилээс мэргэжлийн хөтөлбөр, индексийг шинээр хэрэгжүүлэн ажиллаж байна.

Сул тал
(Weakness)

- Сургалтын хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд эерэгээр нөлөөлөх дадлагын хичээлийн бааз, орчин сайжруулах үйл ажиллагаа хүлээлттэй байна. Спортын цогцолборыг 2019 онд шийдвэрлэх нь зүйтэй.
- Сургалтын хөтөлбөрийг боловсронгуй болгох үйл ажиллагаанд зарцуулах сургалтын төлбөрийн бус буюу бусад орлогын хэмжээ харьцангуй бага байна.

Боломж
(Opportunities)

- Олон улсын Их, Дээд сургуулиудын Холбооны гишүүнчлэлээ ашиглан БНГУ, ОХУ, Авсрали, Казакстан, БНХАУ, Япон, БНСУ-ын Биеийн тамирын Их дээд сургуулийн жишиг хөтөлбөрүүдийг ашиглан сургалтын хөтөлбөрийн агуулга, арга зүй, технологи, сургалтын материалаг баазыг улам боловсронгуй болгох боломжтой.
- Багш нарыг гадаад улс орнуудад багш солилцоогоор өндөр түвшинд багшлахуйгаар давтан бэлтгэх боломж бий.
- Хөтөлбөрийн Хороо, дэд хороодын үйл ажиллагааг эрчимжүүлж, сургалтын хөтөлбөрийг байнга сайжруулан боловсронгуй болгож ажиллах уян хатан холбоог бий болгох боломжтой.

Эрсдэл (Threats)

- Материалаг баазын шинэчлэл нь Сургалтын хөтөлбөр, төлөвлөгөөнд тусгагдсан хичээлүүдийг чанартай зохион байгуулах боломжийг нэмэгдүүлэх ч агуулгыг шинэчлэх нь хөтөлбөрийг тогтвортой хэрэгжүүлэхэд эрсдэлтэй.

ШАЛГУУР 4. ХҮНИЙ НӨӨЦ

Сургууль нь өөрийн эрхэм зорилго, зорилгуудыг хэрэгжүүлэхэд зайлшгүй шаардагдах хүний нөөцийг сургуулийн хэмжээнд төдийгүй салбар, нэгж, хөтөлбөр бүрээр төлөвлөн бүрдүүлж, хөгжүүлэх бодлоготой байна.

4.1.ХҮНИЙ НӨӨЦИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТ

Сургууль нь хүний нөөцийн бүрдүүлэлт, төлөвлөлт, ханган нийлүүлэлт, хөгжлийн талаар баримтлах бодлого, дүрэм, журамтайгаар ажиллаж ирсэн.

ҮБТДС нь хүний нөөцийн бодлого зохицуулалтын хүрээнд “Багшийн хөгжлийн хөтөлбөр”-ийг боловсруулан үүнтэй уялдаа хамаарал бүхий сургуулийн дүрэм, журмуудыг үйл ажиллагаандаа мөрдлөг болгон ажиллаж байна. Багшийн хөгжлийн хөтөлбөрийн зорилго нь “Хүний нөөцийг хөгжүүлж, үндэсний биеийн тамирын хөгжилд хувь нэмэр оруулах”-д оршино. “Багшийн хөгжлийн хөтөлбөр”-ийн хүрээнд 3 үндсэн тэргүүлэх чиглэлийг тодорхойлсон. Үүнд:

- Ажлын байран дээрээ тасралтгүй хөгжих орчинг бүрдүүлэх, хүний нөөцийн бодлого хэрэгжүүлэх,
- Үндэсний болон олон улсын хэмжээнд хүлээн зөвшөөрөгдсөн шилдэг боловсон хүчин бэлтгэх чадвар бүхий хүний нөөцийн багийг бүрдүүлэх,
- Үндэсний болон олон улсын хэмжээнд биеийн тамирын хөгжил, боловсролд хувь нэмэр оруулах чадварлаг боловсон хүчнийг бэлтгэхэд үүрэг, хариуцлагаа нэмэгдүүлэхээр тодорхойлсон.

Эдгээр зорилтуудыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд хүний нөөцийн хөгжлийн бодлогоо сургуулийн алсын хараа, эрхэм зорилгыг хэрэгжүүлэх гол хүчин болсон багшлах боловсон хүчний зохистой бүтэц, бүрэлдэхүүнийг их, дээд сургуулийн стандартад нийцүүлэн бий болгож, багш ажилтны боловсрол, ур чадвар, ажлын туршлагыг нэмэгдүүлэх замаар тогтвортой хөгжих нөхцлийг ханган ажиллахад чиглүүлнэ.

ҮБТДС-ийн эрхэм зорилго болон үйл ажиллагааны зорилго, зорилтуудтай “Багшийн хөгжлийн хөтөлбөр” нь салшгүй уялдаа холбоотой бөгөөд байгуулагдсан цагаасаа хойш эрдэмтэн, профессор, багш нарын тогтвор суурьшилтай ажиллаж байсан болно. Тус сургууль нь мэргэжлийн хувьд чадварлаг, мэдлэг, боловсрол сайтай боловсон хүчнийг сонгон ажиллуулж, багш нарын тоо, бүрэлдэхүүнийг хэрэгжүүлж буй мэргэжлийн хөтөлбөр бүрээр төлөвлөж, багш нарыг хөгжүүлэх хөтөлбөрийг хэрэгжүүлж байна.

Олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн, биеийн тамирын хөгжил, боловсролд хувь нэмэр оруулах эрдэмтэн, профессор, багш нараар хүний нөөцөө бүрдүүлэхийн тулд дараах үйл ажиллагаануудыг авч хэрэгжүүлж байна. Үүнд:

- Спортын олон улсын зэрэгтэй, сурган хүмүүжүүлэх, дасгалжуулах өндөр ур чадвартай профессор, багш, судлаачдаар хүний нөөцийг бэхжүүлэх, багшлах бүрэлдэхүүний мэргэжлийг дээшлүүлэх, ахмад багш нарын залгамж халааг бэлтгэх ажлуудыг зохион байгуулж байна.
- Спортын менежмент, спортын анагаах ухаан зэрэг чиглэлээр судалгаа, шинжилгээний ажил хийх, өөрөө хөгжих хүсэл эрмэлзлэлтэй чадварлаг залуу, спортын зэрэг цолтой, сурган заах арга зүйтэй, судалгааны ажил хийх ур чадвартай шилдэг тамирчдыг багшаар сонгон шалгаруулан ажиллуулж улмаар

олон улсын болон үндэсний хэмжээний спортын тэмцээн уралдаанд оюутан тамирчдаа бэлтгэн оролцуулахад тэдний үйл ажиллагааг чиглүүлж байна.

- Багш нарыг олон улсын болон дотоодын сургалт семинар, төсөл, хөтөлбөрт хамруулах, туршлага солилцуулах, зочин багшаар ажиллуулах арга хэмжээг авч байна. /хүснэгт 12/

4.1.1. Багш, профессорын багийн бүрэлдэхүүн

ҮБТДС-ийн хүний нөөцийн үйл ажиллагааны зохион байгуулалт нь нэг талаас тэнхимийн зохион байгуулалт, нөгөө талаас спортын секцийн хосолмол бүтэцтэйгээр сургалт, судалгаа, спорт /ССС/ гэсэн гурван үндсэн чиг үүрэгтэйгээр ажилладгаараа бусад их, дээд сургуулиудаас ялгарах онцлогтой юм.

Тус сургууль биеийн тамирын боловсрол олгодог сургуулийн хувьд багш нарын бүрэлдэхүүн нь нэг талаас спортын өндөр зэрэг цолтой, нөгөө талаас их, дээд сургуулийн багшийн хувьд сургалт-судалгаа шинжилгээний ажлыг хослон эрхэлдэг чадварлаг хүний нөөцийг бүрдүүлэн ажиллаж байна.


Хүснэгт 11

Салбар, нэгжүүдийн хүний нөөцийн бүрдлийн түвшин (2017-2018 оны хичээлийн жилээр давхардсан тоогоор)

№	Салбар нэгж, тэнхим	Тоо	Боловсрол ба эрдмийн цол, зэрэг	Спортын цол зэрэг
1	Удирдлагын түвшинд	1	ШУ-ны доктор	ОУХМ
2.	Сургалтын алба	3	Дэд проф-1 Магистр-2	-
3.	Санхүүгийн алба	3	Доктор, проф-1 Бакалавр-2	-
4	Онол арга зүйн тэнхим	15	ШУ-ны доктор-1 Доктор-7 Докторант-1 Магистр-6	ОУХМ-2, СМ-3
5	Үндэсний спорт, мэргэжлийн тэнхим	17	Докторант-1 Магистр- 16	ОУХМ-2, СМ-10
6.	Биеийн тамирын эмчилгээний арга зүйн тэнхим	5	Докторант – 2 Магистр- 3	-
Бүгд		44		

Зураг 10


Багш нарын бүтэц /ангиллаар ба хувиар/



ҮБТДС-ийн багш нарын 12,1 хувь нь профессор, 21,3 хувь нь дэд профессор, 30.3 хувь нь ахлах багш, 36.3 хувь нь багш байна. Эдгээр профессор багшийн тэнхимийн харьяаллыг дараах зургаар харуулав.

Зураг 11


Багш нарын тэнхимийн харьяалал



Нийт багш нарын 54.5% нь Биеийн тамир онол арга зүйн тэнхимд, 33.4% нь Үндэсний спорт мэргэжлийн тэнхимд, 12.1% нь Биеийн тамир эмчилгээний арга зүйн тэнхимд ажилладаг.

Зураг 12

Профессорын баг, багшлах бүрэлдэхүүний эрдмийн зэрэг, цол




Тус сургуульд шинжлэх ухааны доктор зэрэгтэй багш 1 буюу нийт багш нарын 3.0%, боловсролын докторын зэрэгтэй 7 багш буюу нийт багш нарын 21.2% бөгөөд докторын зэрэгтэй багш нарын нийт багшид эзлэх хувийн жин 24.2% болж байна.

Эдгээр докторын зэрэгтэй багш нарын эзлэх хувийн жинг үндсэн багшийн хувьд тооцож гаргасан бөгөөд тус сургуульд докторын зэрэгтэй цагийн багш 4 байдаг.

Зураг 13

Захиргаа, аж ахуйн албан хаагчид




ҮБТДС-ийн захиргаа аж ахуйд 4, номын санч 1, санхүүгийн албанд 3, сургалтын албанд 3 мэргэжилтэн тус тус ажиллаж байна.

ҮБТДС-ийн багш, ажилтан нарын спортын зэрэг, цолны байдлыг дараах зургаар харуулав.

Зураг 14

Багш, ажилтан нарын спортын зэрэг, цолны байдал



Тус сургуулийн профессор багш нар тухайн спортын салбартаа танигдсан нэр хүнд бүхий тамирчид байдаг. Тухайлбал, тэдний 23.3% нь олон улсын хэмжээний мастер, 50.0% спортын мастер, 13.3% нь 1 ба 2-р зэрэгтэй, 10% нь улсын шүүгч, 3.3% нь олон улсын дасгалжуулагч байдаг онцлогтой.

ҮБТДС нь Хүний нөөцийн бодлого, зохицуулалтын хүрээнд “Боловсролын тухай хууль”, “Дээд боловсролын тухай хууль”, “Боловсролын талаар Төрөөс баримтлах бодлого” болон бусад эрх зүйн баримт бичгүүдэд нийцүүлэн “Багшийн хөгжлийн хөтөлбөр” болон бусад дүрэм, журмуудыг үйл ажиллагаандаа мөрдлөг болгон ажиллаж байна.


4.1. ХҮНИЙ НӨӨЦИЙН ХӨГЖИЛ

ҮБТДС нь биеийн тамир, спортын салбарт шинжлэх ухааны үндэслэлтэй ололт амжилтыг нэвтрүүлэх зорилготойгоор дараах үйл ажиллагаануудыг явуулж байна. Үүнд:

- Орчин үеийн антропометрийн стандарт шаардлага хангасан сонгодог аргаар Швецарь улсын “GPM” фирмийн антропометрийн багаж, тоног төхөөрөмжийг ашиглан бие бялдрын хөгжилтийн түвшингийн 39 шинж тэмдгийг тодорхойлсон. Үүнд: араг ясны 18 хэмжилт, биеийн мөчид, хэсгийн тойргийн 10 хэмжилт, өөхөн давхрааны 11 хэмжилтийг авч тодорхойлж байна.
- ОХУ-ын анагаах ухааны эрдэм шинжилгээний төвийн “Медасс ABC” биоимпеданс багажийг ашиглан судлуулагчдын биеийн дотоод бүтэц зүйг (булчин, өөхний хуримтлал, идэвхтэй эсийн хэмжээ, усны хэмжээ, үндсэн солилцоо, эс хоорондын шингэн зэрэг) болон бодисын солилцооны түвшинг тодорхойлно.
- Зүрх-судасны системийн үйл ажиллагааны байдал, артерийн дээд, доод даралт, зүрхний лугшилтын давтамж, шинж чанарыг илэрхийлсэн физиологийн үйл ажиллагааны функциональ хэмжигдэхүүнүүдийг багтаасан цогц хэмжилтүүдийг тодорхойлно.
- Германы “Spiro USB” фирмийн спирометрийн багажаар амьсгалын системийн үйл ажиллагааг илэрхийлэх уушигны амьдралын багтаамж, хүчилтөрөгчийн дээд хэрэглээ, амьсгалын системийн үйл ажиллагааны доголдол зэргийг илрүүлэх цогц шинжилгээ хийнэ.
- Сурган хүмүүжүүлэх тестийн аргаар бие бялдрын бэлтгэлжилтийн түвшин (хурд, хүч, уян хатан, авхаалж самбаа, тэсвэрийн) тогтоох судалгааг хийдэг.
- Спортын авьяас чадвар тодорхойлох зорилгоор амны хөндийн арчдаснаас молекул генетикийн шинжилгээний дээж авч тодорхойлох судалгаа явуулна.
- Хичээллэгчдийн ачааллыг болон ажиллах чадварыг тодорхойлно.

ҮБТДС-ийн багш, ажилтан нарын тогтвор суурьшлын байдлын судалгааг дараах зургаар харуулав.

Хүний нөөцийн тогтвор суурьшлын судалгаа



Тус сургуулийн багш нар харьцангуй тогтвор суурьшилтай ажилладаг. Тухайлбал, нийт багш нарын 15.4% нь 20-оос дээш жил буюу сургууль үүсгэн байгуулагдсан цагаас өнөөг хүртэл ажиллажээ. Багш нарын 30.8% нь 11-19 жил ажилласан бөгөөд тал хувь нь 10 жилээс дээш хугацаагаар сургуульдаа багшилж байна. Сүүлийн 5 жилийн хугацаанд 3 багш шинээр авсан бөгөөд эдгээр багш нарын 1 нь боловсролын докторын зэрэгтэй, үлдсэн 2 багш нь магистрын зэрэгтэй. Харин сүүлийн 3 жилд 1 багш хувийн шалтгаанаар ажлаас чөлөөлөгджээ.

Багш, ажилтны мэргэжил дээшлүүлсэн болон сургалтад хамрагдсан байдлыг авч үзье.

Ажлын цаг, ачаалалтай холбоотойгоор багш нарын дотоод, гадаадад мэргэжил дээшлүүлж, түр сургалтад хамрагдах байдал бага харагдаж байгаа ч магистр зэрэгтэй багш нараа жил бүр докторантурын сургалтад хамруулах, төгсгөх тал дээр анхаарал хандуулж ажилладаг. Сургуулийн хэмжээнд 6 багш докторантурын сургалтад хамрагдаж спортын менежмент, спортын сурган, заах арга зүй, спортын боловсрол, спортын анагаах ухааны чиглэлээр судалгаа, шинжилгээний ажил гүйцэтгэж байна.

Хүснэгт 12

ҮБТДС-ийн хүний нөөцийн хөгжлийн талаар хийгдсэн ажлууд


Д/д	Хүний нөөцийн хөгжил	2016	2017	2018
1	Ахмад багш нарын залгамж халааг бэлдэж буй байдал			Багш Н.Мягмарзулыг Б.Бордох багшид дагалдуулан сургаж ажиллах (Тушаалыг хавсаргав)
2	Олон улсын болон	1.Б.Хэрлэн "Волейболын	1.Олимпийн хорооны сургалт	1.Проф Сакүрай Норико

	дотоодын сургалт семинарт оролцсон байдал	холбооны дасгалжуулагчын семинар” 2.Б.Мөнгөнтуяа “Жудо бөхийн дасгалжуулагчын семинар” 3.Э.Мөнх-Оргил “ОУ-н дасгалжуулагчын семинар” 4.Д.Баасанхүү “МУБИС MNUE AUTHORS сэдэвт семинар”	нийт багш нар “G.Mail” сургалтыг зохион байгуулсан. 2. Олимпийн хорооны нийт багш нарт “PP” сургалт зохион байгуулсан.	“SPSS” сургалт нийт багш нарт зориулсан.
3	Төсөл, хөтөлбөрт оролцсон байдал	1.Орчин үеийн хүүхэд, өсвөр үе, нийгэм эдийн засаг ба хүрээлэн буй орчны хүчин зүйлийн судалгаа 2.ОХУ-ын Ломносовын нэрэмжит Москавагийн Их сургууль, Антропологийн хүрээлэнд ҮБТДС хамтарсан төсөл	1.Орчин үеийн хүүхэд, өсвөр үе, нийгэм эдийн засаг ба хүрээлэн буй орчны хүчин зүйлийн судалгаа 2.ОХУ-ын Ломносовын нэрэмжит Москавагийн Их сургууль, Антропологийн хүрээлэнд ҮБТДС хамтарсан төсөл 3.ХХААХҮЯ-ны захиалгат “Хөдөө аж ахуйн Халхгол үндэсний бүтээн байгуулалтын бүсэд ургамал, мал амьтны хорио цээрийн дэглэм бүхий бүс байгуулах ТЭЗҮ боловсруулах”, Н.Мягмарзул	1.Орчин үеийн хүүхэд, өсвөр үе, нийгэм эдийн засаг ба хүрээлэн буй орчны хүчин зүйлийн судалгаа 2.ОХУ-ын Ломносовын нэрэмжит Москавагийн Их сургууль, Антропологийн хүрээлэнд ҮБТДС хамтарсан төсөл 3.”Тамирчдын бие бялдрын бүтэц үйл ажиллагаа онцлог бүрэлдэхийг иж бүрэн судлах” Ш.Батэрдэнэ, Г.Гүндэгмаа 4. Монгол Банкны захиалгат “Малын гаралтай бүтээгдэхүүний экспортыг нэмэгдүүлэх арга зам: Ноос, ноолуурын чиглэлийн судалгаа”, Н.Мягмарзул 5.Үндэсний хөгжлийн газрын захиалгат “Монгол улсын эдийн засгийн өсөлтийг хангахуйц санхүүгийн тогтвортой байдлын үр

				ашигтай механизмыг бүрдүүлэх загварыг боловсруулах суурь судалгаа”, Н.Мягмарзул
4	Зочин багш ажиллаж сургалт явуулсан талаар	1.Проф Сакүрай Норико “Гэмтэл согогын төвийн бариа засал” сургалт	1.Ким багш ба Ким Чүнь-Жа нар “Монголын уламжлал эмчилгээний аргыг судалж зөвлөгөө өгөх нь” 2. Норико Японы Спортын их сургууль 3. Кекучи Японы Цукүба их сургууль 4. Мартин Чехийн Charles их сургууль 5. Година Ломносовын их сургууль 6. Richard Weiss Чөлөөт бөхийн дасгалжуулагч Австрали улс Сидней хот (Interhate Sportove Gymnazium, Kosice)	1.АНУ-ын багш Кинг нийт багш нарт зориулсан “Англи хэлний сургалт” 2.Сургуулиас зохион байгуулсан ОУ-н эрдэм шинжилгээний бага хуралд нийт багш нар оролцов.

Зураг 16

Үндсэн багш нарын төгссөн сургууль



Багш, ажилчдын нийгмийн асуудлыг шийдвэрлэх үүднээс тэднийг эрүүл мэндийн үзлэг шинжилгээнд 2 жилд 1 удаа хамруулахаар төлөвлөгөөнд тусган ажилладаг ба нэг багшид жилд 150000 /нэг зуун тавин мянга/-н төгрөг төсөвлөдөг. Тухайн санхүүжилтийн тал хувийг дотоод нөөц бололцоог түшиглэн биеийн тамирын эмчилгээний арга зүйн тэнхимийн хүний их эмч нар эмчилгээ үйлчилгээ үзүүлэх ба эмчлэх, эрүүлжүүлэх чийрэгжүүлдэг. Мөн харьяа байгууллага болох СБД-ийн Нэгдсэн эмнэлэгийн мэргэжлийн эмч нартай бартер буюу спорт заалыг ашиглуулан нарийн мэргэжлийн үзлэг, шинжилгээнд хамруулдаг. /багш нарын эмнэлэгийн хяналтын карт, нарийн мэргэжлийн үзлэгийн картыг хавсаргав/

ҮБТДС-ийн дүрэм, журамд профессор, багш, ажилтан, ажилчдыг хэрэгцээ, шаардлагыг төлөвлөн тэднийг сонгон шалгаруулахаар тусгагдсан, ингэхдээ ажлын байрны хэрэгцээ байгаа нэгж, байгууллагуудын саналыг харгалзаж байна.

“Багшийн хөгжлийн хөтөлбөр”-т багшлах боловсон хүчний сонгон шалгаруулалт, аттестатчилалын тогтолцоог боловсронгуй болгох, шинэ ажлын байранд тавигдах шаардлагыг ханган, ажиллах эрмэлзлэл бүхий боловсон хүчнийг нээлттэй шалгаруулалтаар сонгон авч байхаар тусгагдсан бөгөөд ажлын байранд ажиллах албан хаагчдын сонгон шалгаруулалтыг Хүний нөөц, чанарын дотоод баталгаажуулалтын албанаас хариуцан зохион байгуулж байна.

Тус сургууль мэргэшсэн, өрсөлдөх чадвар бүхий хүний нөөцийг бүрдүүлэхдээ ҮБТДС-ийн “Хөдөлмөрийн дотоод журам”, “Багшийн хөгжлийн хөтөлбөр”-ийн заалтуудад тусгагдсаны дагуу ажлын байрны шаардлагад нийцсэн боловсрол, мэргэжлийн түвшин, мэргэжлийн авьяас сонирхол, хувийн соёл, зан харилцаа, нийгмийн идэвх, ажил үүрэг гүйцэтгэх чадамж (эрүүл мэнд) ёс суртахууны байдлыг харгалзан явуулдаг бөгөөд жилээс жилд сонгон шалгаруулалтад оролцогчдын чадвар сайжирч, ажил олгогчдын ажлын байрны шаардлагыг хангаж байсан болно. Нээлттэй сонгон шалгаруулалтыг зохион байгуулснаар сургуулийн хүний нөөцийн бүрдүүлэлт эрх зүйн хэм хэмжээнд чанартай явагдаж байна гэж дүгнэж байна.

Манай сургууль боловсон хүчнээ сонгох үндсэн үзүүлэлтэд дараах шаардлагыг хангасан байх ёстойг тодорхой тусгасан. Тухайлбал, багш сонгон шалгаруулахдаа дараах шалгууруудыг тавьдаг.

Тавигдах шаардлага:

Мэргэжил

- Мэргэжлийн сургуулийг төгссөн, дээд боловсролын хуулинд заасан болон түүнээс дээш боловсролын зэрэгтэй
- Англи хэл, компьютерийн дундаас дээш түвшний мэдлэгтэй

Туршлага

- ЕБС-д багшилж байсан бол давуу тал болно
 - Спортын өндөр зэрэгтэй бол давуу тал болно /мэргэжлийн хичээлээр/
- Ур чадвар
- Багаар ажиллах чадвартай
 - Хүмүүсийг сонсох, ойлголцох, нээлттэй харилцах, хамтран ажиллах, ажилд хариуцлагатай хандах чадвартай

Ажилд орохыг хүссэн багш, ажилтан, ажилчид доорх бичиг баримтыг бүрдүүлнэ.

- а. Ажилд орохыг хүссэн өргөдөл
- б. Биеийн байцаалт (маягт №1), товч намтар
- в. Иргэний үнэмлэх (хуулбар)
- г. Нийгмийн даатгалын дэвтэр
- д. Боловсролын диплом
- е. Мэргэжлийн гэрчилгээ, зэрэг цолны үнэмлэх
- ж. Бүтээлийн жагсаалт (зөвхөн багш, ажилтан)

Сургуулийн зүгээс багш нартаа дараах цалин хөлс, урамшуулал, гавьяа шагнал олгох, дэмжлэг, туслалцааг дотоод журмаараа зохицуулдаг. Үүнд:

- Профессор, дэд профессор, ахлах багш цол олгох (үүнд багш, эрдэм шинжилгээний ажилтан хамаарна)
- Боловсрол, эрүүл мэнд, спортын төв байгууллага, бусад байгууллагын шагналд тодорхойлох;
- Төрийн дээд шагнал, олон улсын байгууллагын шагналд тодорхойлох;
- Мөнгөн шагнал олгох, материаллаг урамшуулал үзүүлэх
- Эрдэмтэн, багш, эрдэм шинжилгээний ажилтан сургуулийн захиргаатай гэрээ байгуулан эрдэм шинжилгээ, судалгааны ажил хийхээр нэг жил хүртэл хугацаагаар бүтээлийн чөлөө авч болох бөгөөд энэ хугацааны цалинг сургуулийн дотоод дүрэм журмын дагуу олгоно. Бүтээлийн чөлөөтэй байсан хугацаанд хийж гүйцэтгэсэн ажлын тайлан, үр дүнг захиргааны зөвлөлийн хурлаар хэлэлцдэг.
- Сургуулийн захиргаа багш, ажилчдад хүүхдээ болон өвчтөн асрах, амьдрал ахуйгаа дээшлүүлэх зэрэг шалтгаанаар нэг жил хүртэл хугацааны цалингүй (тэтгэмжгүй) чөлөө олгож болно.

Мөн түүнчлэн тус сургуулийн багш нар гадаад дотоодын, сургалт, спортын уралдаан тэмцээнд дасгалжуулагч, эмч, зөвлөхөөр ажиллах, мэргэжил дээшлүүлэх сургалтад хамрагдах тохиолдол олноор гардаг бөгөөд энэ үед ҮБТДС албан ёсны цалинтай чөлөө олгож дэмждэг.

Сургуулийн багш нарыг “ҮБТДС-ийн шилдэг багшийг шалгаруулах” журмад заасан шалгуур үзүүлэлтээр тогтмол дүгнэж “Оны шилдэг судлаач багш”, “Оны шилдэг арга зүйч”, “Оны шилдэг дасгалжуулагч багш” шалгаруулдаг.

Тус сургууль хүний нөөцийг хөгжүүлэх, сургалтад хамруулах, мэргэжлийн зэрэг, эрдмийн цол ахиулах, ажлын үр дүнгээр шагнаж урамшуулах, дэмжлэг үзүүлэх ажлуудыг сургуулийн “Багшийн хөгжлийн хөтөлбөр”, жил бүрийн “Үйл ажиллагааны төлөвлөгөө”-нд тусган хэрэгжүүлж байна. Дээрх баримт бичгүүдэд багш нарын мэргэжил дээшлүүлэх ажлыг төлөвлөгөөтөйгөөр зохион байгуулах, залуу, эрдэмтэн судлаачдыг бэлтгэх, мэргэжлээ дээшлүүлэхэд дэмжлэг үзүүлэх, гадаад улс орнуудад спортын уралдаан, тэмцээнд оролцоход дэмжлэг үзүүлэх, олон улсын хуралд оролцох, нэр хүнд бүхий мэргэжлийн сэтгүүлд бүтээлээ хэвлүүлэхэд туслах зэрэг зорилтыг хэрэгжүүлэхээр тусгасан. Мөн багш өөрөө суралцах, хөгжих асуудлыг удирдлагаар ханган, үе шаттайгаар төлөвлөн ажиллаж байна.

Өнгөрсөн 3 жилд профессор багш нарын бүрэлдэхүүний чанарыг сайжруулах талаар авсан арга хэмжээний хүрээнд профессор, багш нарыг олон улсын хуралд оролцох илтгэл хэлэлцүүлэхэд анхаарч өөрийн сургуулийн зүгээс ОУХ зохион байгуулж багш нараа тогтмол оролцуулдаг.

Багш нарын төсөл хөтөлбөрт оролцох оролцоог нэмэгдүүлэх, залуу багш нарыг докторантурт сургах, бүтээлээ хэвлэн нийтлэх, өөрийн төгсөгчдөөс эрдэм шинжилгээний мэргэжлийн судлаач бэлтгэх, профессор багш нарын судалгааны ажлын спортын салбарт оруулах хувь нэмрийг нэмэгдүүлэхээр бодлогын чанартай хийсэн, зохион байгуулсан эдгээр ажлуудын үр дүнд багш нарын бүрэлдэхүүнд өөрчлөлт гарсны зэрэгцээ тэдний судалгааны ажилд оролцох эрмэлзлэл, тэмүүлэл өсч, эрдэм шинжилгээний ажлын цар хүрээ сайжирсан.

Түүнчлэн багш нар өөрсдөө суралцахаас гадна “Багшийн хөгжил хөтөлбөр”-ийн хүрээнд хамтын ажиллагаатай байгууллагуудтай хамтран ахисан түвшний урт богино хугацааны сургалт, семинарыг зохион байгуулдаг.

Тухайлбал, Япон улсын эрдэмтэн багш нараар судалгааны арга зүйн сургалтыг SPSS программ дээр зааж явуулсан нь багш нарын судалгааны ажил гүйцэтгэхэд тус дэм болсон юм. Багш нарын мэргэжлийн англи хэлний мэдлэгийг дээшлүүлэх зорилгоор жил бүр англи хэлний сургалтыг сургууль дээрээ зохион байгуулж ирлээ.

Багшийг тасралтгүй хөгжүүлэхийн тулд олон улсын болон үндэсний хэмжээний төсөл хөтөлбөрт хамруулж, сургалт, семинарыг зохион байгуулан мэргэжлийг нь дээшлүүлж байна. Сүүлийн 3 жилийн байдлаар тус сургуулийн эрдэмтэн профессорууд олон улсын болон үндэсний хэмжээний 10 гаруй төсөл дээр ажилласан. Энэ тухай шалгуур 8-д тодорхой өгүүлсэн.

ҮБТДС-ийн дүрэм, Багшийн хөгжлийн хөтөлбөр, Сургуулийн дотоод журамд залуу багш нарын сургалт судалгааны ажлаа явуулахад таатай орчин бүрдүүлэх, техник, технологээр хангах, мэргэжил, боловсролоо дээшлүүлэх, судалгааныхаа үр дүнгээр ном бүтээлээ хэвлэх, нийтийн хүртээл болгох, өндөр хөгжилтэй орны магистрантур, докторантурын сургалтад хамрагдах, эрдмийн зэрэг хамгаалахад нь дэмжлэг үзүүлэх талаар торохой зорилтуудыг тавин хэрэгжүүлж байна. Тухайлбал, эрдэм шинжилгээ, судалгаа хийх, мэргэжил дээшлүүлэхэд 3 сараас 1 жил хүртлэх хугацаагаар цалинтай, түүнээс дээш хугацаанд цалингүй чөлөө олгох, жил бүр залуу багш нарын дунд “Шилдэг залуу багш” уралдаан зарлан тодорхой шалгуур үзүүлэлтийн дагуу шалгаруулж байна.

Сүүлийн 5 жилийн байдлаар 10 багш МУИС-ийн Нийгмийн шинжлэх ухааны сургуулийн сургах зүйн дээд курсэд хамрагдлаа.

Түүнчлэн залуу багш нарыг БСШУСЯ болон бусад төрийн байгууллага, төрийн бус байгууллагуудын шагналд тодорхойлдог. Тухайлбал, сүүлийн 3 жилийн байдлаар 10 гаруй багш БСШУСЯ-ны жуух, МЗХ-ны “Тэргүүний залуу”, “Хөдөлмөрийн алдар” зэрэг шагналуудаар шагнагдсан.


Тус сургуулийн чанарын дотоод баталгаажуулалтын албанаас үр дүнг нь үйл ажиллагаандаа ашиглаж сургалтын чанарыг дээшлүүлэхэд ашиглах зорилгоор багш нараас дараах сэтгэл ханамжийн судалгааг авсан юм.

Энэхүү санал асуулгын үр дүнг тоймлон дараах байдлаар нэгтгэн тайланд оруулав.

1.Та өөрийгөө мэдлэг, чадвар сайтай багш, ажилтан гэж боддог уу?

Зураг 17


Та өөрийгөө мэдлэг, чадвар сайтай багш гэж боддог уу?



2. Мэдлэг чадвараа сайжруулахад тань ямар хүчин зүйлийн нөлөө их байдаг вэ? гэсэн асуултад дараах байдлаар хариулжээ.

Зураг 18

Мэдлэг чадвараа сайжруулахад тань ямар хүчин зүйлийн нөлөө их байдаг вэ?



3.Та сургуулиа илүү сайн хөгжүүлэхийн тулд ямар ажил хийвэл зүгээр гэж боддог вэ? гэсэн асуултад дараах байдлаар хариулжээ.

Зураг 19


Та сургуулиа илүү сайн хөгжүүлэхийн тулд ямар ажил хийвэл зүгээр гэж боддог вэ?



Судалгаанд хамрагдсан багш нараас ажлын байрны болон сургалтын анги танхимуудын хүрэлцээ хангамж, эрүүл ахуй, аюулгүй байдлын талаарх судалгааг авч үр дүнг доор нэгтгэв.


Зураг 20

Таны ажлын байр эрүүл ахуй, аюулгүй ажиллагааны хэм хэмжээнд нийцдэг үү?



Зураг 21


Анги танхимууд сургалтын ажиллагааг явуулахад хангалттай хүрэлцдэг үү?



Багш нараас Сургалтын үйл ажиллагаанд шаардлагатай техник, тоног төхөөрөмж, программ хангамж дижитал эх үүсвэрүүдийг ашиглах боломжтой эсэх, Сургалтын албанаас таны заадаг хичээлийн цаг, сэдвийн төлөвлөлтийг бүрэн хангахад анхаарч, хяналт тавьж ажилладаг эсэхийг тодруулсан болно.

Зураг 22


Сургалтын тоног төхөөрөмж ба технологийн мөрдөлтийн талаарх санал асуулгын дүн




Багш нараас “Таны авч буй цалин амьдралд чинь болон өөрийгөө хөгжүүлэхэд чинь хүрэлцээтэй байдаг уу” гэсэн асуултыг асууж хариултыг дор нэгтгэн харуулав.

Зураг 23

Таны авч буй цалин амьдралд чинь болон өөрийгөө хөгжүүлэхэд чинь хүрэлцээтэй байдаг уу?



Багшийн урамшууллын тогтолцооны талаарх асуултуудын хариулт

Нийт судалгаанд хамрагдсан багш нарын 66.6% нь багшийн хөгжлийг дэмжих урамшууллын систем байдаг, харин 33.4% нь “үгүй” гэж хариулжээ. Мөн нийт багш нарын 55.5% нь авдаг цалин ажлын нөхцөл, ачаалал, чанарт тохирсон гэж үздэг бол 44.5% буюу бараг тал хувь нь авч буй цалин хөлсөндөө сэтгэл дундуур байгаагаа нь харагдаж байна.

Багш нарын судалгаа шинжилгээг дэмжихэд чиглэсэн шинжлэх ухааны тодорхой чиглэлээр мэргэжлийн болон сонирхлоороо нэгдсэн судалгааны бүлэгт байдаг гэж нийт багш нарын 61.0% үзсэн бөгөөд цаашид үүнийг өргөжүүлэх замаар багш нарын эрдэм шинжилгээний ажлыг дэмжих боломжтой байна.

4.3. ХҮНИЙ НӨӨЦИЙН МЭДЭЭЛЛИЙН САН

ҮБТДС нь удирдах ажилтан, захиргааны ажилтан, үндсэн багш, гэрээт багш, ажилтан, ажилчид гэсэн хүний нөөцийн бүтэцтэйгээр үйл ажиллагаагаа явуулж байна.

- Сургуулийн хүний нөөцийн асуудал эрхэлсэн менежер нь хүний нөөцийн бүртгэл, мэдээллийн санг хариуцан ажилладаг.
- Чанарын дотоод баталгаажуулалтын алба нь сургалтын технологи, багш нарын ажлын гүйцэтгэлийн үнэлгээ, багш, оюутны сэтгэл ханамжийн судалгаа зэрэг асуудлуудыг хариуцан гүйцэтгэдэг.
- Тус сургууль өөрийн сургуулийн онцлогт нийцсэн “ЗС” буюу сургалт, судалгаа, спортыг хослон явуулах чадвар бүхий тэргүүлэх зэргийн эрдэмтдээс бүрдсэн тэнхимийн бүтцээр сургалтын үйл ажиллагааг хөтлөн явуулдаг.

Сургуулийн удирдлагын зүгээс багш ажилчдын ажлын гүйцэтгэлийг дараах байдлаар үнэлдэг. Үүнд:

- Багш, ажилчид сургуультай байгуулсан хөдөлмөрийн гэрээний дагуу ажлаа гүйцэтгэдэг эсэх,

- Багш, ажилчдын ажлын гүйцэтгэлийг “Нано софт” ХХК – ны “Fingerprint Attendance Management” программ бүхий хуруу танигч электрон машинаар ажлын цагийг бүртгэдэг системтэй,
- Багш, ажилчдын ажлын явцыг хянах “Нано софт” ХХК-ны 20 камерыг сургуулийн бүх анги танхим, заал талбайд байрлуулсан бөгөөд сургуулийн сургалтын албанаас TCL LED дэлгэцээр нэг доор зэрэг хянах системтэй,
- Ажлын чанарыг хийсэн ажлын тайлан, боловсруулсан хөтөлбөр, ном, гарын авлага, бүтээл, оюутны сурлагын болон спортын тэмцээний амжилтаар дүгнэдэг,
- Жил бүр судлаач багш, шилдэг багш, арга зүйч багш зэрэг номинацид өрсөлдүүлж багш нараа шалгаруулан шагнадаг.

Тус сургууль хүний нөөцөө бүрдүүлэхдээ “Ажлын шинжилгээ, Хүний нөөцийн төлөвлөлт, Хүний нөөцийн шилэн сонголт” гэсэн чиг үүргүүдийг үндэс болгож байна. Хүний нөөцийн бүрдүүлэлтийн үндсэн зорилго нь чадварлаг, мэргэшсэн ажил горилогчдыг байгууллагадаа татах, сул чөлөөтэй байгаа орон тоонд тухайн ажлын байрны шаардлага хангахуйц хүмүүсийг сонгож авахад оршино. Мөн бүрдүүлэлт нь хамгийн бага зардлаар, хамгийн богино хугацаанд, хамгийн тохиромжтой ажилтныг авахад голлон чиглэгдэж байна.

“Багшийн хөгжлийн хөтөлбөр”-т заасны дагуу хүний нөөцийн бүрдэлт, шилжилт хөдөлгөөн, нөөцийн нөхөн хангалтын бүртгэл, мэдээллийн санг тэнхим бүрт бий болгож ашиглахын зэрэгцээ БСШУСЯ-ны “Боловсролын удирдлагын мэдээллийн систем”-д сургуулийн хүний нөөцийн мэдээллийг оруулан ажиллаж байна. Нийт ажиллагсадын дэлгэрэнгүй мэдээлэл, шинээр ажилд орсон, ажлаас чөлөөлөгдсөн иргэний мэдээллийг бүртгэн албан хаагч бүрийн хувийн хэргийг хөтөлж удирдлага хамт олныг шаардлагатай мэдээллээр ханган ажиллаж байна.

Тус сургууль нь хүний нөөцийн бүртгэл мэдээллийн санг чанартай бүрдүүлэн ажилласнаар тайлан мэдээ гаргах, өдөр тутмын үйл ажиллагаандаа ашиглах боломжтой болсон.

Сургуулийн хүний нөөцийн бүртгэл мэдээллийн санг цаашид сайжруулах боломжуудыг дараах байдлаар тодорхойлж байна. Үүнд:

- Хүний нөөцийн тогтвортой хөгжил, хөрвөх, өрсөлдөх чадварыг нэмэгдүүлж тасралтгүй хөгжих таатай орчин бүрдүүлнэ.
- Тив, бүс нутгийн хэмжээнд хүлээн зөвшөөрөгдсөн багш, судлаачдаар хүний нөөцийг бэхжүүлнэ.
- Багшийн ажлын гүйцэтгэлийг программ хангамж ашиглан өндөр хэмжээнд зохион байгуулж, үр дүнг тооцох шалгуур үзүүлэлтийг боловсруулж хэрэгжүүлнэ.
- Ажиллах орчинг сайжруулж, техник хангамжийн хүрэлцээг нэмэгдүүлнэ,
- Залуу эрдэмтэн, судлаачдыг бэлтгэх, мэргэжлээ дээшлүүлэхэд дэмжлэг үзүүлж, өндөр хөгжилтэй орны магистр, докторын сургалтад хамруулах оюутан, багш нарын тоог нэмэгдүүлнэ.
- Багшийн мэргэжлийн чадавхыг дээшлүүлэх, манлайллыг хангах, байгууллагын соёлыг төлөвшүүлэх зорилгоор байгууллагын дотоод хяналт-шинжилгээ үнэлгээг хийх шалгуур үзүүлэлтийг боловсруулан, хэрэгжүүлж

дүгнэлт гаргах, ил тод тайлагнах бөгөөд энэ асуудлыг хариуцсан албаны бүтцэд нэмэлт оруулж ажил үүргийн хуваарийг шинэчилнэ.

4.4. БАГШ АЖИЛТНЫ ЦАЛИН, УРАМШУУЛАЛ

Багш, ажилтны ажлын нөхцөл, цалин хөлс, урамшуулал, дэмжлэгийг тэдний ажлын гүйцэтгэл, чанарт үндэслэсэн шударга, эрх тэгш, уян хатан хэрэгжих тогтолцоо бүрдсэн, цаг үеийн шаардлагад тулгуурлан шинэчлэгддэг байхаар ажиллаж байна.

Багш нарыг эрдмийн болон спортын зэрэг цол, ажилласан жил, туршлага зэргийг харгалзан үзэж үе шатлалтайгаар цалинжуулдаг. Тогтмол цалингаас гадна хоол унаа, ЭША, анги даалт, тест, гарын авлага боловсруулах зардал, бичиг хэргийн зардал зэрэгт нэмэгдэл цалин олгодог.

Хүснэгт 13

ҮБТДС-ийн багш, ажилчдын 2017-2018 оны хичээлийн жилийн цалингийн шатлал бүхий зардлын төсөв /мянган ₮/

№	Багшийн шатлал	Тогтмол цалин	Хоол	Унаа	ЭША	Анги даалт	Тест гарын авлага боловсруулах	Бичиг хэргийн зардал	БҮГД	Тоо	1 сард	ХАОТ	Ажил олгогч	Цалингийн зардалд	Жилд
Багшийн цалингийн шатлал															
1	Тэргүүлэх ОУХМ, дэд проф багш	520000	25200	25200	226000	26000	201600	176000	1200000	1	1200000	108000	156000	1356000	16272000
	Тэргүүлэх ОУХМ, багш	700000	24000	44000	34000	12000	24000	12000	850000	1	850000	73000	110500	960500	11526000
2	Доктор, профессор	472000	44000	44000	60000	60000	60000	60000	800000	2	1600000	148000	208000	1808000	21696000
3	Дэд доктор, дэд профессор	472000	44000	44000	44000	12000	24000	60000	750000	2	1500000	138000	195000	1695000	20340000
4	Магистр, ахлах багш	540000	44000	44000	24000	12000	24000	12000	700000	9	6300000	618000	819000	7119000	85428000
	Магистр багш - 1	600000	24000	44000	34000	12000	24000	12000	680000	1	680000	56000	88400	768400	9220800
	Магистр багш - 2	480000	24000	24000	24000	12000	24000	12000	650000	3	1950000	183000	253500	2203500	26442000
	Магистр багш - 3	410000	24000	24000	44000	12000	24000	12000	600000	5	3000000	288000	390000	3390000	40680000
5	Багш	404000	24000	24000	0	12000	24000	12000	550000	3	1650000	153000	214500	1864500	22374000
	Багш	404000	24000	24000	0	12000	24000	12000	500000	2	1000000	84000	130000	1130000	13560000
6	Дагалдан багш	312000	24000	24000	0	0	0	0	400000	2	800000	64000	104000	904000	10848000
Захиргаа, аж ахуйн ажилчдын цалингийн шатлал															
1	Захирал, дэд захирал	820000	25200	25200	226000	126000	401600	176000	2400000	2	4800000	472000	624000	5424000	65088000
2	Сургалтын албаны дарга	520000	25200	25200	226000	126000	201600	176000	1800000	1	1800000	180000	234000	2034000	24408000
3	Тэргүүлэх ОУХМ, дэд багш	520000	25200	25200	226000	126000	201600	176000	2000000	1	2000000	190000	260000	2260000	27120000
4	Нягтлан бодогч	404000	24000	24000	0	12000	24000	12000	550000	1	550000	39000	71500	621500	7458000
5	Жолооч	402000	24000	24000	0	0	0	0	600000	1	600000	44000	78000	678000	8136000
6	Нярав	352000	24000	24000	0	0	0	34000	500000	2	1000000	84000	130000	1130000	13560000
7	Үйлчлэгч	312000	24000	24000	0	0	0	34000	360000	2	720000	56000	93600	813600	9763200
	Бүгд	3330000	171600	171600	678000	390000	828800	608000	8210000	10	11470000	1065000	1491100	12961100	155533200

Багш нарын сүүлийн 8 жилийн цалингийн өөрчлөлтийг дараах зурагт тусгасан бөгөөд 2010-2011 оны хичээлийн жилээс хойш 2018-2019 оны хичээлийн жилийн хугацаанд тус сургуулийн цалингийн зардал 3 дахин өссөн байгааг харж болно. Хэдийгээр сүүлийн 5 жилд сургалтын төлбөр 2,5 дахин нэмэгдсэн ч сургалтын шууд зардал, багш ажилчдын цалин 4 дахин нэмэгдсэн байна. Бид байгуулагдсанаас хойш улсад нийтдээ 1,0 тэрбум орчим төгрөгийг Монгол Улсын төсөвт НДШ, ХАОАТ хэлбэрээр тушаасан байна.

Зураг 25



Багш, ажилчдын ажлын гүйцэтгэлийг дараах байдлаар үнэлдэг.

- Багш ажилчид сургуультай байгуулсан хөдөлмөрийн гэрээний дагуу ажлаа гүйцэтгэнэ,
- Ажлын чанарыг хийсэн ажлын тайлан, боловсруулсан хөтөлбөр, ном, гарын авлага, бүтээл, оюутны сурлагын болон спортын тэмцээний амжилтаар дүгнэнэ.
- Мөн жил бүр судлаач багш, шилдэг багш, арга зүйч багш зэрэг номинацид өрсөлдүүлж багш нараа шагнадаг.

Урамшуулал, дэмжлэгийн тогтолцооны үр өгөөжийн тухайд авч үзвэл тус сургуулийн багш нар гадаад дотоодын, сургалт, спортын уралдаан тэмцээнд дасгалжуулагчаар, эмчээр, зөвлөхөөр ажиллах, мэргэжил дээшлүүлэх сургалтанд хамрагдах тохиолдол олноор гардаг бөгөөд энэ үед сургууль албан ёсны цалинтай чөлөө олгож дэмждэг.

Хүснэгт 14

ҮБТДС-ийн багш нарт үзүүлсэн тусламж, үйлчилгээ
(Цалинтай чөлөө авсан хоног)

Багш нарын цалинтай чөлөөний задаргаа	2013-2014 он	2014-2015 он	2015-2016 он	2016-2017 он	2017-2018 он	Ажлын өдөр	Мөнгөн дүн
Тэмцээнд явсан хоног	104	48	93	98	96	439	15365000
Мэргэжлийн сургалтанд	92	119	85	42	80	418	14630000

суусан хоног							
Семинарт суусан хоног	25	29	29	32	30	145	5075000
ЭШХуралд суусан хоног	27	28	25	49	56	185	6475000
Ажлын өдөр	248	224	232	221	262	1187	41545000
Мөнгөн дүн	7440000	7280000	7540000	7735000	9170000	41545000	41545000
Сургуулийн заал ашигласан		1000000	1000000	1000000	2000000	5000000	5000000
Нийт зардал	7440000	8280000	8540000	8735000	11170000	46545000	46545000

Хүснэгт 15

**Багш нарт цалинтай чөлөө олгосон тухай мэдээлэл
/5 жилээр/**

Д/д	Багш нарын цалинтай чөлөөний задаргаа	Багш нарын цалинтай чөлөөний задаргаа	Хоног, хугацаа
1	Тэмцээнд явсан хоног	1.Э.Мөнх-Оргил “Аэробикийн”ДАШТ,- Португал Улс -Ази тивийн аварга шалгаруулах тэмцээн- БНСУ 2. Ц.Баярсайхан “Чөлөөт бөхийн” Тахти сур, Иран Улс -“Чөлөөт бөхийн” ОУ-ын тэмцээн Улан-Үдэ -“Дамдиншарав”-ын нэрэмжит чөлөөт бөхийн тэмцээн -Өвөрхангай аймаг - “Оюунболдын чөлөөт бөхийн тэмцээн” -“Улан-Үдийн Ерөнхийлөгчийн нэрэмжит чөлөөт бөхийн тэмцээн 3.Ж.Цогоо “Улан-Үдийн Ерөнхийлөгчийн нэрэмжит чөлөөт бөхийн тэмцээн 4.Ц.Баярсайхан “ОУ-ын Чөлөөт бөхийн тэмцээн” 5.Б.Хэрлэн “Волейбол” Улан-Үдэ -“Волейбол насанд хүрэгчд”-ийн УАШТ, Багануурт -“МВХ-ын Ахмадын” тэмцээн 6.Ц. Гантөгс “Чөлөөт Бөхийн ОУ-ын тэмцээн” Улан- Үдэ -“Сумо бөхийн” тэмцээнд Япон Улсад 7.С.Мөнх-Эрдэнэ “Оюутны хөнгөн Атлетик АШТ” 8. Мөнгөнтуяа “Самбо бөхийн ӨУУАШТ”, Завхан аймагт 9. Д.Ганболд “Волейбол- ОУАШТ” 10. Д.Шүрэнцэцэг “Гандболын ОУАШТ”	14 хоног 14 хоног 7 хоног 5 хоног 5 хоног 3 хоног 5 хоног 5 хоног 5 хоног 5 хоног 5 хоног 5 хоног 5 хоног 2 хоног 3 хоног 5 хоног 3 хоног 2 хоног

		11. МИДСК, МИДСБТБХ-оос зохион байгуулдаг “Волейбол, Сагсан бөсбөг”-ийн АШТ-нд эрэгтэй, эмэгтэй 16 багш нар оролцсон	
2	Олон улсын болон дотоодын мэргэжлийн сургалт оролцсон байдал	<p>1.Э.Мөнх-Оргил “ЕБС-ийн Уран хөдөлгөөнт гимнастикийн сургалт”</p> <p>-“Аэробик, гимнастик шүүгчдийн сургалт”</p> <p>-“Хөгжөөн дэмжигч”-ын сургалт</p> <p>2.Ц. Баярсайхан “Үндэсний бөхөө сурталчилах” Итали Улсад</p> <p>3.Б.Хэрлэн “Волейболын холбооны дасгалжуулагчийн семинар”</p> <p>4.Б.Мөнгөнтуяа “Жудо бөхийн дасгалжуулагчийн семинар”</p> <p>5.Э.Мөнх-Оргил “ОУ-н дасгалжуулагчийн семинар”</p> <p>6.Д.Баасанхүү “МУБИС MNUE AUTHORS сэдэвт семинар”</p> <p>7. Гурван тэнхимийн нийт (15) багш нар”G.Mail” сургалт, Олимпийн хороо</p> <p>8. Гурван тэнхимийн нийт (12) багш нар”PP” сургалт, Олимпийн хороо</p> <p>9.Д.Шүрэнцэцэг “Гандболын дасгалжуулагчийн ОУ”-ын сургалт</p> <p>10.Ц. Баярсайхан “Чөлөөт бөх” ДБНХолбоо сургалт</p> <p>-“Хүүхдийн Азийн наадам”-ын сургалт</p> <p>11.Д.Ганболд “Волейбол”-ын шүүгчийн сургалт</p> <p>12. С.Мөнх-Эрдэнэ “Theory and Metodology of sports training” сургалт</p> <p>13. “Sport Medicine and Science Course” МҮОХороо зохион байгуулсан сургалт</p> <p>Р.Түвшинжаргал</p> <p>14.Ш.Бат-Эрдэнэ</p> <p>15.Т.Баатар</p> <p>16.Э.Золжаргал</p> <p>17.М.Нямцэрэн, Ж. Цогоо Их дээд сургуулийн “Удирдлага мэдээллийн систем шинэчлэл” сургалт</p> <p>18.М. Нямцэрэн, Ц.Цэрэнгаваа ИДС-ийн “ДБУМС-ийн инноваци” сургалт</p> <p>19. Л.Алтанцэцэг, Ц.Цэрэнгаваа, Б.Пүрэвээ “E-San” цахим номын сангийн сургалт</p> <p>20. “Боловсролын үзэсгэлэн яармаг” Мишээл экспод 9 багш нар</p> <p>21.Ш.Бат-Эрдэнэ “ББ-ын Сэргээн засах судлалын” сургалт</p> <p>22. Р.Түвшинжаргал “SPSS” программын сургалтад ШУТИС 23. Э.Золжаргал “SPSS” программын сургалтанд ШУТИС</p> <p>24. Р.Лхамсүрэн “Норико багшийн гэмтэл бэртэлийн сургалт”</p>	<p>5 хоног</p> <p>2 хоног</p> <p>2 хоног</p> <p>30 хоног</p> <p>1 хоног</p> <p>1 хоног</p> <p>1 хоног</p> <p>1 хоног</p> <p>1 хоног</p> <p>7 хоног</p> <p>3 хоног</p> <p>1 хоног</p> <p>1 хоног</p> <p>5 хоног</p> <p>4 хоног</p> <p>4 хоног</p> <p>4 хоног</p> <p>4 хоног</p> <p>2 хоног</p> <p>2 хоног</p> <p>1 хоног</p> <p>3 хоног</p> <p>1 хоног</p> <p>2 хоног</p> <p>2 хоног</p> <p>1 хоног</p>

3	ЭШ-ний хуралд оролцсон байдал	1.Р.Түвшинжаргал “Бүтээлийн чөлөө авсан”	30 хоног
		2. Э.Золжаргал “Хүүхэд залуучуудын судалгааг” орон нутаг руу явсан	21 хоног
		3.Э.Мөнх-Оргил ОУЭШХ	3 хоног
		4. ҮБТДС-ийн 24 багш нар “Оюутны спорт- Үндэсний эрдэм шинжилгээний эрүүл мэнд, хөгжил дэвшил” ОУ-ын ЭШ-ний онол практикийн хуралд:	2 хоног
		27.Л.Алтанцэцэг	1 хоног
		28.Ш.Бат-Эрдэнэ	1 хоног
		29.Р.Түвшинжаргал	1 хоног
		30.Э.Золжаргал	1 хоног
		31.Р.Лхамсүрэн	1 хоног
		32.Л.Гүндэгмаа	1 хоног
		33.Ц.Цэрэнгаваа	1 хоног
		34.Пүрвээ	1 хоног
		35.Мягмарзул	1хоног
		36. Р.Түвшинжаргал Биеийн тамир, спортын салбарын “Шилдэг судлаач-2018” шалгаруулах эрдэм шинжилгээний бага хурал	1 хоног
		37.ҮБТДС-ийн үүсгэн байгуулагч, Монгол Улсын гавьяат багш, доктор (Sc.D), профессор	
		Г.Лхагвасүрэнгийн нэрэмжит эрдэм шинжилгээний онол практикийн бага хуралд:	1 хоног
		38.Л.Алтанцэцэг	1 хоног
		39. Н.Мягмарзул	1 хоног
		40.Р.Түвшинжаргал	1 хоног
		41.Р.Лхамсүрэн	1 хоног
		42.Б.Мөнгөнтуяа	1 хоног
		43. Д.Шүрэнцэцэг	1 хоног
		44.Л.Алимаа	1 хоног
		45.Н.Баярмагнай	1 хоног
		46.Г.Хажидсүрэн	1 хоног
		47.Ц.Баярсайхан	1 хоног
		48.Д.Өлзийжаргал	1 хоног
		49. Ц.Цэрэнгаваа	
		50.Д.Ганболд	1 хоног
		51. Ш.Бат-Эрдэнэ “НБТСГ-ын Эрдэм шинжилгээний бага хуралд”	1 хоног
		52. Э. Золжаргал“НБТСГ-ын Эрдэм шинжилгээний бага хуралд”	1 хоног
		53. Ш.Бат-Эрдэнэ “Спортын төрөлжсөн дунд сургуулийн эрдэм шинжилгээний бага хуралд ”	1 хоног
		54.Э. Золжаргал “Спортын төрөлжсөн дунд сургуулийн эрдэм шинжилгээний бага хуралд	1 хоног
		55. Р.Лхамсүрэн “МУИС-ийн 90 жилийн ойд зориулсан ЭШ-ний бага хуралд”	1 хоног
		56. Э.Золжаргал БТСГ-ын Эрдэм шинжилгээний бага хуралд	1 хоног


		57. Ш.Бат-Эрдэнэ БТСГ-ын Эрдэм шинжилгээний бага хуралд 58. Э.Золжаргал МУИС-ын Эрдэм шинжилгээний бага хуралд	
4	Сургууль заал ашиглалт	1. Э.Мөнх-Оргил “Аэробикийн сургалтад” 2. Ц.Баярсайхан “Хүүхдийн цэцэрлэг”-ийн багш нарын тэмцээн 3. Д.Баянжаргал “Хүүхдийнхээ 149-р цэцэрлэгийн эцэг эхийн тэмцээн” 4. Б.Мөнгөнтуяа “Хүүгийнхээ болон ангийнх хүүхдүүдэд” 5. Д.Өлзийжаргал “Спорт заал ашигласан”	30 хоног 2 цаг 1 хоног 2 цаг 2 цаг

Мөн цалингийн зээл олгох, тэтгэмж олгох асуудлыг байгууллагаас болон ХААН банкт хамтран шийдвэрлэж өгдөг. Сургууль улсын хэмжээний томоохон тэмцээнд амжилт гаргасан тохиолдолд багш нарыг шагнаж урамшуулдаг. Мөн жил бүр судлаач багш, шилдэг багш, арга зүйч багш зэрэг номинацид өрсөлдүүлж багш нарыг 500000-3000000 төгрөгөөр шагнадаг.

Хүний нөөцийн талаарх хамт олны сэтгэл ханамжийн түвшин:

Шалгуур № 4 нь 4 дэд хэсэгтэй бөгөөд хүний нөөцийн бодлого зохицуулалт дэд шалгуур нь 3,42 оноо, хүний нөөцийн бүртгэл мэдээллийн сан, багш ажилтны хөгжил дэд шалгуурууд 3,21 оноо авсан байна. Харин цалин урамшуулал олголт хамгийн доогуур - 2,68 оноо буюу 67 % байна. Энэ нь нэг талаас улс орны эдийн засгийн хямрал, төгрөгийн ханшны бууралт, мөн хувь хүний амьдралын хязгааргүй эрэлт хэрэгцээ зэрэгтэй холбоотой юм. Хэрэв цалин өндөр өсгөх бол оюутны төлбөрийг нэмэх хэрэгтэй. Гэтэл өрхийн амьжиргааны түвшин, төлбөр төлөх чадвар зэргээс хамаарч оюутны элсэлт буурах хандлага илрэх магадлалтай. Тиймээс маркетингийн хувьд төлбөрийг хэт нэмэх боломжгүйг харгалзах хэрэгтэй байгаа юм.

Зураг 26



SWOT шинжилгээ

ҮБТДС-ийн хүний нөөцийн бодлого, зохицуулалт, хүний нөөцийн хөгжил, хүний нөөцийн бүртгэл, мэдээллийн тогтолцоо, багш ажилтны цалин, урамшууллын давуу тал, сул тал, боломж, эрсдлийг тодорхойлох зорилгоор SWOT шинжилгээ хийсэн юм.

Хүснэгт 16

SWOT шинжилгээ /Хүний нөөц/

Давуу тал (Strength)	<ul style="list-style-type: none">• Спортын өндөр зэрэгтэй багш нар ажилладаг.• Залуу багш нар ахмад багш нараа дагалдаж сургалт-эрдэм шинжилгээний ажилд зөвлөгөө авдаг.• Багш нар өөрийн ажилдаа дур сонирхолтой.
Сул тал (Weakness)	<ul style="list-style-type: none">• Багш нар спортын амжилтыг эрдэм шинжилгээний ажлаас илүүд үздэг.• Хүний нөөцийн мэдээллийн программ хангамж боловсронгуй бус.
Боломж (Opportunities)	<ul style="list-style-type: none">• Сургуулийн удирдлагын зүгээс багш нарын судалгаа, шинжилгээний ажилд анхаарч олон улсын эрдэм шинжилгээний хурлуудыг зохион байгуулдаг.• Багш нарыг гадаад улс орнуудад эрдэм шинжилгээний хуралд оролцоход дэмжлэг үзүүлдэг.• Багш нарын мэдлэг чадвар, гадаад хэл, сурган заах арга зүйг дээшлүүлэхэд чиглэсэн сургалтуудыг сургуулиас зохион байгуулдаг.
Эрсдэл (Threats)	<ul style="list-style-type: none">-Элсэгчдийн тоо буурснаар нэг багшид ногдох ачаалал нэмэгдэх-Багш нар авч буй цалиндаа сэтгэл хангалуун бус байгаа тул өөр ажилд шилжих.

Цаашид сургуулийн зүгээс хүний нөөцийг бэхжүүлэх, сайжруулахын тулд дараах арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлэхээр төлөвлөж байна. Үүнд:

1. Сургалт-судалгаа-спортын сургуулийн хувьд эрдэмтэн, профессоруудын ажлын үр дүнг үнэлж байсан өмнөх шалгууруудад шинжлэх ухааны, сургалтын, спортын хөгжилд оруулж буй хувь нэмрээр нь үнэлэх нарийвчилсан шалгууруудыг нэмж оруулан дэлхийн тэргүүлэх их сургуулиудын жишигт мөрдөж буй дэвшилтэт туршлагыг судлан нутагшуулж, сайжруулан боловсруулж хэрэгжүүлнэ.
2. Олон улсын спортын байгууллагуудтай хамтран төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэх үйл ажиллагаагаа өргөжүүлэхийн тулд гадаадын тэргүүлэх их, дээд сургуулиудын хүний нөөцийн туршлагыг судлан нэвтрүүлж ажиллана.

3. Судалгаа, шинжилгээний ажлын орчин, нөхцлийг сайжруулах, багш бүр орчин үеийн мэдээллийн технологийг ашиглах боломжийг бүрдүүлнэ.
4. Хүний нөөцийн хөгжлийн таатай орчин бүрдүүлж нийгэмд үйлчлэх үүрэг, нийгмийн хариуцлагыг өндөржүүлэхэд анхаарах ба сургалт эрдэм шинжилгээний танхим, спортын заал, лаборатори, номын санг шинэчлэн сайжруулна.
5. Ахмад багш нарт залуу багш нарыг дагалдуулан сургаж улмаар залуу багш нарын эрдмийн зэрэг цол хамгаалахад дэмжлэг үзүүлэх, гадаад, дотоодын спортын уралдаан тэмцээнд оролцоход нь туслан дэмжиж ажиллана.

Дээрх зорилтуудыг хэрэгжүүлэн тус сургуулийн хүний нөөцийн чадавхыг ажил олгогчийн шаардлагыг бүрэн хангахаар сайжруулж, үндэснийхээ спортын хөгжилд зохих ёсоор дэм болж спортын шинжлэх ухааныг хөгжүүлэхэд хувь нэмэр оруулна.

ШАЛГУУР 5. МАТЕРИАЛЛАГ БОЛОН ТЕХНОЛОГИЙН НӨӨЦ

Сургууль нь эрхэм зорилго, зорилгуудаа үр ашигтай хэрэгжүүлэх материаллаг болон технологийн нөөцийг бүрдүүлэх, байнга шинэчлэх бодлого, зохицуулалттай байна.

Тоног төхөөрөмж, анги танхим:

Манай сургууль 2018-2019 оны хичээлийн жилийн байдлаар тодорхой хэмжээний хөрөнгө оруулалт хийж, хувьцаа эзэмшин, “Тулга” ХХК-ийн байранд хичээл сургалт явуулах байртайгаас гадна, хичээлийн байр нь лекц, дадлагын танхим, номын сан, багш нарын ба албан ажлын өрөө, оюутны зориулалтын өрөө танхим, спорт тоглоом, аэробик, бөхийн заал, үндэсний спорт, биеийн тамирын онол арга зүй, анатоми, физиологи, биеийн тамирын эмчилгээний арга зүй, компьютерийн кабинетуудтай. Хичээл сургалт, спортын дасгалжуулалт, оюутны соёл, хүмүүжлийн ажил явуулах бүрэн боломж нөхцөлтэй бөгөөд нэг оюутанд ноогдох ашигтай талбай нь нормтивт хэмжээнд байна.

Тус сургуулийн хичээлийн төв байр “Тулга” ХХК-ийн барилгын нэг, дөрөв, тавдугаар давхарт байрладаг бөгөөд энэ байр 1979 онд ашиглалтанд орсон. Мөн 2001 он ашиглалтад орсон бөх, аэробикийн заалтай. 2599 м² ашигтай талбайтай, оюутны 800 суудалтай юм. Спортын заал 455 м², бөхийн заал 180 м², аэробикийн заал 80 м² чийрэгжилтийн заал 80 м² талбай эзэлж байна.

Лекцийн 6 танхим, дадлагын 10 өрөө, номын сан, багш нарын ба албан ажлын 10 өрөө, оюутны зориулалтын 2 өрөө, нийт 26 өрөө танхимтай хичээлийн байртай болсон нь бидний ажлын үндсэн үзүүлэлт болох сургалтын үйл ажиллагааг хэвийн явуулах илүү аятай нөхцөл бүрдсэн гэж үздэг.

Өнгөрсөн хугацаанд хэтийн төлөвлөгөөндөө тусгагдсан барилга байгууламжийн холбогдолтой шинээр байгуулах, тоноглох объектуудын талаар гол анхаарлаа хандуулан ажиллаж ирлээ.

Тус сургууль нь 2019 оноос шинээр 6 спортын заал бүхий 5 давхар шинэ цогцолбор барихад зориулж ХУД-н 10 дугаар хорооны нутаг дэвсгэрт 5500 кв.м. талбай бүхий газрыг Нийслэлийн газрын албаны дуудлага худалдаагаар 350,9 сая төгрөг төлж худалдаж авсан бөгөөд эзэмшлийн гэрчилгээтэй. Тус барилгын зураг төсөл батлагдаж, цахилгаанд журмын дагуу холбогдсон. Мөн санхүү эдийн засгийн үзүүлэлт, зах зээлийн судалгаа зэрэг зөвлөх үйлчилгээг тусгай мэргэжлийн компаниар хийлгэсэн бөгөөд барилгын хөрөнгө оруулалтыг бүрдүүлж байна.

**ҮБТДС-д одоо ашиглагдаж байгаа болон төлөвлөгдөж байгаа барилга
байгууламжийн үзүүлэлтүүд**

Барилгын өрөө тасалгааны зориулалт	Тоо	Талбай м ²	Нийт талбай м ²	1 хүнд ноогдох стандарт м ²	ҮБТДС-ийн 1 хүнд ноогдох талбай м ²
Одоогийн барилга:					
Хичээлийн анги танхим, кабинет	4	60	240	2.2-2.5	2.5
Хичээлийн анги танхим, кабинет	2	80	160	-	-
Дадлага, лабораторын өрөө	8	40	320	-	-
Спорт тоглоомын заал	1	455	455	2.5	7.6
Бөхийн заал	1	180	180	-	9.0
Аэробикийн заал	1	80	80	-	4.0
Фитнесийн заал	1	80	80	-	4.0
Номын сан, уншлагын өрөө	3	40	120	-	4.0
Захиргаа, сургалт, санхүүгийн алба, багш нарын өрөө	9	40	360	4.0	6
Оюутны зөвлөлийн өрөө	1	20	20	-	-
"Оюутны өргөө" дотуур байр /өрөө/	6	35	384	4.0	4.2
"ҮҮПТ" оюутны дотуур байр /өрөө/	8	18	144	4.0	4.8
Дүн			2399	2.2-2.5	2.67
Шинэ спорт цогцолбор барилга:					
Хичээлийн байр/ Блок А / - 5 давхар	5	648	3240	2.5	2.6
Спортын заал 6 / Блок Б/ 2 давхар 6 заалтай	2	1,512	3024	2.5	3.8
Дүн			6264		2.7
Нийт барилгын талбай			8863		2.9


Тайлбар:

1. Нэг оюутанд ноогдох ашигтай талбай 2,67 м² хангалттай
2. Нэг багшид ноогдох талбай 4,8 м² хангалттай
3. Дотуур байр 1 оюутанд 4,2-4,8 м² хангалттай
4. Ээлж ашиглалтын коэффициент 1,35 байна- хангалттай

Дээрх үзүүлэлтүүдээс үзэхэд сургуулийн нийт оюутны тоо сургуулийн хүчин чадалд тохирсон бөгөөд цаашид оюутны тоог нэмэгдүүлэх боломж харагдаж байна.


Тус сургууль сүүлийн 5 жилд материаллаг баазын зардлаа 488,2 сая төгрөгөөс 1058,7 сая төгрөг болтол нэмэгдүүлсэн байна.

Зураг 27




ҮБТДС-ийн 2014 оноос хойш үндсэн хөрөнгийн дүн 389,98 сая төгрөгөөс 926,5 сая төгрөг болж өссөн байна. Үүнээс 770,0 сая төгрөгийн тоног төхөөрөмж, техник хэрэгслийг худалдан авч сургалтад ашиглаж байгаа ба улмаар эд хөрөнгө, техник хэрэгслийн зардлыг 2,3 дахин нэмэгдүүлсэн байна.

Зураг 28



Манай сургууль сүүлийн 5 жилд бэлтгэлийн хувцас хэрэгсэл, БҮТЭЗ-д 24,2 сая төгрөгөөс 53,7 сая төгрөг зарцуулж 2,2 дахин өссөн байна.

Зураг 29



Засгийн газрын болон хандивын ямар нэг тусламж дэмжлэггүйгээр зөвхөн өөрийн хүч боломж санхүүгийн нөөцдөө тулгуурлан хичээлийн байранд оюутны сурах болон багш, ажилтны ажлын таатай орчин нөхцөлийг бүрдүүлэхийн тулд жил бүр тодорхой хөрөнгө гаргаж сүүлийн 5 хичээлийн жилд 86,8 сая төгрөгийн тохижилт, урсгал болон их засварын ажил хийлээ.

Хүснэгт 18

Сургуулийн барилга, байгууламжийн тохижилт, урсгал болон их засварт зарцуулсан хөрөнгө (хичээлийн жилээр, сая төгрөгөөр)

	Зардлын утга	Он					Дүн
		2014 2015	2015 2016	2016 2017	2017 2018	2018 2019	
1	Спорт тоглоомын заал	2.4	3.0	2.2	3.0	12.0	22.6
2	Бөхийн заал	2.5	3.0	2.0	2.0	4.0	13.5
3	Аэробик, чийрэгжилтийн заал	2.0	2.0	2.0	2.0	2.0	10.0
4	Биеийн тамирын талбай	0.5	1.0	1.0	1.3	1.0	4.8
5	Хичээлийн танхимийн урсгал засвар	8.5	6.0	7.0	8.0	6.4	35.9
Дүн		15.9	15.0	14.2	16.3	25.4	86.8

Тус сургууль нь спортын 1381 төрлийн 208,5 сая төгрөгийн үнэ бүхий тоног төхөөрөмж, хэрэглэл материал ашиглаж байна.

Биеийн тамирын эмчилгээний арга зүйн тэнхим нь багш нарын, лекцийн, дадлагын - 3, фитнесийн заал г.м. өрөө танхимд байрлаж байна. Эмчилгээний арга зүйн хичээлийн материаллаг баазад 75 нэр төрлийн 278 тоо ширхэг бүхий 49,5 сая төгрөгийн хэрэгсэл материал хөрөнгө ашиглаж анатоми, физиологи, массаж, спортын анагаах ухаан, гэмтэл бэртлийн эмчилгээ, нөхөн сэргээлтийн хичээлүүдийг заадаг.

Эрүүл Мэнд, Спортын Яамны Мянганы сорилтын сангийн санхүүжилт, БСШУЯ-ны Шинжлэх ухаан технологийн сангийн санхүүжилтээр авсан биеийн тамир, спортын шинжилгээ судалгааны ажлын зориулалт бүхий спортын сургалтын хэмжил зүйн лабораторийн багаж тоног төхөөрөмжүүд ашиглаж Монгол Улсын үндэсний шигшээ багийн тамирчид болон өсвөр үе хүүхэд залуучуудын бие бялдрын хөгжилт, бэлтгэлжилтийн түвшин тогтоох судалгааны ажлыг зохион байгуулан явуулж байна.

Спортын сургалтын хэмжил арга зүйн лаборатори оюутнуудын спортын чадвар, техник, тактик эзэмших сургалтын болон бие бялдрын хөгжилт, бэлтгэлжилтийн явцад тавьж, дүгнэлт гаргах боломжийг олгож биеийн тамир, спортын сургалтыг шинжлэх ухааны үндэслэлтэй удирдах гадаадын мэргэжлийн сургуулиудын түвшинд сургалт явуулах боломжийг олгох юм.

Онолын хичээлийн сургалтын тоног төхөөрөмж: Сургуулийн захиргаанаас сургалтын төрөлжсөн 10 кабинет, лаборатори байгуулахад онцгойлон анхаарч түүнд хөрөнгө зардлынхаа нэлээд хэсгийг зарцууллаа. Магадлан итгэмжлэгдсэнээс хойших хугацаанд сургууль өөрийн хөрөнгөөр хичээлийн хэрэглэлийг шинэчилж, танхим бүрийг LSD TV, M271X NEC фирмийн проектор, дэлгэц зэргээр тохижуулж хүчин чадлыг нэмэгдүүллээ. Мөн хичээл бүрийн явцыг хянах зорилгоор камержуулж, Сургалтын албанаас нэг зэрэг 30 орчим камераар хянах DVR бүхий дэлгэц байрлуулсан. Нийт 35,5 сая төгрөгийн өртөг бүхий лаборатори, кабинетийг шинээр байгуулав.

Тус сургуулийн хэмжээнд магадлан итгэмжлэгдсэнээс хойш 38 компьютер, сургалт болон албан хэрэгцээнд ашиглагдаж байгаагаас гадна компьютерийн кабинетийг өргөтгөж 20 компьютер шинээр авч, 5 МВ бүхий хурдны интернэтэд холбож, сургалтын төлөвлөгөөний дагуу хичээл заах бүрэн боломжтой болсон.

Сургуулийн дотуур байр: Сургуулийн төлөвлөгөөнд тусгагдсан оюутнуудыг дотуур байраар хангах асуудлыг зохих түвшинд шийдвэрлэж байна. ҮБТДС-ийн хөрөнгөөс “Оюутны өргөө” цогцолбор, 1000 оюутны байранд жил бүр 50 оюутан амьдрах 2 талын гэрээ байгуулж оюутны суух өрөөг тохижуулахад зориулж 2013 онд 42,96 сая төгрөгийг улсын төсөвт оруулж оюутны хүмүүжил, ахуйн орчныг хариуцсан сургуулийн төлөөлөгч багш томилон ажиллуулж байна.

Сургуулийн материаллаг бааз, орчин нөхцлийг сайжруулах зорилгоор 2006 оноос хойш нийлбэр дүнгээр 400 гаруй сая төгрөгийн хөрөнгө оруулалт хийсэн бөгөөд Засгийн газрын болон бусад байгууллагын хандив, зээл тусламж аваагүй зөвхөн өөрийн санхүүгийн нөөц боломж дээр тулгуурлан ажиллаа.

5.2. Мэдээлэл харилцааны технологийн систем

Сургууль компьютерийн сургалтын зориулалтын танхимтай. Компьютерын сургалтын 20 компьютертэй бөгөөд компьютерүүд нь хичээл, сургалт явуулах боломж нөхцлийг бүрэн хангасан программ хангамжийн цогц бүрэлдэхүүнтэй юм. Өргөн хэрэглээний оффисын программ хангамжаас гадна компьютерийг вирусээс хамгаалсан асааж унтраахад төлвөө сэргээдэг (Deep Freeze) программтай, хичээлийн үеэр тодорхой нийгмийн сүлжээ сайтуудын (Facebook, Youtube)

хандалтыг хязгаарлах зориулалтын анги, удирдлагын программтай (NetSupport School) зэрэг орчин үеийн компьютерийн лабораторид тавигдах шаардлагыг программ хангамжийн хувьд бүрэн хангасан. Сургалтын компьютерүүдэд суулгасан программ хангамжийн дэлгэрэнгүй жагсаалтыг дараах хүснэгтэнд үзүүлэв:

Хүснэгт 19

Программын төрөл	Программ хангамжууд
Үйлдлийн систем	<ul style="list-style-type: none"> • Windows 7 Professional Service Pack 1, 32bit
Office багц программ хангамж	<ul style="list-style-type: none"> • Microsoft Access 2010 • Microsoft Excel 2010 • Microsoft OneNote 2010 • Microsoft Outlook 2010 • Microsoft PowerPoint 2010 • Microsoft Publisher 2010 • Microsoft Word 2010 • Microsoft Visio 2010
PDF засварлах, унших программ хангамж	<ul style="list-style-type: none"> • Adobe Acrobat 11 Pro • ABBY FineReader 12 • FoxitPDF • SumatraPDF
Бичих дасгалын программ	<ul style="list-style-type: none"> • Fast Type Mon • Flash Type • Mongolian Typing Trainer
Веб хөтөч	<ul style="list-style-type: none"> • Internet Explorer 11 • Google Chrome • Mozilla Firefox
Зураг, бичлэг засварлах	<ul style="list-style-type: none"> • Adobe Photoshop CS6 • MovieMaker • Paint.net
Видео тоглуулагч	<ul style="list-style-type: none"> • Windows Media Player • VLC Media Player • MPC Media Player
Антивирус	<ul style="list-style-type: none"> • Microsoft Security Essential • Malwarebytes Anti-Malware
Бусад	<ul style="list-style-type: none"> • WinRAR • 7 – Zip • Java • Speccy • Defraggler • CCleaner • Recuva • ImgBurn– CD/DVD burner
Тусгай зориулалтын программ хангамж	<ul style="list-style-type: none"> • NetSupport School – Class Management Software • Deep Freeze 8.23 – Freezing Software

Компьютер, нэмэлт төхөөрөмжүүдийн хүчин чадал, ашиглалтын байдлыг авч үзвэл:

Тус сургуулийн хэмжээнд магадлан итгэмжлэгдсэнээс хойш 38 суурин компьютер сургалт болон албан хэрэгцээнд ашиглагдаж байгаагаас компьютерийн кабинетаа өргөтгөж 20 компьютер шинээр авч бүгд интернетэд холбож, сургалтын төлөвлөгөөний дагуу хичээл заах бүрэн боломжтой боллоо. Кабинетаа шаардагдах хэрэглэл материалаар тоноглож төхөөрөмжийн өмнөх таван жилийн үеэс ахиц дэвшил гарлаа.

Хүснэгт 20

Компьютер, тоног төхөөрөмжийн судалгаа

№	Тоног төхөөрөмж	Хэмжих нэгж	2005 он	2015 он	2018 он
1	Компьютер (хичээлийн)	тоо	16	18	20
2	Компьютер (албан хэрэглээний)	тоо	6	12	18
3	Зөөврийн компьютер	тоо	4	15	22
4	Принтер	тоо	4	8	14
5	Компьютерийн ширээ	тоо	21	25	37

Хүснэгт 21

Сургалтын компьютерийн хүчин чадал

Танхим	Зориулалт	Хүчин чадал, үзүүлэлт
Компьютерийн өрөө(№505)	Багшийн компьютер (1ш)	Acer Veritron M2610 <ul style="list-style-type: none"> • CPU – Intel Core i7-3770 3.40GHz • RAM – 4G DDR3 • HDD – 500 GB • Monitor –19 inch LCD
	Сургалтын компьютер (19ш)	Acer Aspire M1830 <ul style="list-style-type: none"> • CPU – Intel Dual Core i3-3200 3.2GHz • RAM – 2G DDR2 • HDD – 320 GB • Monitor –19 inch LCD

Дотоод сүлжээний үйл ажиллагааны тогтворжил, чанар

Сургуулийн дотоод сүлжээ нь дараах бүтэцтэй байгаа юм.

1. Цахилгаан холбоо компаниас IDSL шугам оруулж шилэн кабелиар интернет хүлээн авна.
2. Тус рөүтер нь 4 болон 5 давхарын өрөө бүрд RJ45 этернет кабелиар салаалсан байна.
3. Өрөө бүр TP Link свитчтэй бөгөөд тухайн өрөөнд байгаа компьютерүүдэд интернетийг түгээж байна. Сургуулийн дотоодод мэдээлэл солилцох дотоод сүлжээ техникийн саатлыг эс тооцвол харьцангуй тогтворжсон бөгөөд харин хэрэглэгчдийн санаачилга, ур чадвараас хамаарах дотоод сүлжээгээ жигд ашиглаж чадахгүй байгаад анхаарах шаардлагатай байна.

Хүснэгт 22

Сургуулийн дотоод сүлжээний техник хангамж

Нэр	Тоо, ширхэг	Байршил, өрөө танхим
TP Link 65Mbps Modem Router	1	5 давхрын коридорт
TP Link Wireless Router	2	– 5 давхрын зүүн жигүүрийн коридорт – 5 давхрын 508 тоот багш нарын өрөөнд байрлана.
TP Link 5 Port Switch	7	– 5 давхарт санхүүгийн өрөө – 5 давхарт багш нарын өрөө – 5 давхарт эмчилгээний багш нарын өрөө – 5 давхарт сургалтын алба – 5 давхарт компьютерийн танхим – 4 давхарт захирлын өрөө – 2 давхарт спорт заалны багш нарын өрөө
TP Link 24 Port Switch	1	– 5 давхарт компьютерийн танхим

ҮБТДС нь Монголын Цахилгаан Холбооны МИКОМ компаниас 5Mbps өндөр хурдтай интернет үйлчилгээ авч сургуулийн оюутан, багш ажилтнуудыг интернетээр хангаж байна. Мөн сургуулийн хоёр жигүүрт байрлах Wireless Router нь утасгүй интернетийг түгээж багш болон оюутнууд ухаалаг гар утас, зөөврийн компьютерээ ашиглан өндөр хурдны интернетэд холбогдох боломж нөхцөл бүрдсэн байна. Speedtest.net сайтаас интернетийн хурдыг шалгаж үзэхэд Download : 5.3 Mbps, Upload: 4.0Mbps байна.

Интернетийн гадаад, дотоод хэвийн орчин нийтээр сайн болсон бөгөөд харин интернетийн мэдээллийг сургуулийн албаны нэгжүүд, багш, ажилтнуудын албан хэрэгцээнд зориулан харилцан солилцох үйл ажиллагаандаа хэрэглэдэг болоход учир дутагдал байгааг хүлээн зөвшөөрөх нь зүйтэй гэж үзэж байна.

Олон нийтийн сүлжээ ашиглах нөхцөл боломжийн бүрдлийн байдал

Багш нар тус тусын өрөөнд байрлах суурин компьютер, зөөврийн компьютер, ухаалаг гар утсаа ашиглан олон нийтийн сүлжээ (Facebook, Twitter, Youtube) сайтууд ашиглан хоорондоо мэдээлэл солилцох, сүүлийн үеийн шинэ мэдээлэл олж авах нөхцөл боломж бүрдсэн гэж үзэж болно. Багш нарын болон сургалтын компьютеруудад дээр Internet Explorer, Mozilla Firefox, Google Chrome гэсэн хамгийн өргөн хэрэглэгддэг веб хөтчүүд суулгасан байгаа.

Номын сан: Номын санг байнга шинэчлэх бодлого, бүтэц, зохицуулалттай байх ба багш, ажилтан, суралцагчдын хэрэгцээнд нийцсэн сургалтын хэрэглэгдэхүүн онлайн мэдээллийн сан бүрдүүлэх цахим болон дижитал технологийг хөгжүүлдэг байна. Монгол улсын “Номын сангийн орчны нөхцөл, үйл ажиллагаанд тавих шаардлага /MNS574:2007/ стандартыг чиглэл болгон ажиллаж байна. Сургууль нь сургалт, судалгааны үйл явцад олон улсын мэдээллийн сүлжээ, нээлттэй эх үүсвэрүүдийг ашигладаг байна.


Үндэсний Биеийн Тамирын Дээд Сургуулийн номын сан нь 1991 онд анх байгуулагдсан. Өнөөгийн байдлаар 12399 мянган ном, сурах бичигтэй. Үүнээс нэг

оюутанд ноогдох номын тоо 19,1 ширхэг, нийт талбайн хэмжээ 260м², уншлагын танхим 164 уншигчийн суудалтай болно. Мөн ажлын өдөр хичээлийн хуваарийн дагуу хичээл орсны дараа 15:00 цагаас манай оюутнууд 503, 504, 505, 506, 507, 511 хичээлийн танхимуудад ном унших, хичээлээ байнга давтаж байдаг. ҮБТДС-ийн номын сан мэргэжлийн номын сангийн 1 орон тоотой ажилладаг.

Хүснэгт 23

Д/д	Танхим	Анги танхим	Эзлэхүүн /м ² /	Уншигчийн суудал /ширхэг/
1	Уншигчийн танхим	408	60м ²	60
2	Компьютерийн лаборатори	505	40м ²	20
3	Уншигчийн танхим	400	60м ²	72
4	Магистрын эрдэм шинжилгээний танхим	409	40м ²	12
5	Номын фонд	406	60м ²	
Бүгд			260м ²	164

Зураг 30



Номын сангийн үйл ажиллагаа: 2014-2018 оны хугацаанд хийгдсэн нэгдсэн

бүртгэлийн статистик мэдээллээр номын фондын бүтэц (5 жилийн байдлаар) дараах байдалтай байна.

Зураг 31



Номын сангийн орчин нөхцөл:

- Тав тухтай орчин нөхцлийг бүрдүүлэх
- Эрэлт багатай ном, сурах бичгийг эргэлтэд оруулах гарцыг олж хэрэгжүүлэх
- Фонд бүрдүүлэлтийг оновчтой зохион байгуулах зорилт тавин ажилладаг.

Хүснэгт 24

Номын сангийн орчин нөхцөл, үйл ажиллагааны талаар авсан

судалгааны дүн (2017 он)

Д/д	Стандарт	Заалт	Үзүүлэлт		Чанар	Орчин нөхцлийн талаарх үнэлгээ
			Биелэгдсэн	Биелэгдээгүй		
1	Номын сангийн орчин нөхцөл -Нийтлэг шаардлага -Номын сангийн байрны гэрэлтүүлэг -Номын сангийн барилгын дулаан, чийгшил	4	+		Сайн	-Агааржуулалтын систем /дулаан, чийгшлийн хэмжээ, агаар солилцоо сайжирч тоосжилт, бохирдолт багассан.
2	Уншигчдад үйлчлэх байрны орчин	5	+		Сайн	Сайжирсан
3	Фонд хадгаламжийн орчин	6	+		Сайн	Фонд хадгаламжийн орчин сайжирч, ном сэлбэн засах тоног төхөөрөмжтэй болсон.
4	Номын сангийн тоног төхөөрөмж, техник хэрэгсэлд тавих шаардлага	8		-	Дунд	Номын сангийн үйлчилгээнд орчин үеийн тоног төхөөрөмж нэвтрүүлэх зарим шаардлага байгаа.
5	Номын сангийн үйлчилгээнд тавих шаардлага	9	+		Сайн	Номын сангийн үйлчилгээнд илүү дэвшилтэд арга барил нэвтрүүлэх

Төлөвлөлт: ҮБТДС-ийн номын сан нь жилийн ажлын төлөвлөгөөг хичээлийн жилийн эхэнд гаргаж, захирлаар батлуулан мөрдөж ажилладаг. Төлөвлөгөөг номын сангийн зохион байгуулалт, шинэ ном худалдан авах, ном сэргээн засварлах гэсэн гурван чиглэлээр гаргадаг.

Номын сангийн үйлчилгээ, тохижилт, ном сэлбэн засах зардалд тодорхой хэмжээний төсөв тогтмол зарцуулсаар ирсэн.

Номын сангийн баяжилтийг хийхтэй холбогдуулан шаардлагатай номын судалгааг гарган төсөвлөлтийг уян хатан төлөвлөх, мэргэжлийн чиглэлээс бусад хамгийн их худалдаалагдаж байгаа номын баяжилт хийх шаардлагатай байдаг.

Цахим номын сангийн хөмрөгийг байнга нэмэгдүүлэн дижитал номын сангийн шинэ техник, технологийг үйлчилгээндээ нэвтрүүлж, мэдээллийн эх үүсвэр харилцан солилцож байна. Lib4U PC Version 1.2 нь номын сангийн цогц програм хангамж юм. Lib4U PC Version 1.2 программ нь электрон номын сангийн бүх ном, товхимол, гарын авлага хэвлэмэл материалыг нэгдсэн бүртгэлд оруулах, уншигчийн бүртгэл, электрон каталогит хайлт хийх, бар код хэвлэх, номыг уншлаганд гаргах, буцаан авах гэх мэт үйлдүүдийг гүйцэтгэдэг. Тус программд нийт ном, сурах бичиг бүрэн бүртгэгдсэн.

Уншигчийн сэтгэл ханамжийн судалгаа:

Бид номын сангийн орчны нөхцөл үйл ажиллагаанд тавигдах шаардлагыг стандартын дагуу хэрхэн хангаж байгаа тухай сэтгэл ханамжийн асуудлаар уншигч оюутнуудаас санал авч судалгаа явуулсан юм. Энэхүү үйлчлүүлэгчдийн ерөнхий сэтгэл ханамжийн судалгааг номын сангийн практикт Ликертын 5 баллын хэмжээс гэж нэрлэдэг бөгөөд энэ хэмжээсээр хэрэглэгчийн ерөнхий сэтгэл ханамжийг 5 баллын системээр судлан дүгнэдэг юм.

Энэхүү системийг ашиглан хэрэглэгчдийн сэтгэл ханамжийн судалгааг өөрийн сургуулийн I-IV ангийн 213 оюутнаас судалгаа авахад дараах хариултыг өгсөн. Энэхүү судалгааны дүнг дор өгүүлье.

Зураг 32



Жинхэнэ чанарыг үнэлэхдээ Ликертын 5 баллын хэмжээсийг хамгийн доод тоо 1-ээс дээд тоо 5 хүртэл шатласан шалгуураар дүгнэсэн юм. Хэрэглэгчдийн таньд үйлчилж буй номын сангийн үйлчилгээний чанарыг бүхэлд нь хэрхэн дүгнэх вэ? гэсэн асуултад 1-маш муу, 2-хангалтгүй, 3-дунд зэрэг, 4-хангалттай, 5-маш сайн гэсэн 5 баллын хэмжээсийн үнэлгээ өгдөг.

Дээрх зураглалаас харвал нийт уншигч, хэрэглэгчдийн 58% маш сайн гэж дүгнэжээ.

Цахим сан хөмрөгийн баяжилт, ашиглалтын түвшин

Цахим сан хөмрөгийг байнга нэмэгдүүлэн дижитал номын сангийн шинэ техник, технологийг үйлчилгээндээ нэвтрүүлж, мэдээллийн эх үүсвэр харилцан солилцдог байна. ОХУ-ын Улсын төв номын сангийн фондын <http://www.rsl.ru/>, <http://www.dissercat.com/>, <http://infolio.asf.ru/>, [/Dissertation/Vidy-dissertacii.php](http://Dissertation/Vidy-dissertacii.php), www.teoriya.ru, сайтаас мэдээллийг авдаг.

Мөн www.legalinfo.mn/, econtent.edu.mn холбоосуудыг ҮБТДС-ийн вэб сайтад номын сангийн хуудсандаа оруулж өгсөн.

Гадаад, дотоод захиалгат сэтгүүлүүд, “Биеийн тамирын онол арга зүй” сэтгүүлийн дугааруудаас цахим хэлбэрт оруулан сургуулийнхаа вэб сайтад байршуулж эхлээд байна.

Санхүүгийн чадавх, төсвийн гүйцэтгэлд хийсэн дүн шинжилгээ

ҮБТДС төсвөө хичээлийн жилээр гаргадаг бөгөөд гүйцэтгэлийн чанар үр дүнг улирал (хагас жил), жилээр нь дүгнэж тооцдог.

ҮБТДС-ийн 2010-2018 оны хичээлийн жилээр батлагдсан төсөв төлөвлөгөө, гүйцэтгэлд хийсэн дүн шинжилгээг харуулъя.


Хүснэгт 25

ҮБТДС-ийн 2010-2018 оны хичээлийн жилийн төсвийн төлөвлөгөө, гүйцэтгэл

Хичээлийн жил	2010 - 2011	2011 - 2012	2012 - 2013	2013 - 2014	2014 - 2015	2015- 2016	2016- 2017	2017- 2018
Төсвийн орлогын төлөвлөгөө (сая ₮)	606.70	878.15	1125.30	1090.0	1080.0	803.7	916.5	1051.8
Төсвийн гүйцэтгэл (сая ₮)	592.70	904.00	1071.93	947.93	950.43	779.1	913	1055.8
Зөрүү	14.00	-25.85	53.37	142.07	129.57	24.60	3.50	-4.00

Хүснэгтээс харахад дараах үр дүн гарч байна. Төсвийн төлөвлөгөөний дүнгээс төсвийн гүйцэтгэл нь сүүлийн 5 хичээлийн жилд доогуур үзүүлэлттэй байна.

Зураг 33



Дээрх үзүүлэлтийн шалтгаан нь:


1. Хичээлийн жилийн эхэнд /09 сарын 01-ний өдөр/ бүртгэгдсэн суралцагчдын тооцоогоор төсвийн орлогыг төлөвлөдөг, харин хичээлийн жилийн төгсгөлд суралцагчдын тоо тодорхой хэмжээгээр буурч өөрчлөгддөг. Мөн оюутны сургалтын төлбөр дутуу төлөгддөг.

2. 2012-2013 оны хичээлийн жилд төсөв нэмэгдсэн. Учир нь, ЗГ-ын 19-р тогтоолын дагуу оюутны сар бүрийн үндэсний тэтгэлэг 70200 төгрөгийг сургуулийн дансаар дамжуулан олгогддог болсон, мөн сургалтын төлбөр 10% нэмэгдсэнтэй холбоотой

3. 2013-2014 оны хичээлийн жилд төсөв буурсан. Учир нь, ЗГ-ын 71-р тогтоолын дагуу оюутны сар бүрийн үндэсний тэтгэлэг 70200 төгрөгийг сургуулийн дансаар дамжуулахгүй, шууд оюутны банкин дахь дансанд сургалтын төрийн сангаас шилжүүлэн олгогдох болсонтой холбоотой

4. Төсөв оновчтой боловсруулагдаж хэрэгжсэний улмаас сүүлийн 2016-2017, 2017-2018 онд төсвийн дүн эргээд өссөн дүнтэй байна.

Зураг 34



Дээр дурьдснаар тус сургууль төсөв төлөвлөгөөгөө 3 үе шаттайгаар боловсруулдаг. **1 дэх шатанд:** сургалтын алба, санхүүгийн алба, спорт клуб зэрэг салбар нэгжүүдийн төлөвлөгөө төсвийг цуглуулах үйл ажиллагаа хийгддэг. Төсөв боловруулах **2 дахь шатанд:** Сургуулийн салбар нэгжүүдээс ирсэн төсвийг нэгтгэх, зах зээлийн бодит ханш, инфляцийн түвшин, сургуулийн орлогын төлөвлөгөө, төсөвтэй харьцуулах, уялдуулах, чанарын дотоод хяналт, баталгаажуулалтын үйл ажиллагааны явцад төсвийн дүн, бүтэц өөрчлөгдөх боломжтой. **3 дахь шатанд:** Хичээлийн жилийн хянаж боловсруулсан төсвийг Удирдах зөвлөлөөр хэлэлцүүлж баталгаажуулах явцад ч төсөв тодорхой хэмжээгээр өөрчлөгдөж болно.

Төсвийн төлөвлөлтөд гарсан ахиц, дэвшил: Хичээлийн жилийн явцад төлөвлөлт, төсөвлөлтийг зах зээлийн бодит үнэлгээтэй уялдуулснаар төсвийн зардал хэмнэгдэх боломж гарч оюутны сургалтын төлбөрийг 2015-2016 оны хичээлийн жилд нэмэхгүйгээр үйл ажиллагаагаа явуулах боломж бий болсон.

- Төсвийн хамгийн их буюу 32,2-46,0 хувийг сургалттай холбоотой зардал, 19,4-25,7 хувийг ашиглалтын зардал, 4,4-30 хувийг сургалтын тоног төхөөрөмж, үндсэн хөрөнгө худалдаж авах зардал, бусад зардлыг захиргаа, оюутны үйлчилгээ, эрдэм шинжилгээний зардлууд эзлэж байна.
- 2011-2012 оны хичээлийн жилд Засгийн газрын 19-р тогтоолын дагуу оюутан бүрт үндэсний болон урамшууллын тэтгэлэг сургуулийн харилцах дансаар дамжуулан олгогддог байсантай холбоотой оюутны тэтгэмж үйлчилгээний зардал 47,8% болж бусад зардлаас илүү өссөн үзүүлэлттэй байгаа юм.
- 2012-2013 оны хичээлийн жилээс эхлэн эдийн засгийн нөхцөл байдал, инфляцийн түвшин зэргээс хамааран багш ажилчдын цалинг нэмэгдүүлэх шаардлагаас хамаарч сургалттай холбоотой зардал 489,0 сая болж нэмэгдсэн байна.
- 2015-2016 оны хичээлийн жилд тус сургуулийн өргөтгөлийн барилгын газар эзэмшихтэй холбоотой 350 сая төгрөгийн хөрөнгө оруулалтыг сургуулиас санхүүжүүлсэн бөгөөд энэхүү “сургууль хөгжүүлэх” зардал 30% хүртэл өссөн юм.
- 2017-2018 оны хичээлийн жилд сургуулийн шинэ барилгын газрыг өргөтгөхөд нийслэлийн газрын албаны дуудлага худалдаанд 50,9 сая төгрөг төлж сургууль хөгжүүлэх сангийн зардал өмнөх оныхоос 4,6-8,9% болж өссөн, мөн Японы хүүхдийн хөгжлийн төвийн санхүүжилттэй хамтарсан төсөл хэрэгжиж байгаатай холбоотой эрдэм шинжилгээний зардал 1,1% -5,9% хүртэл өссөн.

ҮБТДС-ийн 2010-2018 оны хичээлийн жилийн төсвийн хуваарилалтыг авч үзье.

Хүснэгт 26

Сургуулийн төсвийн хуваарилалт

Зардал,%	2010-2011	2011-2012	2012-2013	2013-2014	2014-2015	2015-2016	2016-2017	2017-2018
Сургалттай холбоотой	32.2	19.8	45.6	46.0	43.9	32.9	48.1	46.0
захиргаа аж ахуйн	12.8	7.7	14.8	10.8	12.7	8.3	11.5	11.8
Ашиглалтын зардал	19.4	14.1	19.1	21.3	25.7	17.9	24.0	20.6
Оюутны үйлчилгээ	9.5	47.8	16.5	9.3	11.1	5.9	6.9	6.9
Сургууль хөгжүүлэх сан	24.8	9.6	10.4	10.0	4.4	30.0	4.6	8.9
Эрдэм шинжилгээний зардалд	2.2	1.1	3.1	2.6	2.0	3.4	4.9	5.9


Тайлагналтын тогтолцооны төлөвшилтийн байдал:

- Сургуулийн үйл ажиллагааны тайланг сар, улирал, хичээлийн жилээр тогтмол гаргадаг.

- Оюутны сурлагын үнэлгээг улирал, хичээлийн жилээр хичээл бүрээр тогтмол гарган сургалтын албанд хүргүүлдэг.
- Ахиц дэвшилийн тайланг жил бүр электрон болон баримтаар ДБМИҮЗ-д гаргаж өгдөг.
- Сургуулийн багш, суралцагчдын, төгсөгчдийн жилийн тоон мэдээ, төсөв, зардал, хөрөнгийн тайлан зэргийг ДБ 1-11, СУ-17 маягтуудаар БСШУЯ-д тушаадаг.
- Санхүүгийн тайлан балансыг СБД-ийн санхүүгийн хэлтэст, Жил улирлын санхүүгийн тайлан балансыг Санхүүгийн хэлтсийн <https://e-balance.mof.gov.mn/> сайтаар илгээдэг.
- НДШ-ийн тайланг НТХэлтсийн www.ndaatgal.mn/nd8/сайтаар мэдээлдэг.

Татварын тайлан <http://www.mta.mn/> интернэт сайтаар, жил бүр онлайн болон баримт бичгээр тайлагнан баталгаажуулдаг болсон юм. Материаллаг болон технологийн нөөцийн асуудлаар хамт олноос өгсөн өөрийн үнэлгээг танилцуулъя.

Зураг 35



Шалгуур 5-ын сэтгэл ханамжийн байдал буюу өөрийн үнэлгээний байдлаас харахад санхүүгийн нөөц, тогтвортой байдал, технологийн нөхцөлд дээд үнэлгээ (3,53-3,68 оноо) өгсөн байна. Харин олон улсын мэдээллийн сүлжээ ашиглах нөхцлийг бүрдүүлэх, цахим сан хөмрөг, дижитал номын сангийн техник технологи зэрэгт 2,83 оноо өгчээ. Эндээс харахад хэдийгээр ҮБТДС –ийн интернэт сүлжээг хангалттай, WIFI орчин бүрдсэн байхад багш нарын үнэлгээ доогуур байгаа нь ашиглалт дутмаг, багш нарын компьютер ашиглах ур чадварын түвшин ямар байгааг харуулж байна гэж дүгнэж болохоор байгаа юм.

SWOT шинжилгээ

ҮБТДС-ийн материаллаг болон технологийн нөөцийн давуу тал, сул тал, боломж, эрсдлийг тодорхойлох зорилгоор SWOT шинжилгээ хийлээ.

Хүснэгт 27

SWOT шинжилгээ /Материаллаг болон технологийн нөөц/

<p>Давуу тал</p> <ul style="list-style-type: none"> • Хичээлийн байртай, цаашид өргөтгөл барих төсөл хэрэгжиж байна. • Биеийн тамирын сургалтын иж бүрэн техник тоног төхөөрөмж, хувцас хэрэгсэл спортын төрөл бүрээр хангагдсан. • Мөн онолын хичээлийн проектор, телевиз, техник хэрэгсэл сайтай. • Спортын салбарын эрдэм шинжилгээ, судалгааны багаж төхөөрөмж хангалттай • Өөрсдийн хүчээр мэргэжлийн иж бүрэн сурах бичиг, тогтмол гаргадаг БТСОАЗ сэтгүүлтэй Гадаад дотоодын сургалтын мэргэжлийн сурах бичиг, сэтгүүлээр хангагдсан. • Өндөр хурдны шилэн кабель бүхий сүлжээтэй, компьютер, техник хэрэгсэл, хамгаалалт ажиглалтын камер суурилагдсан. 	<p>Боломж</p> <ul style="list-style-type: none"> • Биеийн тамир спортын бэлтгэл сургалтыг явуулах тав тухтай орчин бүрдсэнээр, чанартай боловсрол эзэмших боломжтой. • Тамирчидын бэлтгэл сургуулилтын түвшинг тогтоох иж бүрэн судалгаа шинжилгээний ажлыг явуулснаар оюутнуудын давуу, сул талыг нь илрүүлж, цаашид шинжлэх ухааны үндэслэлтэйгээр сургалт дасгалжуулалтыг явуулж ур чадвараа нэмэгдүүлэх боломжтой. • Мэргэжлийн сурах бичиг, сэтгүүл, өндөр хурдны интернэт ашигласнаар орчин үеийн мэргэжлийн мэдээллийг шуурхай авч сургалтандаа ашиглах боломжтой.
<p>Сул тал</p> <ul style="list-style-type: none"> • Биеийн тамир спортын сургалтын хэрэглэл иж бүрэн техник тоног төхөөрөмж, хувцас хэрэгсэл спортын төрөл бүрээр хангагдах нь зардал их шаарддаг. • Мөн онолын хичээлийн проектор, телевиз, техник хэрэгсэлийн эвдрэл гарч засвар үйлчилгээний зардал их гардаг. 	<p>Эрсдэл</p> <ul style="list-style-type: none"> • Биеийн тамир спортын сургалтын хэрэглэл материалын элэгдэл хорогдол өндөртэй тул зардал ихсэх бөгөөд сургалтын төлбөрийн хэмжээнд нөлөөлнө. • Спортын тоног төхөөрөмжид засвар үйлчилгээ шинэчлэл хийхгүй бол хичээллэгчид бэртэж гэмтэх магадлалтай.

Цаашид сургуулийн зүгээс материаллаг ба технологийн нөхцлийг бэхжүүлэх, сайжруулахын тулд дараах арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлэхээр төлөвлөж байна. Үүнд:

- Сургуулийн шинэ өргөтгөл барилгыг барьж ашиглалтад оруулах
- Жил бүр үндсэн хөрөнгө, техник тоног төхөөрөмжийн бүрэн бүтэн байдал, ашиглалтын явцыг шалган дүгнэж шинэчлэх, сайжруулах арга хэмжээ авна.
- Оюутнуудыг спортын иж бүрэн хувцас хэрэгслээр хангах, сурах бичиг нэмж боловсруулан гаргах, БТСОАЗ сэтгүүлийн багтаамж, захиалгыг нэмэгдүүлнэ.

ШАЛГУУР 6. СУРАЛЦАГЧДАД ЧИГЛЭСЭН ҮЙЛЧИЛГЭЭ

Сургууль нь суралцагчдад хувь хүний хөгжилд нь болон амжилттай суралцахад нь тохирсон үйлчилгээг үр дүнтэй үзүүлдэг байна.

6.1. Суралцагчдад чиглэсэн үйлчилгээний бодлого, зохицуулалт:

ҮБТДС-ийн дүрэмд зааснаар суралцагч нь шаардлага хангасан хичээлийн байр, талбай, номын сан, лаборатори, интернетийн сүлжээ, лабораториор хангуулах эрхтэй бөгөөд сургуулийн зүгээс сургалт, эрдэм шинжилгээний ажил, спортын уралдаан тэмцээнд амжилт гаргасан оюутныг урамшуулан дэмжих үүрэг хүлээсэн байдаг юм.


Манай сургуулийн онцлог бол өөрийн сонгосон спортын төрлөөрөө хувь хүнийхээ буюу мэргэжлийн хөгжлийг олж авдагт байдаг юм. Ийм учраас сургуулийн захиргаа суралцагч бүрийг аль болохоор спортын олон төрлийн уралдаан тэмцээнд байнга оролцуулж байх, энэ талын нөхцлийг нь сургалтын бааз болон хөрөнгө оруулалтын талаас нь дэмжих бодлого баримтлан ажиллаж ирсэн. Энэ агуулгаар суралцагчдад чиглэсэн төсөв, зардлын талаарх мэдээллийг дараах үзүүлэлтээр харуулъя.

Хүснэгт 28

2013-2018 оны хичээлийн жилд суралцагчдад чиглэсэн арга хэмжээний зардал \мянган төгрөгөөр

№	Хийгдсэн ажлууд	2013-2014	2014-2015	2015-2016	2016-2017	2017-2018	Дүн	
1	Бичиг хэргийн төсөв	81,0	85,7	95,0	107,0	135,0	503,7	
2	Уламжлалт тэмцээн уралдаан	"Волейболын Лиг"-ийн САШТ	270,0	295,5	295,0	397,5	487,5	1,745,5
3		"Жудо Үндэс кап" нээлттэй тэмцээн	377,0	377,0	1,000,0	951,5	1,485,5	4,191,0
4		"Сагсан бөмбөг"-ийн САШТ	250,0	288,0	660,0	427,5	517,5	2,143,0
5		"Чөлөөт бөх"-ийн САШТ	350,0	400,0	400,0	829,0	829,0	2,808,0
6		"Үндэсний бөх"-ийн САШТ	20,0	56,0	34,0	92,0	120,0	322,0
7		"Хөнгөн атлетик"-ийн САШТ	-	-	-	363,0	363,0	726,0
8		Урлагийн үзлэгийн арга хэмжээ	282,6	320,0	469,5	424,5	424,5	1,921,1
9	Шинэ жилийн арга хэмжээ	2,900,0	5,310,0	4,764,8	4,007,7	7,226,0	24,208,5	
10	Эрдмийн баярын үйл ажиллагаа	146,0	180,0	240,0	460,0	460,0	1,486,0	
Дүн		4,676,6	7,312,2	7,958,3	8,059,7	11,588,0	39594,8	

Суралцагчдад үзүүлсэн үйлчилгээний зардлын өсөлтийг графикаар харуулбал: /2013-2018 он/



Биеийн тамир, спортын чиглэлээр улс, нийслэлд зохион байгуулагдаж буй томоохон уралдаан, тэмцээн, өдөрлөгт оролцсон болон зохион байгуулсан үйл ажиллагаа, Монгол Улсын хүн амын эрүүл аж төрөх ёсыг төлөвшүүлэх, эрүүл мэндийг бэхжүүлэх зорилгоор явагдаж байгаа спорт, олон нийтийн үйл ажиллагаанд мэргэжлийн зүгээс туслан идэвхтэй оролцож ирлээ. Үүнд:

- Нийслэлийн Засаг даргын дэмжлэгтэйгээр зохион байгуулдаг “Дуулиан- 2020” тэмцээнд “Их талын дуулиан ТББ”-тай хамтран ажиллаж жил бүр тэмцээнийг зохион явуулж 40-50 байгууллагын 10.000 гаруй тамирчид нэг жилд оролцов.
- “Оюутан залуучуудын бие бялдрын боловсролыг дэмжих” сэдэвт биеийн тамирын мэргэжлийн их, дээд сургуулиудын уралдааныг БТСГ-аас зохион явуулахад оролцон 2 удаа түрүүлэв. Тэмцээнд 5 их, дээд сургуулийн 600 гаруй оюутан оролцов.
- Улаанбаатар хотын нэрэмжит олон улсын гүйлтийн тэмцээнийг жил бүр зохион байгуулахад оролцохоос гадна оюутнуудаа оролцуулан алт, мөнгө, хүрэл медаль хүртэв. Тэмцээнд жилд 20.0-30.0 мянган хүн оролцдоггоос гадна гадаадын тамирчид, элчин сайдын яамдууд, гадаадаас манайд ажиллаж байгаа ажилчид өргөнөөр оролцдог.
- Төрийн бус байгууллагаас зохион явуулж байгаа “Зүрхээ хайрлая” биеийн тамирын өдөрлөгт нийт 30.0 мянган хүн идэвхтэй оролцож, мэргэжлийн туслалцаа үзүүлж, эрүүл мэндийн талаар сурталчилгаа хийж, спортын үзүүлэн тоглолт хийдэг.

- Жил бүр Япон улсын элчин сайдын яамнаас зохион байгуулдаг “Тал нутгийн марафон” ОУ-ын марафон гүйлтийн тэмцээнд сургуулийн оюутнуудаа хамруулан бусад сургуулийг манлайлан оролцдог.
- Монголын болон олон улсын спортын холбоодоос хамтран зохион байгуулдаг томоохон тэмцээн уралдаанд жил бүр сургуулийнхаа нийт оюутнуудыг спортын чиглэл бүрээр оролцуулж амжилт гаргаж, ерөнхий зохион байгуулалтад хамтран ажиллах, мэргэжлийн шүүгчдийг оролцуулах, хөгжөөн дэмжих гэх мэт бусад хэлбэрээр идэвхтэй оролцдог.
- “Бие бялдрын хүмүүжил-олимпийн боловсрол-их спорт” сэдэвт олон улсын эрдэм шинжилгээ, онол-практикийн бага хурлуудад сургуулийн багш, оюутнууд жил бүр амжилт гарган оролцож байна.

6.2. Суралцагчийн хөгжил. *Суралцагчдын төсөл, судалгааны ажилд оролцох, оюутан солилцоонд хамрагдах, тэдний идэвх, санаачлага, оролцоог дэмжихэд чиглэсэн үйл ажиллагааг системтэйгээр зохион байгуулдаг байна.*

Төсөл, судалгаанд оролцдог оюутан, суралцагчдын тоо, үр дүнг илтгэе.

Манай сургууль 2010-2016 онд АНУ-ын мянганы сорилтын сан, ОХУ-ын Ломносовын нэрэмжит Москвагийн их сургууль, БСШУЯ-тай хамтран “Монгол хүүхдийн шалгуур үзүүлэлт”, “Идэвхтэй хөдөлгөөнөөр саад болж байгаа бэрхшээлүүдийг судлах”, “Халдварт бус өвчин, осол гэмтэлд өртсөн хүмүүст зориулсан эрүүлжүүлэн чийрэгжүүлэх эмчилгээний биеийн тамирын хичээлийг зохион байгуулж, хөтөлбөр боловсруулж, эрүүл мэндийн боловсрол олгох”, “Хүүхэд, өсвөр үе, залуучуудын бие бялдрын хөгжлийн орчин үеийн чиг хандлага”, “тамирчдын морфофункциональ онцлог бүрэлдэхэд угсаа зүй, экологи болон удамшил зүйн чиг хандлага” зэрэг төслүүдийг хэрэгжүүлсэн юм. “Дасгал хөдөлгөөн хүүхдийн бие бялдар, танин мэдэхүй болон сэтгэн бодох чадварт хэрхэн эерэгээр нөлөөлж байгааг судлах Монгол-Японы хамтарсан төслийг 2018 оны 02 дугаар сараас эхлэн одоог хүртэл амжилттай хэрэгжүүлж байна.

Эдгээр төслүүдийн хүрээнд Улаанбаатар хот, аймаг орон нутагт явуулсан судалгаанд манай сургуулийн оюутнууд хамрагдсан юм.

-Оюутан солилцоо, төсөл, хөтөлбөрийн талаар авч үзвэл:

ҮБТДС хоёр талын хамтын ажиллагааны гэрээний дагуу сүүлийн жилүүдэд БНХАУ-ын ӨМӨЗО, ОХУ-ын Тува улс, БНСУ-аас оюутан, магистрант хүлээн авч сургаж ирсэн бөгөөд тус сургуулийн нэг онцлог бол олимп, дэлхий, тив, олон улсын тэмцээнд бэлтгэх, оролцох баг, тамирчин оюутнуудын бэлтгэл сургалтыг харилцан зохион байгуулж байдаг оршино. Энэ чиглэлээр оюутан-тамирчдын бэлтгэл сургалтын чиглэлээр сүүлийн жилүүдэд зохион байгуулсан зарим баримтыг дор өгүүлье.

Үндэсний спорт, мэргэжлийн тэнхимийн чөлөөт бөхийн спорт клубын баг, тамирчид сүүлийн жилүүдэд дараах улсуудын баг, тамирчидтай хамтран ажиллаж ирлээ. Үүнд:

- БНСУ-ын Ханнам Их Сургуулийн спорт клубын баг, тамирчидтай Улаанбаатар хотноо хамтарсан бэлтгэл хийж нөхөрсөг уулзалт хийсэн. (2005 он)
- БНСУ-ын Бөхийн холбоотой Улаанбаатар хотод (2006 он) хамтарсан

- бэлтгэл хийж тэмцээнд оролцов.
- БНСУ-ын Сүүл хотын Бучионы залуучуудын шигшээ багтай хамтарсан бэлтгэл хийж тэмцээнд оролцсон. (2008 он)
 - ҮБТДС-ийн чөлөөт бөхийн баг, тамирчид 2011 онд БНЭУ-д уламжлал болгон зохион байгуулагддаг “Хари рам” тэмцээнд урилгаар оролцсон.
 - Манай баг АНУ-ын Калифорни мужийн “Менло Коллеж”-ийн багтай бэлтгэл хийж тэмцээнд оролцсон.
 - АНУ-ын үндэсний шигшээ багтай хамтарсан бэлтгэл хийж тэмцээнд оролцож байв.
 - БНСУ-ын Чусоны Их Сургуулийн спорт клубтэй хамтарсан бэлтгэл хийж (2012 он. Чусон хотод) тэмцээнд оролцсон.
 - Япон Улсын Кокушикан Их Сургуулийн баг, тамирчид 2013 онд Улаанбаатар хотод хамтарсан бэлтгэл хийж тэмцээнд оролцов.
 - 2015 оны 10-р сарын 2-оос 27-ны өдөр БНХАУ-ын ӨМӨЗО-ны Хөх хотын чөлөөт бөхийн гуравдугаар дэсийн шигшээ багтай хамтарсан бэлтгэл хийж тэмцээнд оролцсон.
 - 2014 онд АНУ-ын спортын бэлтгэлийн төвд 10 хоног бэлтгэл хийж тэмцээнд оролцсон.
 - 2009, 2011, 2015 онд ОХУ-ын Красноярск хотноо уламжлал болгон зохион байгуулагддаг И.Ярыгин, Д.Миндиашвили нарын нэрэмжит тэмцээнүүдэд оролцож байв.
 - Жил бүр ОХУ-ын Буриад Улсын Чөлөөт бөхийн холбоотой хамтран бэлтгэл хийж тэмцээнд оролцдог.
 - 2013 он 10-р сард БНАСУ-ын Нийслэл Пхеньян хотод тус улсын Армийн спорт клубтэй 26 хоног хамтарсан бэлтгэл хийж тэмцээнд оролцсон.
 - 2016 оны нэгдүгээр сард ОХУ-ын Саха (Якут) Улсын Спортын дээд зэрэглэлийн сургуулийн багтай манай сургуулийн 1 дасгалжуулагч, 5 тамирчин 25 хоногийн бэлтгэл хийж, тэмцээнд оролцсон.
 - Манай баг, тамирчид 2016 оны 4-р сард Швед Улсын баг тамирчидтай Улаанбаатар хотноо Олимпийн эрх авах олон улсын тэмцээний бэлтгэл хийж тэмцээнд оролцсон болно.
 - Манай баг, тамирчид олон улсын тэмцээн уралдаан, бэлтгэл сургуулиулалтад хамрагдан амжилттай оролцсоор байна.
 - 2017 онд Хятадын Бээжин хотын Биеийн тамирын их сургуультай хамтран ажиллах хамтын ажиллагааны хүрээнд Спортын сэтгэл судлал мэргэжлээр магистрантурт 2016 оны төгсөгч Д.Шинэцэцэг тэтгэлэгтэй суралцаж байна.
 - 2018 онд Хятад улсын нийслэлийн биеийн тамирын их сургуульд сагсан бөмбөгийн дасгалжуулагчийн магистрантурт 2016 оны төгсөгч О.Гэрэлт-Од суралцаж байна.
 - 2018 онд Хятад улсын биеийн тамирын сургуульд Спортын аялал жуулчлалын магистрантурт 2017 оны төгсөгч Э.Баянбат суралцаж байна.
 - 2018 онд Японы спортын шинжлэх ухааны их сургуульд оюутан солилцоогоор 1 жилийн хугацаатайгаар оюутан А.Нямсүрэн суралцаж байна.

- 2018 оны Японы нийгмийн эрүүл мэндийн шинжлэх ухааны төвийн “Хүүхэд судлалын хүрээлэнгийн судлаач Ph.D Кенжи, Таке нар багш оюутнуудад сургалт семинарыг сүүлийн 2 жилийн хугацаанд тогтмол явуулж ирсэн
- 2018 оны 11 дүгээр сард Австрали улсын чөлөөт бөхийн багш дасгалжуулагч Richard Weiss манай сургуульд 21 хоногийн хугацаатай ажилласан.
- Энэ онд Японы спортын шинжлэх ухааны их сургуульд Биеийн тамирын арга зүйн чиглэлээр магистрантурт 2015 оны төгсөгч А.Хишигмаа суралцаж байна.

Хүснэгт 29

**2014-2018 онд Оюутны хөгжил үйл ажиллагаанд зориулсан
төсвийн хэмжээ /мянган төгрөгөөр /**

№	Хийгдсэн ажлууд	Хичээлийн жил					
		2014 он	2015 он	2016 он	2017 он	2018 он	
1	Сургуулийн бэлтгэлийн иж бүрэн хувцас	1,820	2,626	816	13,213	1,160	
2	Оюутны улсын аварга шалгаруулах тэмцээны төрөл	Жүдо бөх	280.0	560.0	200.0	90.0	951.0
3		Чөлөөт бөх	200.0	495.0	495.0	210.0	2,334
4		Волейбол	100.0	100.0	100.0	560.0	850.0
5		Сагсан бөмбөг	240.0	1,048.0	1,048	1,222	4,405
6		Модон бөмбөг	600.0	884.0	884.0	1,777.0	1,350.0
7		Хөлбөмбөг	278.0	1,570.0	1,570.0	280.0	280.0
8		Таэквондо	576.0	695.0	69.0	600.0	460.0
9		Аэробек	-	560.0	560.0	60.0	3,160
10		Хөнгөн атлетик	-	-	60.0	60.0	360.0
11		Шатар	124.0	150.0	150.0	-	-
12		Цана	-	-	-	-	-
13		Гандбол	460.0	210.0	210.0	600.0	266.0
14		Ширээний теннис	85.0	100.0	100.0	413.0	260.0



6.3. Хөгжлийн бэрхшээлтэй оюутанд чиглэсэн үйлчилгээ:

Манай сургууль хөгжлийн бэрхшээлтэй оюутнуудыг цөөн тоогоор элсүүлэн суралцуулдаг туршлагатай. Энэхүү зорилтот бүлгийн суралцагчид төрийн зээл тусламжид бүрэн хамрагдах үйлчилгээ үзүүлдэг. Сонсголын бэрхшээлтэй оюутнууд гол төлөв сагс, волейбол, хөлбөмбөг, бөхийн суурь болон өндөр ур чадвартай байдаг. Тэдэнд зориулсан онолын хичээлийн материалуудыг хэвлэж өгдөг. Эдгээр оюутны давуу тал хараад гүйцэтгэх чадвар зонхилдог тул тэд сургууль төгсөөд сонсголгүй хүүхдүүдэд заах аргыг эзэмшдэг. Цаашид хөтөлбөртөө тусгайлан заалт оруулах талаар судлах шаардлагатай юм.

Тусгай хэрэгцээт суралцагчдыг төрийн сангийн үйл ажиллагаанд хамруулан төрийн хөнгөлттэй зээл, буцалтгүй тусламж болон бусад тэтгэлгээр суралцуулдаг. Сүүлийн 5 жилд 4 оюутан төгссөн. Энэ хичээлийн жилд 1-р курст 3 оюутан, 3-р курст 1 оюутан суралцаж байна.

6.4. Оюутны байгууллага ба оюутны оролцоо:

Монгол улсын хүн амын эрүүл аж төрөх ёсыг төлөвшүүлэх, эрүүл мэндийг бэхжүүлэх зорилгоор хийгдэж байгаа спортын олон нийтийн үйл ажиллагаанд мэргэжлийн зүгээс туслан идэвхтэй оролцдог.

Сургуулийн дэргэдэх оюутны эрх ашгийг хамгаалах, тэдний төлөөллийн байгууллага бол оюутны зөвлөл байдаг. Оюутны зөвлөл нь өөрийн дүрэмтэй бөгөөд уг дүрмээр оюутны байгууллагын дотоод үйл ажиллагаа, сургууль болон оюутны эрх ашигтай холбогдох бөгөөд гадаад бүхий л төрлийн харилцааг зохицуулж байдаг.

“Дээд боловсролын тухай” хуулийн зохих заалтын дагуу сургуулийн удирдах зөвлөлийн бүрэлдэхүүнд оюутны төлөөлөл оролцох бөгөөд ҮБТДС-ийн дүрэмд зааснаар оюутны зөвлөлийн дарга нь сургуулийн удирдах зөвлөлийн гишүүн байдаг.

Оюутны зөвлөл нь сургуулийн дүрэм болон өөрийн дүрмийн эрх хэмжээний хүрээнд сургуулийн захиргаатай болон төр, засгийн тогтоол, шийдвэрийн дагуу төр, олон нийтийн бусад байгууллагуудтай хамтран ажиллах талаар гэрээ, хэлэлцээр байгуулан ажилладаг.

Юуны өмнө сургуулийн захиргаа, оюутны зөвлөл хамтран оюутны сурах, амьдрах нөхцөл, оюутны байгууллагаас нийт оюутнуудын дунд зохиох соёл, хүмүүжлийн ажил, спортын уралдаан, тэмцээн зохион байгуулах ажлын талаар харилцан үүрэг хүлээж ажилладаг.

Тухайлбал хичээлийн жилд оюутнуудын дунд явуулах соёл, урлагийн арга хэмжээнүүд, спортын уралдаан, тэмцээнүүдэд шаардагдах төсвийг сургуулийн жил бүрийн төсөвт тусган санхүүжүүлж байна. Сургуулийн төсвөөс Оюутны байгууллагын үйл ажиллагаанд зориулан зарцуулсан зардлын хэмжээг доорх графикаар харуулав.

Зураг 38

**Оюутны үйл ажиллагаанд зориулсан төсвийн хэмжээ
/2014-2018он/**




Оюутны зөвлөлийн зорилго, үйл ажиллагааны үндсэн чиглэл, зарчим:
Тус сургуулийн оюутны сайн дурын үүсгэл санаачлагын байгууллагын үндсэн хэлбэр нь спортын үндсэн төрлүүдийн спорт клуб болон биеийн тамирын эмчилгээний арга зүйн мэргэжлийн багш, оюутнуудаас бүрдсэн эмч-шүүгч нарын баг юм. Эдгээр клуб, багийн сургуулийн болон хот, бүс, улсын чанартай спортын уралдаан, тэмцээнүүдэд оролцож үр дүнд хүрч байна.

Оюутнуудын сэтгэл ханамжийн талаарх оюутны байгууллагын судалгааны дүн:

Бид энэхүү шалгуур үзүүлэлтэд үнэлгээ өгөхийн тулд ҮБТДС-ийн төгсөгч, суралцаж буй нийт оюутнаас дараах 13 үндсэн асуулгаар сэтгэл ханамжийн судалгаа авсан бөгөөд эдгээр асуулга бүрд хэрхэн хариулсныг нэг бүрчлэн зургаар харуулав.

Энэхүү “Шалгуур 6” нь дотроо 4 дэд бүлэгтэй байна. Уг судалгааг 2016, 2018 оны судалгаатай харьцуулан дүгнэж үзэхэд 2018 оны хамт олны сэтгэл ханамжийн байдал буюу өөрийн үнэлгээний байдлаас харахад сурагчдад чиглэсэн үйлчилгээний бодлого зохицуулалт нь бусад дэд шалгууруудаас дээгүүр үнэлгээ /3,61 оноо/ авсан байна.

Зураг 39



Хөгжлийн бэрхшээлтэй суралцагчдад чиглэсэн үйлчилгээ, оюутны байгууллага зэрэг дэд шалгуурт тус тус 3,39 оноо, харин суралцагч солилцоонд нь бусад дэд шалгууруудаас хамгийн доогуур үнэлгээг /3,22 оноо/ өгсөн байна. Эндээс бид цаашид суралцагч солилцоог нэмэгдүүлэх, өргөжүүлэхэд анхаарах нь зүйтэй гэсэн дүгнэлт хийж байгаа.

SWOT шинжилгээ:

ҮБТДС-ийн суралцагчдад чиглэсэн үйлчилгээний давуу тал, сул тал, боломж, эрсдлийг тодорхойлох зорилгоор **SWOT** шинжилгээг хийлээ.

<p>Давуу тал</p> <ul style="list-style-type: none"> • Биеийн тамирын сургуулийн хувьд нэр хүнд хүлээн зөвшөөрөгдсөн. • Биеийн тамирын багш, дасгалжуулагч мэргэжлийн магистрантурт суралцагчдын тоогоороо тогтмол өсч байгаа. • Оюутан бүрийг спортын олон төрлийн уралдаан тэмцээнд байнга оролцуулж сургалтын материалаг бааз болон хөрөнгө оруулалтын талаас нь дэмждэг. • Оюутны төсөл, судалгааны ажилд оролцох, оюутан солилцоонд хамрагдах, тэдний идэвх, санаачлага, оролцоог дэмжихэд чиглэсэн үйл ажиллагааг системтэйгээр зохион байгуулдаг. • Спортын өндөр зэрэг цолтой мөн идэвх санаачилга, бүтээлч сэтгэлгээтэй оюутнуудыг хөнгөлөлттэй суралцуулах, сургуулийн нэрэмжит тэтгэлэгт хамруулах, урамшуулал олгодог. • Улс, нийслэлд биеийн тамир, спортын чиглэлээр зохион байгуулагдаж буй томоохон уралдаан, тэмцээн, өдөрлөгийг өөрийн нөөц бололцоондоо тулгуурлан зохион байгуулдаг. • Өөрийн сонгосон спортын төрлөөрөө хувь хүний мэргэжилтэй болж бие бялдарын хөгжилтийг олж авдаг. 	<p>Боломж</p> <ul style="list-style-type: none"> • Салбар хоорондын хамтарсан судалгааг хөгжүүлэх, • Олон эх үүсвэрээс судалгааны санхүүжилт авах, • Монгол Улсын хүн амын эрүүл аж төрөх ёсыг төлөвшүүлэх, эрүүл мэндийг бэхжүүлэх зорилгоор явагдаж байгаа спорт, олон нийтийн үйл ажиллагаанд мэргэжлийн зүгээс туслалцаа үзүүлэх, • Оюутны төсөл судалгааны ажлыг үргэлжлүүлэх, цаашид хөгжүүлэх, • Хөгжлийн бэрхшээлтэй оюутнуудыг нийт оюутнуудынхаа 5%-д нь элсүүлэн суралцуулах, • Мэргэжлийн мэдээллийг шуурхай авч сургалт, үйл ажиллагаандаа ашиглах, • Амжилт гаргасан оюутан, төгсөгчдийнхөө нэр хүнд амжилтаар нь өөрийн сургуулийг гадаад, дотоодод сурталчилан таниулах, • Оюутнууд эзэмшиж буй мэргэжил, мэргэшлээрээ өөртөө зохих хөрөнгө оруулалтыг хийх, • Оюутны өөрийн удирдлагын байгууллагын санхүүг жил бүр нэмэгдүүлэх,
<p>Сул тал</p> <ul style="list-style-type: none"> • Оюутнуудыг хөгжүүлэх урт хугацааны стратеги төлөвлөгөөг төлөвлөж байгаагүй. • Судалгааны бүх талын санхүүжилт хангалттай биш. • Залуу судлаачдыг дэмжих бодлого, зохион байгуулалт дутмаг. • Оюутнуудад зориулсан цахим мэдээллийн нэгдсэн системийн үйл ажиллагаа хэвийн бус. 	<p>Эрсдэл</p> <ul style="list-style-type: none"> • Мэдлэгт тулгуурласан судалгааны цогц үйл ажиллагаа төлөвшихгүй удах, • Биеийн тамир спортын сургалтын хэрэгсэл, материалын элэгдэл хорогдол өндөр учраас оюутны төлбөр нэмэгдэх, • Спортын олон төрлийн уралдаан тэмцээнд байнга оролцсноор хичээллэгчид бэртэж гэмтэх,

Цаашид сургуулийн зүгээс суралцагчдад чиглэсэн үйлчилгээг бэхжүүлэх, сайжруулахын тулд дараах арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлэхээр төлөвлөж байна. Үүнд:

- Оюутнуудыг хөгжүүлэх урт хугацааны \2019-2025 он\ стратеги төлөвлөгөөг боловсруулах;
- Амжилт гаргасан оюутан, төгсөгчдийнхөө нэр хүндийг нь өргөх, дэмжлэг үзүүлэх замаар өөрийн сургуулийн нэр хүндийг өргөх, гадаад, дотоодод сурталчилан таниулах томоохон ажлуудыг төлөвлөгөөтэйгээр зохион байгуулах;
- Хөгжлийн бэрхшээлтэй оюутнуудын нийгэмд эзлэх байр суурийг нь нэмэгдүүлэх үүднээс тэдэнд зориулсан хөгжлийн хөтөлбөр боловсруулах;
- Оюутнуудад зориулсан цахим мэдээллийн нэгдсэн системийн үйл ажиллагааг идэвхжүүлэх,
- Оюутнуудын олон улсын болон дотоодын тэмцээн уралдаанд орох хувцас хэрэгсэл, тоног төхөөрөмжийг сайжруулах, нэмэгдүүлэх, шинэчлэх ажлыг зохион байгуулах;
- Судалгаа шинжилгээ, төсөл, эрдэм шинжилгээний ажлыг тогтмол зохион байгуулж оролцогчдын цар хүрээг нэмэгдүүлэх;
- Сургуулийн гадаад харилцааг өргөжүүлж багш, оюутан солилцоог одоогийн түвшнээс 10%-иар нэмэгдүүлэх;

ШАЛГУУР 7. НИЙГЭМД ЧИГЛЭСЭН ҮЙЛЧИЛГЭЭ

Сургууль нь нийгмийн хөгжилд хувь нэмэр оруулах чиг үүргээ хэрэгжүүлж, нийгэмд чиглэсэн үйлчилгээг үзүүлнэ.

7.1. Нийгмийн харууллага: Нийгэмд үзүүлдэг үйлчилгээний нэр төрөл, хүртээмж, чанар.

Бидний эрхэм зорилго бол дэлхийн спортын орчин үеийн чиг хандлагад нийцсэн чанартай мэргэжилтэн бэлтгэх, нийгэмд үйлчлэхэд чиглэгддэг. Тодруулбал, залуучуудад биеийн тамир, спортын багш, дасгалжуулагч, эрүүл мэндийн арга зүйчийн чиглэлээр насан туршийн боловсрол олгох, биеийн тамирын төрөл, чиглэлүүдээр олон нийтэд чиглэсэн сургалт үйлчилгээ явуулах, сургуулийн өөрийн чиг үүргийн чиглэлээр дотоод, гадаад түншлэлээр дамжуулан идэвхтэй хамтран ажиллах тогтолцоог бүрдүүлэн ажилладаг юм.

ҮБТДС-ийн онцлог бол биеийн тамир, спортоор хичээллэгсдийн эрүүл мэнд, бие бялдрын хөгжилтөд зөвлөгөө өгч хөгжүүлэхийн зэрэгцээгээр нийтийн биеийн тамир, тодорхой төрлийн тэмцээний үед бэртэл, гэмтэл авсан тамирчид, иргэдэд эмнэлгийн анхан шатны тусламж үзүүлдэг арга зүйчдийг бэлтгэдэг. Энэ бол бидний нийгэмд үзүүлж байгаа үйлчилгээ мөн.

Өөр нэг үйлчилгээ нь эрүүл мэндээ хамгаалах биеийн тамирын дасгал хөдөлгөөнөөр сэтгэл зүйн бэлтгэлийг сайжруулна.

Үйлчлүүлэгчдийн сэтгэл ханамжийн түвшин: Тус сургуулийн үйлчлүүлэгчдийн сэтгэл ханамжийн байдлыг манай хамт олны удаа дараагийн уралдаан, тэмцээнүүдэд оролцон төрийн төв байгууллага, тусгай газруудаас олгосон өргөмжлөл, батламж, цом, төв орон нутгийн хэвлэл мэдээллийн тойм, хөндлөнгийн үнэлгээ зэргээр илэрхийлж болно.

Нийгмийн үйлчилгээний хүрээнд хамтран ажилладаг байгууллагуудын үнэлгээ, сэтгэл ханамж: Бидний нийгмийн үйлчилгээний хүрээнд хамтран ажилладаг төрийн, төрийн бус болон олон нийтийн, эрдэм шинжилгээ, судалгааны олон байгууллага байдаг. Тэд өөрсдийнхөө чиглэлээр үнэлгээ өгч, сэтгэл ханамжаа илэрхийлсэн байдаг. Жишээ: ҮБТДС-ийг шилдэг менежменттэй “ТОП-5”, “ТОП-6” сургуулиар шалгаруулан нийтэд зарлан тухайн байгууллага сэтгэл ханамжаа илэрхийлсэн байдаг бол МҮОХ, МҮОА өөрсдийн удирдах байгууллагад манай сургуулийн удирдлага, эрдэмтэн судлаачдаас оруулан ажиллуулдаг нь тэдний сэтгэл ханамжийн илэрхийлэл гэж бид үздэг.

7.2. Нийгмийн түншлэл: Манай сургууль өөрийн чиг үүргийн чиглэлээр ажил олгогч, төгсөгчид, мэргэжлийн байгууллагуудтай түншлэн идэвхтэй хамтран ажиллаж, нийгмийн хөгжилд хувь нэмрээ оруулж байдаг. Сургуулийн онцлогоос хамааран нийгмийн сайн сайхны төлөө зохион байгуулдаг уламжлалт ажлуудын талаар зарим баримт өгүүлье.

Манай сургууль биеийн тамирын эмчилгээний арга зүйн тэнхимтэй. Тус тэнхимийн харьяанд “эрүүлжүүлэлт чийрэгжүүлэлт”-ийн иж бүрэн тоноглол бүхий тусгай кабинет байгуулан тогтмол ажиллагаатай болгосон юм. Бид энэ тэнхим, кабинетаар дамжуулан нийгмийн сайн сайхны төлөө үйлчлэх зарчмыг баримтлан ажилладаг. Бид түншлэлийн дотоод, гадаад хэлбэрүүдийг ашиглан нийгэмдээ

үйлчилдэг уламжлалтай болсон юм. Энэ чиглэлээр хэвшиж тогтсон дотоод түншлэлийн зарим үйл ажиллагаанаас дурдвал:

- БСШУЯ-ны харьяа Боловсролын хүрээлэнтэй хамтарсан “Монгол хүүхдийн шалгуур үзүүлэлт” төслийн “Хүүхдийн бие бялдрын хөгжилт, бэлтгэлжилтийн түвшин тогтоох” судалгааны багийн удирдамж, арга зүйг боловсруулан тэргүүлэн удирдаж оролцлоо.
- Тэнхимээс зохион байгуулан оюутан, багш нарын судалгааны баг нийслэлийн БТСГ-тай хамтран “Хүн амын чийрэгжилтийн түвшин тогтоох сорил тест”- ийг зохион байгуулалтайгаар авч, зөвлөмж өгч хэвшүүлээ,
- ЭМСЯ-ны харьяа цус сэлбэлтийн үндэсний төвтэй хамтарч 2008 оноос эхлэн “Амьдрал бэлэглэе” уриан дор цусны донорын өдөрлөгийг жил бүрийн 10 сар болон 5 сард 2 удаа зохион байгуулан багш, оюутан, ажилчдыг хамруулан жилд 80 орчим хүнээс 100 литр цус, цусан бүтээгдэхүүн хандивлаж ирлээ.
- БСШУСЯ-ны БТС-ын хөгжлийн төвийн эрдэм шинжилгээний албатай хамтран үндэсний шигшээ багийн тамирчдын бие бялдрын хөгжилт, бэлтгэлжилтэнд байнгын судалгаа хийж, зөвлөмж гаргаж өгдөг.
- МҮОХ, МҮОА, БСШУСЯ-ны БТСГ хөгжлийн төвийн эрдэм шинжилгээний алба, Нийслэлийн БТСГ, бусад их дээд сургуулиудаас зохион байгуулдаг эрдэм шинжилгээ, онол практикийн бага хурлуудад оюутнууд болон багш нараа идэвхтэй оролцуулан хамтран ажилладаг.
- Улаанбаатар хотын спортын төрөлжсөн сургалттай дунд сургуультай хамтран жил бүр өсвөрийн тамирчдын бие бялдрын хөгжилт, бэлтгэлжилтийн судалгаа хийж зөвлөгөө өгч байна.
- Сургуулийн хөрөнгө оруулалтаар Биеийн тамирын эмчилгээний арга зүйн тэнхимийн дэргэд “эрүүлжүүлэн чийрэгжүүлэх” кабинет байгуулан байнгын үйл ажиллагаатай болгосон. /хавсралт 2/
- Багш, ажиллагсдыг эрүүл мэндийн карттай болгон нарийн мэргэжлийн үзлэг, шинжилгээнд хамруулан улмаар өөрийн кабинетаар эмнэлгийн анхны тусламж үйлчилгээг үзүүлж байна.
- Жил бүр шинээр элсэн орж байгаа оюутнуудыг биеийн ерөнхий хөгжлийн судалгаа болон эрүүл мэндийн үзлэгт тогтмол хамруулж ирсэн.
- Спортын бэртэл, гэмтэл авсан бусад сургуулийн болон өөрийн сургуулийн оюутнуудад “эрүүлжүүлэн чийрэгжүүлэх кабинет” -аар дамжуулан нөхөн сэргээх, эрүүлжүүлэн чийрэгжүүлэх ажлыг мэргэжлийн багш, оюутны тусламжтайгаар үнэ төлбөргүй зохион байгуулж байна.
- Тэнхимийн багш Т.Баатар түүврийн аргаар дүүргүүдийн өрхийн эмнэлэг дээр “Настны эрүүл мэнд”-ийн дасгал хөдөлгөөнийг тогтмол хийх заавар зөвлөгөө өгч ажилладаг.
- Тэнхим Монголын Оюутны Спортын Холбоотой хамтын ажиллагааны гэрээ байгуулан тус холбооноос жил бүр зохион байгуулдаг “Универсиад” наадмын бүх уралдаан тэмцээнд (жилд 10-12 төрлийн тэмцээн болдог) мэргэжлийн багш, оюутнууд эмч-шүүгчээр ажиллаж, анхан шатны тусламж үйлчилгээ үзүүлж, тэмцээний үеийн гэмтэл, бэртлийн байдалд судалгаа хийж нийтэд мэдээлдэг болсон.

Харилцагчдын оролцооны талаар:

- Биеийн тамирын эмчилгээ арга зүйн тэнхим Монголын Үндэсний Сагсан Бөмбөгийн Холбоотой хамтын ажиллагааны гэрээ байгуулан тус холбооноос зохион байгуулж байгаа тэмцээний үеэр мэргэжлийн багш, оюутны баг эмнэлгийн анхны тусламж үзүүлж, тэмцээний дараа нөхөн сэргээх үйл ажиллагаа явуулж байна.
- Мөн “Мини” сагсан бөмбөгийн холбоотой хамтран ажиллах гэрээ байгуулан тус холбооноос зохион байгуулж буй өсвөрийн сагсан бөмбөгчдийн тэмцээнүүдэд мэргэжлийн багш, оюутнууд эмч-шүүгчээр ажиллан эмнэлгийн анхан шатны тусламж үзүүлж байна.
- Улаанбаатар хотын тусгай хэрэгцээт ерөнхий боловсролын 63-р сургуулийн биеийн тамир, чийрэгжүүлэлтийн кабинет болон спорт заалыг биеийн тамирын эмчилгээний арга зүйчийн төгсөх ангийн оюутнуудын хандиваар тохижуулах ажлыг зохион байгуулдаг уламжлал нэгэнт тогтсон болно.
- Жил бүрийн 12-р сарын 1-ний Дэлхий нийтээр ДОХ-той тэмцэх өдрийн үеэр нийт оюутнуудад ДОХ болон бэлгийн замын халдварт өвчний хор хөнөөл, түүнээс урьдчилан сэргийлэх асуудлаар хичээл, сургалтын ажлыг тогтмол явуулж байна.
- Волейболын насанд хүрэгчдийн “Тэнүүн огоо” шигшээ багийн тэмцээн уралдаанд эмч шүүгчээр хамтран ажиллаж байна.
- Хөл бөмбөгийн залуучуудын шигшээ багийн тэмцээн уралдаанд эмч шүүгчээр ажиллаж байгаа. Мөн хөл бөмбөгийн “Гоёо” багийн уралдаан тэмцээнд тогтмол эмч шүүгчээр ажиллаж байна.
- “Голомт банк”-ны ажилчин, албан хаагчидтай явган аялалаар сүүлийн 6 жил тасралтгүй хамтран ажилласны зэрэгцээ баг, тамирчдын уралдаан тэмцээнд эмч шүүгчээр ажиллаж байна.
- Монголын оюутны холбоотой тогтмол хамтран уралдаан, тэмцээнд эмч шүүгчээр ажилладаг.
- Шинжлэх Ухаан, Технологийн санхүүжилтээр “Монголын үндэсний шигшээ баг”-ийн тамирчидтай “Токио-2020” хүрээнд зохион байгуулж байгаа төсөлт ажлыг хэрэгжүүлж байна.
- Тус тэнхим БНСУ-ын Ардын уламжлалт анагаах ухааны “Жун” эмнэлэгтэй хамтран ажиллаж 2013-2015 оны хичээлийн жилд тус сургуулийн эмч оточ нарын баг ажиллуулан БТЭАЗ-н мэргэжлийн оюутнуудад тусгай хөтөлбөр, хуваариар хичээл заалган, долоо хоногийн бямба гариг бүрийг тус сургуулийн оюутнуудад урьдчилан сэргийлэх үзлэг хийх, гэмтэл бэртэл авсан оюутан- тамирчдад эмнэлгийн анхан шатны тусламж үзүүлэх, эмчилгээ хийх зэрэг хэлбэрээр хамтран ажилласан.
- БТЭАЗ-н тэнхим Япон Улсын Токио Хотын Биеийн Тамирын Шинжлэх Ухааны Их Сургуулийн Спортын Анагаах ухааны тэнхимтэй хамтын ажиллагааны гэрээтэй ажиллаж байна. Энэхүү хамтын ажиллагааны гэрээний багш солилцооны хүрээнд профессор Сакура Норико тус сургуульд уригдан ирж “Атлетик трейнер” мэргэжлээр 3 удаа сургалт зохион байгуулж, 4-р курсын оюутнуудад 5 удаагийн хичээлийг онол, дадлага хослуулан

явуулав. /хавсралт 3/


Гадаад түншлэлийн зарим баримт өгүүлэе.

- ОХУ-ын Ломоносовын нэрэмжит Москвагийн их сургуулийн Антропологийн хүрээлэн
- Япон улсын Цукуба их сургуулийн эрдэмтдийн баг /хавсралт 4/
- Япон улсын нийгмийн эрүүл мэндийн шинжлэх ухааны төвийн Хүүхэд судлалын хүрээлэн зэргийг жишээ татан дурдаж болно.
Дотоод түншлэлийн хүрээнд хамтран ажиллаж хэвшсэн өөр төрөл, хэлбэрүүд байгаа юм.

Тухайлбал:

- Монголын тэшүүрийн холбоо, Монголын гимнастикийн холбоо, Монголын самбо бөхийн холбоо, Монголын жүдо бөхийн холбоо, Монголын таеквондогийн холбоо, Монголын боксын холбоо, Монголын чөлөөт бөхийн холбоо гэх мэт бүх холбоодуудтай хамтран ажиллаж байна.
- Сүхбаатар дүүргийн Засаг даргын тамгын газрын Цэргийн штабтай хамтран “Оюутан цэрэг” цэргийн мэргэжил олгох сургалтыг байнга зохион байгуулж байна.
- Нийслэлийн Сүхбаатар дүүргийн прокурорын газар, ерөнхий прокурорын газартай хамтран гэмт хэргүүдийн хор уршигийн талаар нийт оюутнуудын дунд сургалт зохион байгуулдагаас гадна нийт багш ажилчдын дунд гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, “Архидан согтуурахтай тэмцэх тухай” хуулийн холбогдох зүйл заалт, байгууллагын дотоод аюулгүй байдлыг хангах, багшийн ёс зүйн талаар сурталчилан таниулдаг. /Хавсралт 5/
- Сонгино хайрхан, Сүхбаатар, Чингэлтэй дүүргийн биеийн тамир спортын хороодтой байнгын хамтын ажиллагаатай.
- Монголын үндэсний олон нийтийн радио, телевизийн спортын баг хамт олонтой олон жилийн харилцаа холбоотойгоор их спортын залгамж халаа болсон шилдэг залуу тамирчдын тив, дэлхийд гаргасан амжилтыг олон нийтэд сурталчилан танилцуулах ажлыг хийсээр байна.
- 1991 оноос эхлэн 4-р курсын оюутнуудыг багшлах дадлага хийлгэдэг байхад цөөхөн хэдэн ерөнхий боловсрол сургууль дээр гаргадаг байсан бол сүүлийн жилүүдэд багшлах дадлагыг 20-иод сургууль дээр гарган ажиллаж байна.

Сургуулийн төрийн ба төрийн бус байгууллагуудын хамтын ажиллагааны талаар шалгуурын 2.3-т тодорхой өгүүлсэн болно.

Хэрэглэгчдийн хандалт, сэтгэл ханамж

Шалгуур 7-д холбогдох нийгмийн хариуцлага, нийгмийн түншлэлийн асуудлаар хамт олноос өөрийн үнэлгээний судалгаа авсан бөгөөд хамт олон нийгмийн хариуцлагын тухай 3,63 гэсэн үнэлгээ өгсөн байна. Энэ нь манай хамт олны нийгмийн хариуцлага сайн байгаа нь харагдаж байна. Харин нийгмийн түншлэлийн тухайд 3,47 өгсөн нь гадаад, дотоод хамтын ажиллагааны талаар илүү анхаарах нь зүйтэй гэсэн сануулга гэж үзэж байна.

SWOT шинжилгээ (Нийгэмд чиглэсэн үйлчилгээ)

<p>Давуу тал (Strength)</p>	<ul style="list-style-type: none"> • Багш нарын шагнал урамшууллыг мөнгөн хэлбэрээр болон өргөмжлөл, медалиар холбогдох ойн баяр, арга хэмжээнүүдийн үеэр шагнаан урамшуулдаг. • Их дээд сургуулийн дунд зохион байгуулдаг оюутны универсиад их наадамд биеийн тамирын эмчилгээ арга зүйн тэнхимийн багш нар эмч шүүгчээр ажилладаг. Мөн МСБХ болон бусад холбоодын тэмцээн, уралдаанд эмч, шүүгчээр ажилладаг. • Олон улс, тив дэлхийн аварга, оюутны спортын тэмцээнүүдэд өндөр амжилт үзүүлсэн тамирчин оюутнуудын сургалтын төлбөрийн 20-50 хувийн хөнгөлөлтийг сургуулийн захирлын тушаалаар батламжилдаг. • Спортын ур чадвараа ахиулах 18-23 насны суралцагчидын өөрийн сонгосон төрлөөрөө мэргэших ур чадвар нь байнга ахиж, спортын зэрэг цол нь дээшлэх нөхцлийг сургууль бүрдүүлж өгдөг. • Манай сургуулийн оюутнууд аливаа олон нийтийн үйл ажиллагаанд идэвхтэй оролцдог, Жилд 2 удаа цус сэлбэх үндэсний төвтэй хамтран цусны өдөрлөгт тогтмол идэвхтэй оролцдог.
<p>Сул тал (Weakness)</p>	<ul style="list-style-type: none"> • Спортын тэмцээн уралдааныг түлхүү анхаардаг. • Оюутнуудын суурь ерөнхий мэдлэгт анхаарах • Багш, оюутны гадаад болон дотоод солилцоог нэмэгдүүлэх
<p>Боломж (Opportunities)</p>	<ul style="list-style-type: none"> • Сургуулийн удирдлагын зүгээс багш нарын судалгаа, шинжилгээний ажилд анхаарч олон улсын эрдэм шинжилгээний хурлуудыг зохион байгуулах. • Багш нарын уралдаан, тэмцээнд явахад, өөрийгөө хөгжүүлэн мэргэжлийн сургалт, семинарт суух, ОУХ, эрдэм шинжилгээний хуралд оролцоход нь цалинтай чөлөө олгож дэмжлэг үзүүлэх. • Багш нарыг гадаад улс орнуудад эрдэм шинжилгээний хуралд оролцоход дэмжлэг үзүүлэх. • Мэргэжлийн хөтөлбөрийг нэмэгдүүлэх
<p>Эрсдэл (Threats)</p>	<p>Удаан хугацаагаар гадаад болон дотоодын тэмцээн уралдаан, цугларалтад хамрагддаг өндөр зэрэгтэй тамирчдын онолын хичээлүүдийн кредит цагийн нөхөлтийг зохион байгуулах сургалт нь хүндрэл учруулдаг.</p>

ШАЛГУУР 8. ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭ, ИННОВАЦИ

Сургууль нь боловсролын болон шинжлэх ухааны тэргүүлэх чиглэлээр сургалт, судалгаа, үйлдвэрлэлийн уялдаа холбоотой үйл ажиллагааг хэрэгжүүлж, шинжлэх ухаан, технологи, инновацийн хөгжилд хувь нэмрээ оруулдаг байна.

8.1 Эрдэм шинжилгээний бодлого, удирдлага

ҮБТДС-ийн эрдэм шинжилгээ, судалгааны ажлын чиглэл нь үндсэн агуулгаараа сургуулийн Удирдах Зөвлөл, Эрдмийн Зөвлөл, Захиргааны Зөвлөл, Тэнхимүүд, клубууд, спортын багуудын хамтын ажиллагаагаар сургалт, судалгааны ажлын уялдаа холбоог сайжруулах, эрдэм судлалын ажлыг бүх талаар дэмжих, дотоод гадаадын хамтын ажиллагааны тогтолцоог бүрдүүлж, үр өгөөжийг дээшлүүлэхэд чиглэсэн иж бүрэн тогтолцоо юм.

ҮБТДС-ийн судалгааны ажлын хуваарилалт:

1. Сургуулийн захирлаар ахлуулсан Эрдмийн Зөвлөлийн дэргэд профессорын баг, судалгааны баг, хэвлэл, мэдээллийн баг, “Биеийн тамир, спортын онол, арга зүй” сэтгүүлийн зөвлөл ажиллана.
2. Захиргааны Зөвлөлийн харьяанд өөрийн төсвийн төслийн санхүүжилтийн баг, хамтын ажиллагааны баг ажиллаж байна.
3. Тэнхим тус бүр эрдэм шинжилгээ, судалгааны болон мэргэшсэн клуб, кабинет, спортын бэлтгэлийн хөтөлбөртэй ажилладаг. Тодруулбал:
 - Онол арга зүйн тэнхим дотоод, гадаадад зохион байгуулах эрдэм шинжилгээ, онол практикийн бага хурлыг зохион байгуулан сурталчилдаг.
 - Үндэсний спорт мэргэжлийн тэнхимийн харьяанд спортын клубүүд ажиллаж төрөл бүрийн уралдаан тэмцээнд оролцох ажлыг удирдан явуулж, тамирчдын гадаад, дотоод хамтарсан бэлтгэлийг зохион байгуулдаг.
 - Биеийн тамирын эмчилгээний арга зүйн тэнхим дэргэдээ биеийн тамирын эмчилгээ, чийрэгжүүлэлтийн кабинет ажиллуулахын зэрэгцээгээр спортын уралдаан, тэмцээнүүдийн эмч, шүүгч нарын багт ажиллах зэрэг үүрэгтэй байдаг.

ҮБТДС-ийн Удирдах Зөвлөлийн үйл ажиллагааны зорилгын нэг үндсэн хэсэг нь сургуулийг зохион байгуулалт, санхүү, материаллаг баазын хувьд бэхжүүлэх, сургалт, эрдэм шинжилгээ, спорт, хүмүүжлийн ажлын хэтийн чиглэл, бодлого стратегийг тодорхойлох, хэрэгжилтэд нь хяналт тавих, үнэлэлт, дүгнэлт өгч дэмжлэг тусалцаа үзүүлэхэд оршино. (Дүрмийн 1.3)

ҮБТДС-ийн Эрдмийн Зөвлөлийн үйл ажиллагааны журамд зааснаар тус зөвлөлийн үндсэн чиг үүрэг нь сургуулийн эрдэм судлалын ажлын чиглэлийг тодорхойлох, эрдэм шинжилгээ, сургалт үйлчилгээний уялдаа холбоог сайжруулах, профессорын болон судалгаа, төслийн баг ажиллуулах, гадаад дотоодын боловсрол, биеийн тамир, спортын байгууллагуудтай хамтран ажиллах гэрээ, хэлэлцээр, төслийн хэрэгжилтийг хэлэлцэн хамтын шийдвэр гаргах зэрэг асуудалд төвлөрч байхад оршино. Сургуулийн эрдэм судлалын ажил нь дээрх чиг үүрэг бүхий үндсэн нэгжүүдийн үйл ажиллагааны зорилтыг хэрэгжүүлэхэд бусад

салбар нэгжүүдийн үйл ажиллагаа чиглэгдэж байгаа юм. Эдгээр салбар нэгжүүдийн чиг үүрэг хэрхэн хэрэгжиж байгааг дор өгүүлнэ.

Дэлхийн спортын чиг хандлагад нийцсэн хөрвөх чадвартай биеийн тамир, спорт, эрүүл мэндийн мэргэжилтэн бэлтгэх сургуулийн эрхэм зорилтыг шийдвэрлэхэд чиглэсэн стратеги зорилгын нэг үндсэн чиглэл нь шинжлэх ухаан, инновацийн онол, практикт суурилсан сургалт, судалгааны менежмент юм.


Бид сургуулийнхаа 2021 он хүртэлх стратегийн зорилгодоо эрдэм шинжилгээ, судалгааны ажлын хүрээнд профессор, багш нарын бүтээлийг баталгаажуулах тогтолцоог бүрдүүлэх зорилт (зорилт 1.2) дэвшүүлж улмаар энэхүү зорилтын шалгуур нь биеийн тамир, спортын салбарын шинжлэх ухааны түвшинд хэвлэгдсэн бүтээлийн тоон үзүүлэлт байна гэж заасан байгаа.

Судалгааны тухайд сургуулийн нийт тэнхим, албадын багш, ажилтнуудыг нэгтгэсэн тус бүрдээ тэргүүлэх чиглэл бүхий профессорын, судлаачдын гэсэн хоёр үндсэн баг ажилласаар ирсэн. Профессорын баг нь мэргэжлийн суурь судалгаа, онол, арга зүйн асуудалд үйл ажиллагаагаа чиглүүлдэг бөгөөд судлаачдын баг нь хавсрага судалгааны чиглэлээр ажиллаж байна.

Тус сургууль нь биеийн тамир, спортын салбарын багш, дасгалжуулагч, арга зүйч мэргэжилтэн бэлтгэх чиглэлээр төрөлжсөн, өөр мэргэжлийн салбар, нэгж сургуульгүй учир сургууль байгуулагдсан эхний үеэс л сургуулийн хэмжээнд профессорын нэг баг ажилласаар ирсэн.

Зураг 41

Доктор зэрэгтэй багш нарын тоо \2014-2018 оноор\



Профессорын багийн тэргүүн ээлжийн зорилт нь юуны өмнө сургалтын хөтөлбөрт орсон мэргэжлийн хичээлүүдийн сурах бичиг, гарын авлагыг хэвлэн

багш, оюутны хүртээл болгох ажил байсан юм. Учир нь урьд нь ийм төрөлжсөн сургууль манай улсад байгаагүй учир мэргэжлийн сурах бичиг, гарын авлага дутагдалтай байлаа.

Профессорын баг энэхүү зорилтоо тодорхой бодлого, дэс дараалалтай хэрэгжүүлэн ажилласан. Сүүлийн 2006 оноос хойш доорх сурах бичиг, гарын авлага, зөвлөмжүүдийг боловсруулсан. Энд заримаас нь тодруулан дурдвал: Дасгалжуулалтын онолын дадлага, Бөхийн чөлөөт барилдааны цогц хөтөлбөр, Гимнастик заах арга зүй, Аэробек заах арга зүй, Бөхийн жудо барилдааны онол, арга зүй, Жудо бөхийн дасгал, зэрэглэлийн ангилал, Сагсан бөмбөгийн цагаан толгой, Дасгалаар эрүүлжихүй, чийрэгжихүй, Цэгэн иллэг, Иллэгийн анатоми, Гар засал эмчилгээ, Рефлекс эмчилгээ, Хөдөлмөр эмчилгээ, Монгол адуу их ном, Хурдан морьд уяж засах үндэсний хураангуй зэрэг сурах бичиг, гарын авлага, зөвлөмжүүдийг дурдаж болно.


ҮБТДС-ийн багш, магистрант, оюутнуудын эрдэм шинжилгээний хуралд оролцсон байдал болон хэвлүүлсэн бүтээлийн тоог сүүлийн 5 жилээр харуулав Сүүлийн 5 жилийн хугацаанд олон улсын нэр хүндтэй мэргэжлийн сэтгүүлд 15 ш, дотоодын сэтгүүлд 38 эрдэм шинжилгээний өгүүлэл хэвлэгдсэн байна.

Хүснэгт 32

Багш нарын хэвлүүлсэн эрдэм шинжилгээний өгүүлэл

Хэвлүүлсэн бүтээл		2015 он	2016 он	2017 он	2018 он	2019 он	Дүн
ОУ-ын нэр хүндтэй мэргэжлийн сэтгүүл	тоо	3	7	1	1	3	15
	%	27.3	41.2	11.1	9.1	60.0	28.3
Дотоодын сэтгүүл	тоо	8	10	8	10	2	38
	%	72.7	58.8	88.9	90.9	40.0	71.7
Дүн	тоо	11	17	9	11	5	53

Зураг 42



Дотоод, гадаадын хамтын үр бүтээлтэй судалгааны ажлууд, тэдгээрээс гарсан бүтээлүүд:

ҮБТДС нь 2000 онд АНУ-д төвтэй Олон улсын эрүүл мэнд, бие бялдрын боловсрол, нөхөн сэргээлт, спорт бүжгийн зөвлөлийн (1СНРЕН-80) гишүүн (2003 онд), Олон улсын спортын шинжлэх ухаан, биеийн тамирын боловсролын Зөвлөлийн (1С53РЕ, код. Д-132) гишүүн бөгөөд ЮС, ФИСУ зэрэг Олон улсын мэргэжлийн байгууллагууд, ОУОХ, Спортын Холбоотой ажил төрлийн холбоотой ажиллаж байна. ҮБТДС-ийн эрдэмтэд, судлаачдын эрдэм шинжилгээ, судалгааны бүтээл, өгүүллүүд ОХУ, АНУ, БНХАУ, Япон, Украин, Австрали, Солонгос, Тайвань зэрэг дэлхийн 10 гаруй орны олон улсад нэр хүндтэй сэтгүүл, тогтмол хэвлэлүүдэд нийтлэгдсэн байна.


Сүүлийн 5 жилийн хугацаанд олон улсын нэр хүнд бүхий эрдэм шинжилгээний хуралд нийтдээ 232 илтгэл хэлэлцүүлсэнээс 10,3% гадаадын, 89,7 % дотоодод зохион байгуулагдсан хуралд оролцсон байна.

Хүснэгт 33

Багш, оюутнуудын эрдэм шинжилгээний хуралд хэлэлцүүлсэн илтгэл

Хэвлүүлсэн бүтээл		2015 он	2016 он	2017 он	2018 он	2019 он	ДҮН
Гадаадын хуралд хэлэлцүүлсэн илтгэл	тоо	5	5	1	5	8	24
	%	9.1	12.8	7.7	2.3	27.6	10.3
Дотоодын хуралд хэлэлцүүлсэн илтгэл	тоо	50	34	43	60	21	208
	%	90.9	87.2	92.3	97.7	72.4	89.7
Дүн	тоо	55	39	44	65	29	232

Зураг 43



2018 оны 4 сарын 20-21-нд Монгол Улсын нийслэл Улаанбаатар хотноо “Оюутны спорт: Үндэстний эрүүл мэнд, хөгжил дэвшил” сэдэвт олон улсын оюутан, залуу судлаачдын эрдэм шинжилгээний хурлыг Олон улсын спортын их сургуулиудын холбоо, Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын яам, Монголын оюутны спортын холбоо (МОСХ), Үндэсний биеийн тамирын дээд сургууль (ҮБТДС) хамтран анх удаа зохион байгуулсан юм.

Бага хуралд нийт 12 орны 319 залуу судлаач бүтээлээ ирүүлснийг англи, орос, монгол хэлээр эмхэтгэн 500 хуудас бүхий илтгэлийн номыг нийтийн хүртээл болгосон. Тус хуралд ҮБТДС-ийн эрдэмтэд, залуу судлаач багш, оюутны 31 илтгэл хэлэлцүүлж хэвлүүллээ.

2018 онд БСШУСЯ-наас "Тогтвортой хөгжил, Дээд боловсрол" Улсын 2-р зөвлөгөөнд, "Их, дээд сургуулийн биеийн тамир, спортын хөгжлийн асуудлууд" сэдэвт олон улсын эрдэм шинжилгээний хурал-6, БСШУСЯ, ЗГХАБТСГ-ын "Биеийн тамир, спортын салбарын "Шилдэг судлаач-2018" эрдэм шинжилгээний бага хурал 5, "Биеийн тамир,спорт-Хөгжил ба шинэчлэл" ОУЭШ-ний онол практикийн бага хуралд 9, ҮБТДС-ийн багш, оюутны "Эрдэм шинжилгээний бичиг"-ийн эмхэтгэлд 10 илтгэл хэлэлцүүлэн тус тус хэвлэгдэн гарлаа.

Энэ онд МУБИС-ийн багш Ц.Тамирын "ЕБС-ийн бага ангийн сурагчдын биеийн бүрдлийн судалгаа" боловсрол судлалын доктор (Ph.D) зэрэг горилсон бүтээлийн эрдэм шинжилгээний ажлын удирдагчаар тус сургуулийн Захирал ШУ-ны доктор,проф. Л.Алтанцэцэг ажиллаж амжилттай хамгааллаа.

8.2. Судалгааны баг, хамтарсан судалгаа:

Сургуулийн салбар, нэгж бүрт шинжлэх ухааны тодорхой асуудал, сэдвээр судалгааны багууд ажиллан судлаач багш нарыг үе шаттайгаар бэлтгэж ирсэн.

ҮБТДС-ийн судалгааны баг нь биеийн тамирын боловсрол, биеийн тамираар эмчлэх арга зүй, спортын дасгалжуулалтын тодорхой асуудал, сэдэв, төсөл дээр мэргэшин ажилласаар ирлээ.

Судалгааны багийн үйл ажиллагааг эрдэм судлалынх нь чиглэлээр эрдэм шинжилгээний нэг сэдэвт бүтээл дээр ажиллах баг, төслийн баг, БТС –ын салбарын сургалт, дасгалжуулалтын тулгамдаж буй асуудлаар мэргэшин судлах судалгааны баг гэж төрөлжүүлэн судлаач багш нарыг ажлын цар хүрээ, хугацааны тодорхой баримжаатай ажиллуулдаг болсон юм.

Сургуулийн нийт багш нар тус бүрдээ эрдэм шинжилгээ, судалгааны ажлын тодорхой чиглэл, сэдэвтэй бөгөөд тэрхүү мэргэшсэн чиглэл, сэдвийнхээ дагуу судалгааны ажил хийж, бүтээлээ туурвисаар байна.

Манай сургуулийн багш нарын 28,6% нь эрдмийн зэрэгтэй бөгөөд судлаачдын багийн бүрэлдэхүүнд нийт багш нарын 66,6% нь хамрагддаг юм.

Тэдний тодорхой хэсэг нь эрдмийн зэрэг хамгаалж, нэлээд нь докторантурт суралцаж байна. Тухайлбал: Нэр бүхий дараах багш нар докторантурт суралцаж байна.

№	Овог, нэр	Судалгааны ажлын сэдэв	Сургалтын байгууллага
1	Ц.Баярсайхан	Чөлөөт бөхийн тамирчдын дасгалжуулалтыг боловсронгуй богоход Акробатикийн бэлтгэлийг хэрэглэх нь	МУБИС
2	Д.Өлзийжаргал	Биеийн тамирын багш нарын бие бялдрын бэлтгэлжилтийн судалгаа	МУБИС
3	Ч.Болдбаатар	Ойрын зайн гүйгчдийн бие бялдрын бэлтгэлжилтийг судалсан нь	БНХАУ, Хэбэй хотын Их сургууль
4	Ү.Мөнхдагва	Босоо Монгол бичгийг хэрэглэх боломжийг судалсан нь	БНХАУ, Хөх хот
5	Ш.Бат-Эрдэнэ	Өндөр зэрэгтэй тамирчдын бие бялдрын хөгжилт, бэлтгэлжилт болон Морфофункциональ онцлогийг судалсан нь	АШУУИС
6.	Э.Золжаргал	Дасгал хөдөлгөөн хүүхдийн сэтгэхүйн үйл ажиллагаанд нөлөөлөх нь	МУБИС

Өөрөөр хэлбэл, дээр өгүүлсэн нэг сэдэвт бүтээл дээр судалгаа хийж буй баг үр бүтээлтэй ажиллаж байгаа гэж үзэж болно. Тухайлбал, судлаачдын багийн ахлагч Л.Алтанцэцэг 1998 онд ОХУ –ын Москва хотын Бүх Оросын Биеийн тамирын эрдэм шинжилгээний хүрээлэнд **“Монгол улсын сургуулийн бага насны хүүхдүүдийн бие бялдрын хөгжилт, бэлтгэлжилтийн судалгаа”** сэдвээр боловсролын дэд докторы зэрэг хамгаалсан.

2015 онд ОХУ-ын Биеийн тамир, спорт, аялал жуулчлал, залуучуудын бодлогын Их сургуульд **“Монголын цаг агаар, газар зүйн янз бүрийн бүсэд суралцагчдын бие бялдрын хөгжилт, бие бялдрын бэлтгэлжилтийг харьцуулсан судалгааны үр дүнд тулгуурлан биеийн тамирын хичээлийн хөтөлбөрийг өргөжүүлэх сурган хүмүүжүүлэх үндэслэлүүд”** сэдвээр шинжлэх ухааны докторын (Sc.D) зэрэг хамгаалсан юм.

Судлаач багш Л.Гүндэгмаа 2009 онд ОХУ-ын Ломоносовын нэрэмжит Их сургуульд **“Монголын оюутан залуучуудын морфофункциональ онцлог генетикийн хүчин зүйлээс хамаарах нь”** сэдвээр биологийн ухааны докторын зэрэг хамгаалсан бөгөөд эдүгээ ОХУ-ын Москва хотын БТС, залуучууд, аялал жуулчлалын Их сургуулийн шинжлэх ухааны докторантурт суралцаж байна.

Багш, судлаач Д.Баасанхүү БНХАУ-ын Өвөр Монголын Их Сургуулийн докторантурт **суралцан “Монгол Төрийн Гаалийн Яамны түүхийн судалгаа”** сэдвээр дэд докторын зэрэг (2015 он) амжилттай хамгааллаа.


Биеийн тамирын эмчилгээ арга зүйн тэнхимийн багш Р.Түвшинжаргал нь МУБИС-ийн докторантурд суралцаж **“Тархины саатай хүүхдийн хөдөлгөөнийг засахад биеийн тамирын дасгал хэрэглэсэн үр дүн, арга зүйн судалгаа”** сэдвээр дэд докторын зэрэг (2018 он) амжилттай хамгааллаа.

Манай хамт олон үндэсний болоод гадаад хамтын ажиллагааны хүрээнд хамтарсан туршилт, судалгааны тодорхой ажлуудыг хэрэгжүүлж байна.

ҮБТДС –ийн мэргэжлийн тэнхимүүд, эрдэмтэд, багш, дасгалжуулагчид өөрийн орны болон гадаадын ижил төстэй сургууль, эрдэм шинжилгээний байгууллага, спортын хороо, нийгэмлэг, клубүүдтэй түншлэлийн холбоо тогтоон судлаачид, багш, дасгалжуулагчид солилцон мэргэжил дээшлүүлэх, эрдмийн зэрэг хамгаалах, эрдэм шинжилгээ, судалгааны төсөлт ажил хэрэгжүүлэх, тамирчдын хамтарсан бэлтгэл хийх зэрэг бидэнд үр өгөөжөө өгч болох хамтын ажиллагааны боломжит бүхий л хэлбэрүүдийг ашиглан ажиллаж ирлээ.

Зураг 44

**Сургалтанд хамрагдсан багшийн тоо ба хэрэгжүүлсэн төслийн тоо
(2016-2018 оноор)**




Дэлхийн хэд хэдэн орны мэргэжил нэгт их, дээд сургуулиудтай харилцаа тогтоон хамтран ажиллаж байна. Тухайлбал, Япон Улсын Хасагава хотын БТШУИС (2002), ОХУ-ын Москва хотын Биеийн тамир, спорт, Аялалын Их сургууль, Украин улсын Киевийн БТС-ын Их сургууль (2009), Япон Улсын Токиогийн СШУИС (2010), БНХАУ –ын Бээжингийн Биеийн тамирын Их сургууль (2011 он)-тай хамтын ажиллагааны гэрээ, хэлэлцээртэй ажиллаж, БНХАУ –ын ӨМӨЗО –ны Хөх хот болон бусад хот, аймгийн биеийн тамир, спортын сургууль, клубүүд, ОХУ-ын Буриад Улсын Улаан-Үд, Якутын спортын нийгэмлэг, клубын баг, тамирчидтай хамтарсан бэлтгэл сургууль уламжлал болон тогтсон билээ.

Хамтарсан судалгааны багийн бүрэлдэхүүнд судлаачдын төслийн баг хамаарагдана. Энэ багийн үйл ажиллагааны үндсэн зорилго нь судлаачид өөрсдийн мэргэшсэн судалгааны чиглэлээр хамтран өөрийн орны биеийн тамир, спорт, боловсрол, эрүүл мэндийн салбарын тулгамдаж буй нэн чухал асуудлаар болон төрийн бус байгууллага, эрдэм шинжилгээний хүрээлэн, олон нийтийн байгууллагатай хамтран төсөл боловсруулан хэрэгжүүлж улмаар сургуулийн сан хөмрөгт хувь нэмрээ оруулах, хамгийн чухал нь судлаач өөрийн эрдэм шинжилгээ, судалгааны ажлын бодит, баталгаатай эх сурвалжтай болоход оршино.

Зураг 45



Зураг 46




Төслийн талаар материал /хавсралт 6-7/

Бид стратегийн зорилгодоо судалгааны ажлыг явуулах хамтын ажиллагааг өргөжүүлэх (1.3) зорилт дэвшүүлж, түүний шалгуур үзүүлэлтэд байгууллагуудтай хамтран гүйцэтгэх гэрээт төсөл, захиалгат ажил байхаар зорилгоо тодорхойлсон юм. Энэ хүрээнд манай судалгааны баг сүүлийн жилүүдэд дараах байгууллагуудтай хамтарч нийтдээ 11 томоохон төсөлт эрдэм шинжилгээ, судалгааны цогц төслийг хэрэгжүүлсэн байна.

Үүнд:

1. Эрүүл мэндийн яам, АНУ –ын мянганы сорилтын сан-1
2. Эрүүл мэндийн яам, АНУ –ын мянганы сорилтын сан-2
3. Эрүүл мэнд спортын яамны харьяа БТХТ-ийн эрдэм шинжилгээний алба
4. Ломносовын нэрэмжит Москвагийн их сургуулийн Антропологийн хүрээлэн-
5. Ломносовын нэрэмжит Москвагийн их сургуулийн Антропологийн хүрээлэн-2
6. Ломносовын нэрэмжит Москвагийн их сургуулийн Антропологийн хүрээлэн-3
7. БСШУЯ-ны харьяа Боловсролын хүрээлэн
8. Спортын бэлтгэлийн төвийн эрдэм шинжилгээний алба
9. Японы хүүхдийн эрүүл мэндийн хөгжлийн төв, Цукуба их сургууль
10. Чех улсын Чарльстоны их сургууль
11. ЗГХА, Биеийн тамир спортын газар

ҮБТДС-тай хамтарч эрдэм шинжилгээний төсөл хэрэгжүүлсэн байгууллагууд



Шалгуурын энэ хэсэгт өөрийн улсын зохих газруудтай хамтран хэрэгжүүлсэн төсөлт ажлын гүйцэтгэлийн талаар өгүүлбэл:

1. “Үндэсний шигшээ багийн тамирчдын бие бялдрын ерөнхий хөгжилт, бэлтгэлжилтийн түвшин тогтоох судалгаа” төсөлт ажил .

Судлаач Л.Алтанцэцэгээр удирдуулсан энэхүү төсөлт ажил нь хугацааны хувьд хоёр үе шаттай хэрэгжсэн бөгөөд 2014 онд Соёл, Спорт, Аялал Жуулчлалын Яамны харьяа Спортын бэлтгэлийн Төвийн Эрдэм шинжилгээний албатай хамтран ажилласан. 2015 онд Эрүүл Мэнд, Спортын Яамны Биеийн тамир, спортын хөгжлийн Төвийн эрдэм шинжилгээний албатай хамтран уг судалгааг хийсэн юм. 2018 онд Доктор Л.Гүндэгмаа БСШУСЯ-ны ШУТС-ийн суурь судалгааны төсөлт ажил бичиж Үндэсний шигшээ багийн тамирчдын мониторинг хийх судалгааг үргэлжлүүлэн хэрэгжүүлж байна.

Хүснэгт 35



УБТДСургуульд БТС-ын байгууллагатай хамтран хэрэгжсэн эрдэм шинжилгээ - судалгааны төсөлт ажлууд



№	Төсөлт ажлын нэр	Санхүүжилт		Хамтрагч	Хэрэгжсэн хугацаа	Үр дүн
		Байгууллага	Мөнгөн дүн			
6	“Үндэсний шигшээ багийн тамирчдын бие бялдрын ерөнхий хөгжилт бэлтгэлжилтийн түвшин тогтоох судалгаа”	ССАЖЯамны харьяа Спортын бэлтгэлийн төв	1.6 сая ₮	Спортын бэлтгэлийн төвийн эрдэм шинжилгээний алба	2014 онд	Тамирчин тус бүрийн бие бялдрын ерөнхий бэлтгэлжилтийн загвар гаргасан, удирдамж зөвлөмж тайлан гаргасан, ЭШ-ний өгүүлэл
7	“Үндэсний шигшээ багийн тамирчдын бие бялдрын ерөнхий хөгжилт бэлтгэлжилтийн түвшин тогтоох судалгаа”	Эрүүл мэнд спортын яам	2.3 сая ₮	БТСХөгжлийн төвийн эрдэм шинжилгээний алба	2015 онд	Тамирчин тус бүрийн бие бялдрын ерөнхий бэлтгэлжилтийн загвар гаргасан, зөвлөмж тайлан гаргасан, ЭШ-ний өгүүлэл

2. Боловсрол, Соёл, Шинжлэх Ухааны Яамны харьяа Боловсролын хүрээлэнтэй хамтран 2014-2016 онд “Монгол хүүхдийн Шалгуур үзүүлэлт” төслийн хүүхдийн бие бялдрын хөгжилт, бэлтгэлжилтийн түвшин тогтоох эрдэм шинжилгээ, судалгааны төсөлт ажлыг хэрэгжүүлээд байна.

“Монгол хүүхдийн Шалгуур үзүүлэлт” төслийн Хүүхдийн бие бялдрын хөгжилт, бэлтгэлжилтийн түвшин тогтоох төсөл, түүний үр дүнг дор өгүүлэв.

3. Бид гадаад түншлэлийн хүрээнд хэд хэдэн төслийг амжилттай хэрэгжүүллээ. Тухайлбал, Эрүүл мэндийн яам, АНУ-ын Мянганы сорилтын сангийн санхүүжилтээр эрүүл мэндийн 2 томоохон төсөл хэрэгжүүлсэн. Үүнд:

- "Идэвхтэй хөдөлгөөнөөр хэрэгжүүлэхэд саад болж байгаа бэрхшээлүүдийг судлах" сэдэвт төсөл 2010-2011 онуудад хэрэгжсэн бөгөөд тайлан, зөвлөмж, эрдэм шинжилгээний өгүүлэл нийтлэгдсэн.
- "Халдварт бус өвчин, осол гэмтэлд өртсөн хүмүүст зориулсан эрүүлжүүлэн чийрэгжүүлэх эмчилгээний биеийн тамирын хичээлийг зохион байгуулж, хөтөлбөр боловсруулж, эрүүл мэндийн боловсрол олгох" сэдэвт төсөл 2012-2013 онуудад хэрэгжсэн бөгөөд үр дүнд нь эрүүлжүүлэх хичээлийн хөтөлбөр, тайлан, зөвлөмж, эрдэм шинжилгээний өгүүлэл хэвлэгдэж, хичээлийн хэрэгсэл материал бүхий цогц танхим байгуулагдсан.

4. Японы хүүхдийн хөгжлийн үндэсний төвтэй хамтарсан төсөл

Хүснэгт 36

Төсөлт ажлын нэр	Санхүүжилт		Хамтрагч	Хэрэгжих хугацаа	Үр дүн
“Сургуульд суурилан хийгдэх хөдөлгөөнт дасгалын хөтөлбөр нь хүүхдийн танин мэдэхүй болон эрүүл мэндэд нөлөөлөх нь” сэдэвт хамтарсан төсөл	Байгууллага	Мөнгөн дүн	Цукуба их сургуулийн эрдэмтдийн баг	2017-2020 он	Судалгааны үр дүнд СБД-ийн 11 сургууль 4 дүгээр ангийн 2000 орчим сурагч “SPARTS” дасгалыг өдөр бүр хийж IQ бие бялдрын хөгжилд бэлтгэлжилтийн түвшин дээшилнэ.
	Япон улсын хүүхдийн эрүүл мэндийн хөгжлийн үндэсний төв	4.0 сая иен			

Манай сургуулийн судлаач багш нарын бүтээл гадаадын нэр хүндтэй сэтгүүлд хэвлэгдсээр байна.

Заримаас нь дурдахад

1. “Thomson Reuters” –олон улсын шинжлэх ухааны ишлэгддэг (Филадельфийн жагсаалт) индексд бүртгэлтэй Теория практика физической культуры, Физическая культура, Спортивная медицина, Вестник спортивной науки, Учёные записки ун.им. Лесгафта г.м. сэтгүүлүүдэд тус сургуулийн багш нарын 100 гаруй хуудас 33 эрдэм шинжилгээний өгүүлэл нийтлэгдсэн байна.
2. EBSCO– Англи хэлээр нийтлэгддэг тогтмол хэвлэлийн баазад бүртгэлтэй “Теория практика физической культуры” болон “Физическая культура” сэтгүүлд сургуулийн багш нарын 100 гаруй хуудас 30 гаруй эрдэм шинжилгээний өгүүлэл нийтлэгдсэн.

3. ОХУ-ын шинжлэх ухааны ишлэлийн индексд бүртгэлтэй “Залуу судлаачид”, “Шинжлэх ухааны ололт амжилт” г.м. сэтгүүлүүдэд бүтээлээ хэвлүүлдэг.
4. Олон улсын Олимпийн хорооны “Olympic review” сэтгүүлд 1 бүтээл Японы “Спортын шинжлэх ухааны их сургууль”-ийн сэтгүүлд 2 бүтээл хэвлэгдсэн байна.
5. ОХУ, Солонгос, Хятад, Казакстан, Тайланд зэрэг орны эрдэм шинжилгээний хуралд оролцож, илтгэлүүд хэлэлцүүлэн, 10 гаруй бүтээлээ хэвлүүлсэн байна.

Мөн Ломоносвын нэрэмжит Москвагийн их сургуулийн шинжлэх ухааны мэдээлийн istina.msu.ru сайтанд 17 хамтарсан бүтээлүүд бүртгэгдсэн байна. (Үүнээс эрдэм шинжилгээний өгүүлэл – 6, илтгэл -7, хураангуй -4) , Манай хамт олон Олон улсын хэмжээний эрдэм шинжилгээ, судалгаа, инновацийн мэдээллийн санг ашиглаж байдаг.

Инноваци бол шинэ мэдлэгийг баялаг болгон хувиргах үйл явц юм. Энэ үйл явцад инновацийн мэдээллийн сан нэн чухал бөгөөд бид УИХ-аас баталсан “Инновацийн тухай” хуулийн зохих заалтын дагуу инновацийн мэдээллийн сан байгуулахад анхаарч олон улсын хэмжээний эрдэм шинжилгээ, судалгаа, инновацийн мэдээллийн сангийн эх үүсвэрүүдийг багш, судлаач бүр мэдээллийн төрөл бүрийн сувгуудыг боломжийн хэрээр ашиглаж судалгааны ажилдаа ашиглаж байна. Бид одоохондоо биеийн тамир, спортын салбарт хамаарах инновацийн нэгдсэн сан бүрдүүлж амжаагүй байна. Судлаач бүр өөрсдийнхөө сонирхсон сэдэв, асуудлаар мэдээлэл олохоос хэтрэхгүй байгаа ч гэсэн манай судлаачид тодорхой хэмжээгээр боломжоо ашиглаж байгаа.

Дэлхийн эрүүл мэндийн байгууллагын www.who.com сайтад бүртгэгдсэн бөгөөд дэлхийн улс орнуудын болон Монгол Улсын хүн амын эрүүл мэндийн талаарх сүүлийн үеийн мэдээллийг шуурхай авч, судалгаа, сургалтын ажилдаа ашигладаг. Тухайлбал Доктор, профессор Л.Гүндэгмаа ДЭМБ-аас 2016 оны 05 сарын 19-ны өдөр 18:55 цагт Дэлхий дээр 5 хүртэлх насны хүүхдийн нас баралт 5,9 сая байна гэх мэт мэдээллийг авч байсан баримт байгаа.

8.3. Судалгааны санхүүжилт. Сургуулийн санхүүгийн төлөвлөлтөд эрдэм шинжилгээ, судалгааны ажилд зориулсан төсөв тодорхой хэмжээгээр тусгагдаж, үр дүнг нь тооцон тайлагнадаг уламжлалтай. Тухайлан сүүлийн 8 жилийн эрдэм шинжилгээний ажилд зориулсан санхүүжилтийн үзүүлэлтийг танилцуулъя.

Сургуулийн эрдэм шинжилгээний ажлын зардал

	2010-2011	2011-2012	2012-2013	2013-2014	2014-2015	2015-2016	2016-2017	2017-2018	Дүн
Төсөлт ажил (сая төгрөг)	5.3	17.5	23.7	23.7	24.7	43.0	44.0	67.3	249.2
Багш нарын ЭША (сая төгрөг)	4.6	6.2	9.1	10.4	14.0	16.8	17.2	22.9	101.2
Дүн	9.9	23.7	32.8	34.1	38.7	59.8	61.2	90.2	350.4
Зарлага (сая төгрөг)	483.2	620.4	756.3	912.4	898.7	778.9	870.8	1035.1	6355.9
ЭША-ын зардлын эзлэх %	2.0	3.8	4.3	3.7	4.3	7.7	7.0	8.7	41.7

2010 онд тус сургуулийн ЭША-ын нийт зардал 9,9 сая төгрөг байсан бол 2018 онд 90,2 сая төгрөг болж өсчээ. Сургуулийн 2010-2011 оны нийт зардлын 2% байсан бол 2017-2018 оны хичээлийн жилд 8,7% болж өссөн үзүүлэлттэй байна. Өөрөөр хэлбэл, Эрдэм шинжилгээ, судалгааны ажлын зардлын эзлэх хувь дээрх хугацаанд 4,3 дахин өссөн байна.

Сургуулиас зарцуулсан эрдэм шинжилгээ, судалгааны ажлын энэхүү санхүүжилт бидэнд үр ашгаа өгсөөр байгаа. Тухайлбал, сургуулийн төсвөөр хийгдсэн эрдэм шинжилгээ, судалгааны ажлын эх сурвалжаар тус сургуулийн нэг багш шинжлэх ухааны докторын зэрэг, нэг багш докторын зэрэг хамгаалсан бол одоо нэг багшийн биологийн шинжлэх ухааны докторын диссертаци, 3 багшийн дэд докторын диссертаци бичигдэж байна.

Биеийн тамир, спортын салбар бол нийгэмд үйлчилдэг онцлогтой учир бид төсөлт ажлаасаа олсон орлогыг зөвхөн сургуулийнхаа материаллаг баазыг бэхжүүлэх, багш дасгалжуулагч, оюутан тамирчдынхаа ур чадварыг дээшлүүлэх, сургалт, судалгааны ажилд зарцуулж байна.

Харин судалгаа, төсөлт ажлын эх үүсвэр олон төрөл байж болох бөгөөд тухайн санхүүгийн эх үүсвэрийг нэмэгдүүлэхийн төлөө санаачилгатай ажиллах нь бидний үүрэг гэж үзнэ.

Сүүлийн жилүүдэд эрдэм шинжилгээ, судалгааны ажилд зарцуулсан зардлын хураангуйг дор мэдээлье.

ҮБТДС-ийн эрдэм шинжилгээ, судалгааны төсөлт ажлын зардал

№	Судалгааны төрөл	2010, 2011	2012, 2013	2014-2015	2017-2018	Дүн	Үр дүн
1	Орос монголын хамтарсан судалгаа:						
1.1	Шинжлэх ухаан, технологийн сангаас	8.0	6.0	0	10,0	24.0	7334 хүүхэд өсвөр үеийнхний иж бүрэн судалгаа бүхий тайлан гаргаж өгсөн
1.2	ҮБТДС	10.0	14.4	0	6.5	30.4	ШУ-ны докторын ажил 1, боловсролын докторын ажил 1 хамгаалагдсан
2	Эрүүл мэндийн төсөлд:	4.8	27.1	7.6		39.5	-
2.1	Мянганы сорилтын сангаас /3000\$/	4.8	0.0	0.0		4.8	ХБӨОГ-д өртсөн хүмүүст зориулсан эрүүлжүүлэх хичээлийг зохион байгуулсан хөтөлбөр, гарын авлага боловсруулсан.
2.2	Мянганы сорилтын сангаас /15000\$/	0.0	21.8	7.6		29.4	
2.3	ҮБТДС	0.0	5.3	0.0		5.3	
3	“Монгол хүүхдийн Шалгуур үзүүлэлт”	0.0	0.0	14.4		14.4	-
3.1	Боловсролын хүрээлэнгээс	0.0	0.0	11.4		11.4	Иж бүрэн антропометрийн багаж тоног төхөөрөмжийг авч өгсөн, судалгааны удирдамж боловсруулсан.
3.2	ҮБТДС			3.0		3.0	

4	Монголын тамирчдын бие бялдрын ерөнхий бэлтгэлжилтийн судалгаа	0.0	0.0	2.7	6.5	9.2	Шигшээ багийн 296 тамирчны иж бүрэн судалгааг явуулж тамирчин бүрийн давуу, сул талын оношилгоог хийж, өндөр зэрэгтэй тамирчны функциональ чадварын модель загварыг боловсруулж сургалт, дасгалжуулалтад хэрэгжүүлж байна.
5	Хөгжимт хөдөлгөөн дасгалаар хүүхдийн бие бялдар, сэтгэн бодох чадварыг дээшлүүлэх нь”				67.3	67.3	УБ хотын, СБД-ийн ЕБ-ын 11 сургуулийн 2000 гаруй 9-10 насны хүүхдүүдийг хамруулж, дасгал хийлгэж бие бялдрар, сэтгэн бодох чадварыг нь дээшлүүлэв.
	Нийт дүн	27.6	74.6	46.7	89.8	238.7	

SWOT шинжилгээ

ҮБТДС-ийн материаллаг болон технологийн нөөцийн давуу тал, сул тал, боломж, эрсдлийг тодорхойлох зорилгоор SWOT шинжилгээг гүйцэтгэлээ.

SWOT шинжилгээ / Эрдэм шинжилгээ, инноваци /

<p>Давуу тал</p> <ul style="list-style-type: none"> • Дэлхийн спортын чиг хандлагад нийцсэн биеийн тамир, спорт, эрүүл мэндийн чиглэлийн шинжлэх ухаан, инновацийн онол, практикт суурилсан сургалт, судалгааны иж бүрэн арга зүй, техник технологийг ашиглан гардан гүйцэтгэх чадвар бүхий мэргэжлийн багтай юм. • Хүний бие бялдрын хөгжилт, бэлтгэлжилтийн түвшин тогтоох морфофункциональ үзүүлэлтүүдийг оношлох хамгийн сүүлийн үеийн иж бүрэн техник, тоног төхөөрөмж бүхий лабораторийн болон хээрийн багажтай. • Гадаад, дотоодын байгууллага, эрдэм шинжилгээний хүрээлэнгүүд, олон улсын сангуудтай хамтран судалгааны төсөл хэрэгжүүлж ажилладаг. • Хамтарсан төслийн уралдаанд сүүлийн 10 жил шалгарч 240,0 орчим сая төгрөгийн санхүүжилтыг БСШУСЯ-ны Шинжлэх ухаан технологийн сан, АНУ-ын мянганы сорилтын сан, Японы хүүхдийн эрүүл мэндийн хөгжлийн төв зэргээс авсан тооцоо байна. 	<p>Боломж</p> <ul style="list-style-type: none"> • Биеийн тамир спортын салбарт судалгаа шинжилгээний ажил хийх арга барилд суралцах боломж гарч оюутан, магистрантын тоо, судлаач багшийн тоо нэмэгдэж байна. • Судалгаа шинжилгээний хамтарсан төслүүд хэрэгжсэнээр орлого нэмэгдэх боломжтой байна. • Шинжлэх ухааны үндэслэлтэйгээр сургалт дасгалжуулалтыг явуулж тамирчдын ур чадварыг нэмэгдүүлэх боломжтой. • Гадаад, дотоодын индекс, нэр хүндтэй сэтгүүлүүдэд багш нарын бүтээл хэвлэгдэж байна. • Судалгааны үр дүнгээр гадаад дотоодын олон улсын хуралд оролцож байна.
<p>Сул тал</p> <ul style="list-style-type: none"> • Судалгаа шинжилгээний багаж төхөөрөмж, хэрэгсэл материал ховор, олдоц багатай тул гадаадаас авах, захиалж авах шаардлага гардаг. 	<p>Эрсдэл</p> <ul style="list-style-type: none"> • Судалгаа шинжилгээний багаж төхөөрөмж, хэрэгсэл, материал ховор, олдоц багатай тул гадаадаас авахад зардал нэмэгдэх нь хүндрэлтэй.

Цаашид сургуулийн зүгээс Эрдэм шинжилгээ, инновацийг өргөжүүлэх, сайжруулахын тулд дараах арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлэхээр төлөвлөж байна. Үүнд:

1. Гадаад дотоодын судалгааны ажлын төсөл хөтөлбөрийг үргэлжлүүлэх, шинийг эрэлхийлж, судалгааны санхүүжилтийг нэмэгдүүлэх.
2. Лабораторийн хэрэгсэл материалын зардлыг жил бүр төсөвт нэмэх.
3. Судалгааны арга барилыг багш, оюунуудад эзэмшүүлж, олноор төсөлд хамруулах зэрэг болно.

ШАЛГУУР 9. ЧАНАРЫН БАТАЛГААЖУУЛАЛТЫН ТОГТОЛЦОО

Сургууль нь өөрийн үйл ажиллагааны чанарын бодлоготой, түүнийхээ баталгааг хангах чанарын удирдлагын тогтолцоог төлөвшүүлж ажиллана. Энэхүү чанарын удирдлагын тогтолцоо нь өөрийн болон гадны хамтран ажиллагчдын оролцоог хангасан байхаас гадна үндэсний болоод олон улсын хэмжээнд хүлээн зөвшөөрөгдөхөд дэмжлэг үзүүлэхэд оршино.

9.1. Чанарын удирдлагын бодлого: “Монгол Улсын нийт ард иргэдийн бие бялдрын хөгжил, бэлтгэлжилт, спортын амжилтыг эрхэмлэн, төгсөгчдөд ажил олгогч төрийн болон төрийн бус байгууллагуудын сэтгэл ханамжийг дээдэлсэн биеийн тамир, спортын боловсролын үйлчилгээг үзүүлж, чанарын удирдлагын тогтолцоог тасралтгүй сайжруулдаг, өөрчлөлт шинэчлэлтийг түгээгч Их Сургууль болно” гэж шинэчлэн тодорхойлж, Эрдмийн Зөвлөлийн 2017 оны 5 дугаар сарын 5-ны 08 тоот тогтоолоор баталгаажуулан хэрэгжүүлж байна.

ҮБТДС үүсгэн байгуулагдсан цагаасаа эхлэн үйл ажиллагааны дотоод хяналтыг удирдлагын арга барилын нэг болгон үйл ажиллагааны чанарын дотоод хяналтын тогтолцоог хэрэгжүүлж ирсэн уламжлалтай.

- Монгол Улсын Засгийн газрын 2011 оны 311 дүгээр тогтоолын хавсралт болох "Аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагаанд дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах нийтлэг журам"-ыг үндэслэн ҮБТДС-ийн "Дотоод хяналт, чанарын баталгаажуулалтын алба"-ны ажиллах журмыг боловсруулан баталж, түүнийг үндсэн удирдлага болгон ажиллаж байсан;

- “Дотоод хяналт, чанарын баталгаажуулалтын алба”-ны ажиллах журмыг 2016 оны 10-р сарын 10-нд ҮБТДС-ийн захирлаар батлуулж үндсэн удирдлага болгож байв. (“Албан хөтөч” 60-64-р хуудас)

-2017 оны 10-р сарын 09-нд уг албаны нэрийг БМИҮЗ-ийн зөвлөмжийн дагуу нэрийг нь өөрчилж “Чанарын дотоод баталгаажуулалтын алба” болгож ажиллах журмыг батлав. (хавсралт-4)

-2018 оны 12-р сарын 25-нд ҮБТДС-ийн захирлын 44 тоот тушаалаар “Чанарын дотоод баталгаажуулалтын алба” –ны бүрэлдэхүүн болон ажлын төлөвлөгөөг шинэчлэн батлав. (хавсралт-4,5)

Сургуулийн “Чанарын дотоод баталгаажуулалтын алба”-ны тогтолцоо нь сургуулийн дотоод нэгжүүд болон багш ажилтнуудын бие даасан байдал, эрх чөлөөгөө ханган ажиллахад дэмжлэг үзүүлж улмаар хамт олны үйл ажиллагааны чанарын баталгааг хангах бодлого баримтлан ажилладаг.

9.2. Чанарын дотоод удирдлагын тогтолцоо, журам: Сургуулийн үйл ажиллагаанд чанарын дотоод баталгаажуулалтын үнэлгээ хийх ажлын зорилго нь сургалтын стандартын шаардлагыг хангахад туслах, сургуулиа хөгжүүлэх, дотоод үйл ажиллагааг нь боловсронгуй болгож туслахад оршино.

Сургуулийн Чанарын дотоод баталгаажуулалтын албаны дотоод хяналт, шинжилгээ, үнэлгээний үйл ажиллагаа нь сургуулийн эрхэм зорилго, зорилт, төлөвлөлт, эрх зүйн зохицуулалт, хүний нөөц, сургалтын материаллаг болон

технологийн нөхцөл, сургалтын хөтөлбөр, суралцагсад, тэдэнд чиглэсэн үйлчилгээ, эрдэм шинжилгээ, судалгааны ажил, сургуулийн нийгэмд чиглэсэн үйлчилгээ, гадаад харилцаа зэрэг сургуулийн үйл ажиллагааны бүхий л хүрээний орц, гарц, явцын үр дүнгийн асуудлыг хамарна.

“Алба” нь сургуулийн дотоод хяналт – шинжилгээ хийх, үнэн зөв мэдээлэл авах, үнэлгээ өгөх, зөвлөмж гаргах, хариу авах эрхтэйгээр ажилладаг.

“Алба” нь бодит мэдээлэлд үндэслэн хяналт, шинжилгээ хийх, хяналт шинжилгээн дээр үндэслэн үнэлгээ, дүгнэлт, зөвлөмж гаргах, сургуулийн дотоод үйл ажиллагааг хэвийн явуулах нөхцөл боломжоор хангах, дэмжих, хяналт, шинжилгээний үр дүнгийн талаар сургуулийн удирдлагатай санал солилцох, мэргэжлийн байгууллагуудаас зөвлөгөө авах үүрэгтэйгээр ажилладаг.

“Алба” нь чанарын дотоод баталгаажуулалт хийхийн тулд “чанарын хяналт – шинжилгээ, үнэлгээний баг” томилон ажиллуулдаг.

“Баг” нь “Алба”-аас баталсан удирдамж, төлөвлөгөөний дагуу БМИҮЗ-ийн магадлан итгэмжлэх шалгуур үзүүлэлтүүдийн биелэлтэд хяналт тавьж үр дүнг баталгаажуулна.

“Алба” нь дор дурдах үндсэн Шалгуур үзүүлэлтүүдээр хяналт – шинжилгээ хийж, үнэлгээ өгнө. Үүнд:

1. Эрхэм зорилго, зорилтууд
2. Засаглал ба эрх зүйн зохицуулалт
3. Сургалтын хөтөлбөрийн удирдлага
4. Хүний нөөц
5. Материаллаг болон технологийн нөөц
6. Суралцагчдад чиглэсэн үйлчилгээ
7. Нийгэмд чиглэсэн үйлчилгээ
8. Эрдэм шинжилгээ, инноваци
9. Чанарын баталгаажуулалтын тогтолцоо

“Алба” нь хяналт – шинжилгээ хийж, үнэлгээ өгч баталгаажуулсан тухайгаа сургуулийн удирдлага, хамт олонд албан ёсны тайлангаар болон хэвлэл, мэдээллийн хэрэгслээр мэдээлэх үүрэг хүлээн ажиллаж байна.

“Алба” –ны гишүүдийг БСШУСЯ, БМИҮЗ-өөс зохион байгуулж байгаа бүхий л сургалт хэлэлцүүлэгт хамруулж, мэдлэг боловсролыг дээшлүүлэх арга хэмжээг тогтмол хэрэгжүүлдэг.

Тус сургуулийн чанарын дотоод баталгаажуулалтын албанаас сургалтын чанарыг дээшлүүлэхэд ашиглах зорилгоор багш нараас сэтгэл ханамжийн судалгааг авч, гарсан үр дүнг нь үйл ажиллагаандаа ашигладаг. (Энэхүү санал асуулгын үр дүнг тоймлон “Шалгуур 4”-н 50-54-р хуудсанд тусгасан болно).

Багш, ажилчдын ажлын явцыг хянах “Нано софт” ХХК-ны 30 камерыг сургуулийн бүх анги танхим, заал талбайд байрлуулсан бөгөөд сургуулийн сургалтын албанаас TCL LED дэлгэцээр нэг доор зэрэг хянах системтэй.

Багш, ажилчдын ажлын гүйцэтгэлийг “Нано софт” ХХК – ны “Fingerprint Attendance Management” программ бүхий хуруу танигч электрон машинаар ажлын

цагийг бүртгэдэг системийг нэвтрүүлсэнээр цагийн ашиглалт, ажлын бүтээмж дээшилсэн.

9.3: Удирдлагын мэдээллийн систем: Сургууль нь орчин үеийн мэдээлэл, харилцааны технологид суурилсан удирдлагын мэдээллийн системийг бүрдүүлэн үр ашигтай ажиллуулж, байнга боловсронгуй болгон хөгжүүлдэг байна. Сургуулийн Unimis удирдлагын мэдээллийн систем нь сургалтын болон санхүүгийн модуль гэсэн хэсэгтэй. Үүнд дараах мэдээллүүд багтдаг юм.

Хүснэгт 40

Программ хангамжийн үндсэн модулиуд

Багшийн вэб	Оюутны вэб	Санхүүгийн модуль	Сургалтын албаны-ны модуль	Лавлах сан
Ашиглаж буй программ хангамж				
UNIMIS		LIB4U PC	Санхүүгийн Модуль	Мэдээллийн сүлжээ
Багш	Оюутан	Номын сан		
-Товч мэдээлэл -Заах хичээлүүд -Оюутны хичээл сонголт хуваарилалт -Хичээлийн дүн оруулах	-Товч мэдээлэл -Дүнгийн мэдээлэл	-Электрон каталоги -Номын бүртгэл -Уншигчийн бүртгэл -Үйлчилгээний бүртгэл	-Дэлгэрэнгүй тайлан -Балансын тайлан -Хавсралт тайлан	-Албан ажлын өрөө -Хичээлийн танхим, лаборатори, кабинет

Зураг 48

Үндэсний Биеийн Тамирын Дээд Сургуулийн Удирдлагын Мэдээллийн Систем

оюутны дэлгэрэнгүй мэдээлэл

ТУСЛАМЖ

Бүртгэл Дэлгэрэнгүй сайт

Ургийн овог	Овог Монгол	Овог Англи	Нэр Монгол	Нэр Англи	Гар утас
Калимат	Бэхтберди	Bekhtbyrdi	Абутали	Abutaliv	99229
Хүлд	Батжаргал	batjargal	Адьяабаяр	adyabayar	91253
Тучин	Наранхүү	Narankhuu	Адьяахүү	Adyaakhuu	86081
Хонч Жамба	Амарсайхан	Amarsaikhan	Адьяасүрэн	Adyaasuren	80242
Вандай	Энхбаатар	Enkibaatar	Адьяасүрэн	Adyaasuren	94945
Их монгол	Нямхүү	Nyamkhuu	Азжаргал	Azjargal	96461
Баянөлгий	Жанжимхан	Janimkhan	Айболот	Aibolot	94469
найман	Канзилбек	Kanzilybek	Айдос	Aidos	99834
Шыбарайгыр	Мануарбек	Manuarbyek	Айдос	Aidos	95429

Дээрх мэдээллийн баазыг дараах байдлаар ашигладаг юм.

1.Сургалтын UNIMIS программ дахь мэдээлэл:

А.Багш:

- Багш нарын ажил мэргэжил, цол зэрэг, ур чадварын тухай мэдээлэл
- Багш нарын мэргэшиж заах хичээлүүдийн тухай мэдээлэл
- Хичээлийн хөтөлбөрүүд
- Багшийн хичээл хувиарлалтын мэдээлэл
- Хичээлийн дүнгийн тухай мэдээлэл

Б.Оюутан:

- Оюутны дэлгэрэнгүй бүртгэл
- Оюутны дүнгийн мэдээлэл
- Ирц, явц, дахин шалгал, дүнгийн тодорхойлолт хэвлэх

В.Номын сан: Багш, ажилтан, оюутан, сурагчдад уншигчийн картаар ном олгож үйлчилдэг.

2.Удирдлагын UNIMIS программ дах мэдээлэл:

А.Санхүүгийн:

- Төлбөрийн тохиргоо хийх
- Төлбөр бүртгэх
- Төлбөрийн олон төрлийн тайлангууд

Б.Сургалтын албаны модуль:

- Багш ажилтныг программд бүртгэх
- Хичээл бэлтгэх
- Хичээлтийн төлөвлөгөө боловсруулах
- Багшид хичээл хувиарлах
- Сургуулийн үндсэн мэдээллүүдийг хадгалах
- Хандах эрхийн тохиргоо хийх

В.Удирдлагын хянах самбар:

- Оюутнуудын төлбөрийн мэдээ
- Мэргэжлийн зэргийн ангилал
- Статистик тоо
- Бусад мэдээлэл харах хянах хэсгийг энэ программд боловсруулж нэвтрүүлсэн.

Энэхүү программ хангамжийг цаашид хөгжүүлэн зарим нэг модулийг нэвтрүүлнэ. Жишээ нь хүний нөөцийн модулийг нэвтрүүлэх. Мөн энэ программыг сургуулийн web site, БСШУСЯ-ны сайттай холбон ажиллуулах боломжтой.

9.4.Олон нийтийн мэдээлэл ба үйл ажиллагааны ил тод байдал:

ҮБТДС-ийн WEB SITE www.ubtds.mn дах мэдээлэл

- Сургуулийн бүтэц зохион байгуулалт
- Захиргаа
- Сургалт

- Эрдэм шинжлгээ
- Номын сан
- Оюутан
- Элсэлт
- Мэдээ
- Төсөл хөтөлбөрүүд

Сургуулийн бүтэц зохион байгуулалт, сургалт семинар, эрдэм шинжилгээний хурал, тэмцээн уралдаан, нийгэмд чиглэсэн ажил үйлчилгээ, гадаад харилцааны талаарх мэдээ мэдээллийг цаг алдалгүй тухай бүрд нь оруулж, танилцуулах зэргээр 2017 оноос эхлэн ашиглаж байна.

Зураг 49



УБТДС-иас гаргадаг “Биеийн тамир, спортын онол, арга зүй” сэтгүүл нь дараах мэдээллийг агуулдаг.

- Мэдээ мэдээлэл
- Мэндчилгээ
- Эрдэм шинжилгээ судалгааны ажлын үр дүн
- Биеийн тамирын багшийн булан
- Төгсөгч оюутан
- Спортын эрдэмтэн
- Хөдөлгөөн эрүүл мэнд
- Оюутан тамирчин
- Нэг ангийхан
- Спортын сураглт дасгалжуулалтын технологийн шинэчлэл
- Олимпын боловсрол

MNBC спорт суваг.

MNBC спорт сувагтай хамтран ажиллаж сургуулийн болон тэмцээн уралдааны талаарх бүхий л мэдээллийг цаг тухай бүрд нь олны хүртээл болгож ажилладаг

9.5.Чанарын удирдлагын нөөц

Сургууль нь салбар, нэгж, хөтөлбөр бүрээр багш, ажилтны зохистой орон тоо, ур чадварын шаардлагыг тогтоон, нээлттэй сонгон шалгаруулж, ажлын байрандаа хөгжих үйл явцыг дэмждэг байна. Чанарын удирдлагын нөөцийг бүрдүүлэхдээ тогтвор сууршилтай ажиллах боломжтой багш нараас бодлогоор

чанарын баталгаажуулалтын албанд томилон дадлага туршлага эзэмшүүлэхэд анхаарч байна.

Хүснэгт 41

**Салбар, нэгжүүдийн хүний нөөцийн бүрдлийн түвшин
(давхардсан тоогоор)**

№	Салбар нэгж, тэнхим	Тоо	Боловсрол ба эрдмийн цол, зэрэг	Спортын цол зэрэг
1	Удирдлагын түвшинд	1	ШУ-ны доктор	ОУХМ
2.	Сургалтын алба	3	Дэд проф.-1 Магистр-2	-
3.	Санхүүгийн алба	3	Доктор, проф.1 Бакалавр-2	-
4	Онол арга зүйн тэнхим	15	ШУ-ны доктор-1 Доктор-7 Докторант-1 Магистр-6	ОУХМ- 2 СМ-3
5	Үндэсний спорт, мэргэжлийн тэнхим	17	Докторант-1 Магистр- 16	ОУХМ-2, СМ-10
6.	Биеийн тамирын эмчилгээний арга зүйн тэнхим	5	Докторант - 2 Магистр- 3	-
	Бүгд	43		

Дээрх хүснэгтэн үзүүлэлтээс харахад боловсон хүчний чанар хүний нөөцийн хувьд шаардлага хангасан түвшинд хүрч байгаа гэж үзэж болно.

9.6. Олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн байдал

Сургууль нь чанарын баталгааг хангаж, сургуулийнхаа нэр хүндийг гадаадад болон олон улсын түвшинд хүлээн зөвшөөрүүлэхэд чиглэсэн гадаадын улс орнуудад адил төстэй сургуультай дүйцэх түвшинд хүрэх бодлого, үйл ажиллагааг үр дүнтэй хэрэгжүүлдэг.

ҮБТДС нь бүс нутаг, олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн, эрх бүхий чанарын байгууллага, хөдөлгөөнд гишүүнээр элсэх, батламж, гэрчилгээ авах зэргээр ижил түвшинд байгаага нотлон харуулдаг байна. Тухайлбал ОУ-ын ШУ, Биеийн Тамирын Боловсролын зөвлөл /ICSSPE/- д нэгдэж түүний гишүүний D-132 кодтой байгууллага болж чадсанаар 1999 оноос эхлэн ОУ-ын хурал, семинар, зөвлөгөөнд бүрэн эрхтэй оролцдог болсон.




Мөн АНУ-д төвтэй Олон улсын Эрүүл Мэнд, Бие бялдар, Нөхөн сэргээлт, Спорт, Бүжгийн Зөвлөлийн гишүүнээр 2000 оны 5-р сард элсэн түүний гишүүн орнуудтай өргөжүүлэн ном хэвлэл, мэдээлэл харилцан солилцох зэрэг хамтын ажиллагаагаа одоо хүртэл явуулж байна.

Батламж, гэрчилгээ



2015 оны 7-р сарын 23-ны өдөр БНСУ-ын Биеийн тамир, чийрэгжүүлэх холбоо ҮБТДС-ийн Биеийн Тамир эмчилгээний арга зүйн тэнхимтэй хамтран ажиллах гэрээнд гарын үсэг зурлаа.



9.7. Үндэсний хэмжээний байр суурь

Одоогийн нөхцөлд спортын сургуулийн эрэмбэглэгдсэн байдлын судалгаа тэр бүр байдаггүй. Сургалтын үйл ажиллагаа тогтмолжсон, чанарын үр дүнгийн Шалгуур үзүүлэлтүүдээр БСШУЯамны аттесстатчтлалын шалгалтанд 2009 онд


орж аттестатчилагдсан. Спортын амжилтаар 1-р байранд эрэмблэгдэх гол нотолгоо нь төр хувийн хэвшлийн их, дээд сургуулиудын дунд 4 жилд 1 удаа явагддаг "Универсиад" их наадамд 2017 онд тэргүүн байрт шалгарсан. 28 жилийн түүхэн хөгжлийн явцад Хөдөлмөрийн баатар 21, гавьяат дасгалжуулагч 4, гавьяат тамирчин 19, Олимпын медальт, 3 дэлхийн аварга 10, Улсын арслан 1 улсын гарьд 2, улсын заан 3 заан, улсын харцага 2, улсын начин 3, аймаг сумын цолтой 10 д оюутан тамирчин төрөн гарсан байна.

Хүснэгт 42

ҮБТДС-ийн оролцсон тэмцээн, уралдааны үндсэн үзүүлэлт

Шалгуур	ҮБТДС	МУБИС-н УБТДС	Аварга БТДС	Мон- Алтиус	Олимп БТДС
Тэмцээн уралдаанд оролцсон байдал тоо	307	70	20	60	15
Тэмцээн уралдаанд оролцсон амжилт	71	40	20	25	10
Оролцсон тэмцээн уралдааны төрөл	30	25	8	16	2
Тэмцээн ураалдаанд оролцсон оюутны тоо	2170	850	200	550	50
Тэмцээн уралдаанд оролцсон байдлаархи эрэмбэ	1	2	4	3	5

Зураг 54



Олон улсад эзэлдэг эрэмбэд 2,95 оноо өгсөн нь бусад дэд шалгуур үзүүлэлтүүдээс доогуур үнэлжээ. Тиймээс цаашид нь олон улсад хүлээн зөвшөөрөгдөх асуудалд илүү анхаарал хандуулж ажиллах шаардлагатай гэж үзэж байна.

Хүснэгт 43

Шалгуур үзүүлэлт 9-д хийсэн SWOT шинжилгээ

Давуу тал	Сул тал
<ul style="list-style-type: none"> • ҮБТДС нь үүсгэн байгуулагдсан цагаасаа эхлэн өнөө хүртэл дотоод хяналт, шалгалтыг сургуулийн удирдлагаас сайн зохион байгуулж , хэрэгжүүлж ирсэн уламжлалтай . • Чанарын баталгаажуулалтын албаны бодлого, тогтолцоотой, уг албаны ажиллах журам удаа дараа тодотгогдож сайжирсан, түүнийг хэрэгжүүлэх бие даасан алба ажилладаг. • Багш хамт олон чанарын баталгаажуулалтын албаны үйл ажиллагаа, ач холбогдлыг нь зөв ойлгож дэмждэг. • Боловсролын болон эрдмийн, спортын өндөр зэрэгтэй, заах арга зүй сайтай багш нарын бүрэлдэхүүн ажилладаг нь сургалт, эрдэм шинжилгээний ажлын чанарын үзүүлтэд эергээр нөлөөлж чаддаг. • Захиргааны болон үйлчилгээний ажилтан багшлах бүрэлдэхүүн сургуулийн эрхэм зорилгыг хангах хүрээнд амжилт, чанарын төлөө санаа нэгтэй "Итгэл, Сэтгэл, Зүтгэл" гэсэн уриатай ажилладаг. • Багш нар сургах ажилдаа, оюутнууд мэргэжилдээ дур сонирхолтой байдаг онцлогтой. • Гадаад хамтын ажиллагаа сайн хөгжиж ирсэн. • Төгсөгчдийн амжилт, болон Үндэсний хэмжээний эрэмбээр тэргүүлэх үзүүлэлтийг хангаж байдаг. • Дотоод хяналт, шалгалт сайтай камерийн иж бүрэн хяналтын систем, цаг бүртгэлийн хуруу танигч тоног төхөөрөмж ашиглан сургуулийн үйл ажиллагааг хянаж, дутагдлыг цаг тухайд нь арилгаж ажилладаг 	<ul style="list-style-type: none"> • Зарим багш, оюутнууд спортын амжилтыг онолын сургалт, эрдэм шинжилгээний ажлаас илүүд үзэх хандлагатай байдаг. • Олон улсын хэмжээний эрэмбээр хамт олны үнэлгээ 2,95 байгаа нь их дээгүүр үзүүлэлт биш гэж үзэж байна. • Багш оюутнуудын гаргасан спортын болон эрдэм шинжилгээ- судалгааны ажлын амжилтыг үнэлэх, урамшуулах байдал их өндөр биш , зөвхөн сургуулийн хэмжээнээс хэтэрдэггүй . • БТСГ-аас тус сургуулийн 28 жилийн туршид Улс эх орны хэмжээнд оруулж ирсэн хувь нэмрийг үнэлж, эдийн засгийн болон сэтгэл зүйн хувьд бодлогоор дэмжих, урамшуулахад бага анхаардаг.

Боломж	Эрсдэл
<ul style="list-style-type: none"> • Сургууль олон улсын эрдэм шинжилгээний хурлыг үр дүнтэй зохион байгуулж явуулсан, энэ талаар багагүй туршлагатай байдлыг түшиглэн хойшид явагдах олон улсын эрдэм шинжилгээний хурлыг зохион байгуулж явуулахад тус сургуулийг гол байр суурьтай оролцуулах. • Багш нарыг гадаад улс орнуудад Эрдэм шинжилгээний хуралд оролцох, сургалт явуулахад дэмжлэг үзүүлдэг, цаашид улам өргөжүүлэх боломжтой • Багш нарын мэдлэг чадвар, гадаад хэл, сурган заах арга зүйг дээшлүүлэхэд чиглэсэн сургалтуудыг сургуулиас зохион байгуулдаг. • Сургуулийн өргөтгөл шинэ байрыг барьж байгуулан гадаад харилцаагаа улам өргөжүүлж, эрдэм шинжилгээ-судалгааны ажлыг улам сайжруулан олон улсын жишигт хүрсэн сургалт судалгааны Үндэсний Биеийн Тамир, Спортын Их Сургууль болгох бүрэн боломжтой болно. 	<ul style="list-style-type: none"> • Биеийн тамир, спортын мэргэжлийн бус удирдах албан тушаалтан ДБСБ-ын ажилтан, МИҮЗ-ийн мэргэжилтэн нараас Үндэсний Биеийн Тамирын Дээд Сургуулийн үйл ажилгааны өвөрмөц онцлогтой байдлыг хүндэтгэн, гүнзгий судалж ойлгоогүй, ойлгуулаагүй байдлуудаас шалтгаалж, зөрчилтэй ойролт гарах магадлалтай. • Монгол Улсын хэмжээнд Үндэсний спортын баялаг өв уламжлалд суурилсан, орчин цагийн биеийн тамир спортын төрлүүдийг хөгжүүлэх чиглэлтэй цорын ганц биеийн тамирын дээд сургууль гэдэг онцгой байдлыг тэр бүр бүрэн ойлгохгүй нийтийн жишгээр хандах байдал зэрэг болно.

Цаашид сургуулийн зүгээс чанарын удирдлагын бодлогыг тууштай хэрэгжүүлж, чанарын стандарт шаардлагын сургуулийн бүх үйл ажиллагаанд жигд хангахын тулд дараах арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлэхээр төлөвлөж байна. Үүнд:

1. Сургуулийн алба тэнхим, нэгж бүрийн онцлогийг харгалзан чанарын стандарт шаардлагыг тус сургуулийн чанарын баталгаажуулалтын албанаас тодорхойлж, түүний дагуу графикийн дагуу шалган үнэлж, баталгаажуулалт олгож байх.
2. Чанарын стандарт шаардлагыг хангаж, баталгаажуулалт амжилттай хийлгэсэн алба нэгжүүдийг нийтийн өмнө урамшуулж, ажлын арга туршлагыг нь бусдад судлуулж, дэлгэрүүлэх, хэвлэл мэдээллийн хэрэгслээр нийтийн хүртээл болгох ажлыг тасралтгүй зорион байгуулж явуулах.

Дээрх зорилтуудыг хэрэгжүүлснээр сургуулийн бүх үйл ажиллагаа чанарын хувьд улам сайжирч, жигдрэн сургуулийн хэмжээнд эрхэм зорилгодоо хүрэх нөхцөл бүрэн бүрдэж чадна, эхний алхамууд хийгдсэн, зарим үр дүн нь гарч байна.

СТРАТЕГИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ТӨЛӨВЛӨГӨӨ

№	Үйл ажиллагаа	Хэрэгжүүлэх хугацаа	Зарцуулах төсөв (сая төгрөгөөр)	Хэрэгжүүлэх арга хэлбэрүүд
1.Сургалт- эрдэм шинжилгээний ажлын талаар				
1	Профессорын багаар ажиллах тогтолцоог сайжруулах, боловсронгуй болгох	2016-2017	-	Өмнөх туршлагад шүүмжлэлтэй бүтээлчээр хандаж шийдвэрлэх
2	Эрдэмтэн профессор багш нарын тогтвортой бүрэлдэхүүнийг хадгалж 3 багш докторын зэрэг хамгаалах	2016-2018 он	-	Төрийн сан, зээл хөнгөлөлт
3	Багш нарыг дотоод, гадаадад мэргэжил дээшлүүлэх эрдмийн цол хамгаалахад нь дэмжлэг үзүүлэх, үндсэн багш нар дотор эрдэмтдийн эзлэх хувийн жинг 10-20% -д хүргэнэ	2017 -2021 он	-	Засгийн газар хоорондын хамтын ажиллагааны тэтгэлэгт хөтөлбөрөөр
4	Бакалаврын болон магистрын хөтөлбөрүүд дэх сургалтын төлөвлөгөөнд заагдсан хичээлүүдээр онол, арга зүйн тулгуур сурах бичгүүдийг боловсруулах, орчуулах, хэвлэн нийтлэх ажлыг өргөжүүлэх, урьд хэвлүүлсэн сурах бичгүүдийг цахим хэлбэрт шилжүүлэх, эдийн засгийн эргэлтэнд оруулах	2016 -2021 он	Сургуулийн төсөв, хандив	Жил жилд өлөвлөгөөтэйгээр боловсруулж хэвлүүлнэ
5	Бакалаврын "Биеийн тамирын багш", "Спортын дасгалжуулалт", "Биеийн тамирын болон эмчилгээний арга зүйч" хөтөлбөрүүдийг өөрийн орны МИҮЗөвлөлөөр магадлан итгэмжлүүлэх	2016-2017 он	Сургуулийн төсвөөс	ҮБТДС-ийн хөтөлбөрийн баг зохион байгуулах
6	Хамтын ажиллагаатай гадаадын их дээд	2019 он		Хамтын ажиллагааны

	сургуулиудтай хамтарсан хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлыг эхлүүлэх, оюутан, багш солилцоог идэвхижүүлэх			гэрээ, хэлэлцээр төлөвлөгөөний дагуу зохион байгуулах
7	Сургалтын үйл явцыг сургалт-эрдэм шинжилгээ-үйлдвэрлэл гэсэн тогтолцоонд шилжүүлж, сургалтын болон судалгааны чиглэлээр олон улсын болон өөрийн орны байгууллагуудын дэмжлэг авах, шинжлэх ухааны төсөл, хөтөлбөр боловсруулах хэрэгжүүлэх,	2018-2021 он		Төлөвлөгөө, хүсэлтийн дагуу хэрэгжүүлэх
8	"Биеийн тамир, спортын тухай" хуульд нэмэлт өөрчлөлт оруулах ажлын хэсэгт эрдэмтдийн багийн ахлагчаар ажиллаж, Монгол улсын хүн амын бие бялдрын чийрэгжүүлэлтийн хөтөлбөрийг боловсруулахад хамтран оролцох	2016 он	-	БСШУСпортын яам, ЗГХАгентлаг БТСпортын газар
9	Олон улсын магадлан итгэмжлэгдсэн байгууллагаар сургуулийн үйл ажиллагаа, байгууллагын магадлан итгэмжлэл хийлгэх	2017-2021 он	Сургуулийн төсөв.	БМИУЗөвлөл, Сургуулийн захиргааны хүсэлтээр шийдвэрлэх
10	Хамтын ажиллагааны гэрээтэй Москва, Алма-ата, Киев, Токио, Казакстан, Бээжингийн болон бусад спортын их сургуульд багш нарын 60% -ийг мэргэжил дээшлүүлэх ажлыг төлөвлөгөөтэйгээр гүйцэтгэж, гадаадын эрдэмтэн багш нарыг урьж ажиллуулна.	2017-2017 он	Сургуулийн төсөв	Тодорхой төлөвлөгөөний дагуу гэрээ, хэлэлцээрээр шийдвэрлэнэ.
11	Багш, судлаачдын эрдэм шинжилгээний ажлын үнэлэмжийг дээшлүүлэх, "Биеийн тамир, спортын онол, арга зүй" сэтгүүлийн чанарт өөрчлөлт хийх	2017 он	Сургуулийн төсөв, захиалагчдын төлбөрөөс	Мэдээллийн ажилтан, редакцын гишүүдээр дамжуулан боловсронгуй болгоно.

2. Биеийн тамир,спортын ажлын талаар				
12	"Токио 2020"-ын олимпийн баг тамирчдыг амжилттай оролцуулахад шинжлэх ухааны үндэслэлтэй бэлтгэх арга зүйг боловсруулах ажлын хэсэгт оролцох	2017-2020 он	БТСХороо, МҮОлимпи йн хороо, Спорт холбоодын зардлаар	БТСХороо, МҮОлимпийн хороо, Спорт холбоодтой гэрээ байгуулж, хамтран ажиллана.
13	Оюутны спортын ур чадварыг дээшлүүлэх "Шавь сургалт"-ын бүтэц, зохион байгуулалтыг боловсронгуй болгож, Монгол улсад шилдэг тамирчдыг бэлтгэх тогтолцоог бүрдүүлж, тив, дэлхий, олимпод бэлтгэн оролцуулах зохих хувь нэмрээ оруулна.	2017-2020 он	Шигшээ баг, ивээн тэтгэгч байгууллага, сургуулийн төсвөөс	Шигшээ баг, ивээн тэтгэгч байгууллага, сургуулийн мэргэжлийн багш, дасгалжуулагч нар зохион байгуулна
14	Монголын төр, хувийн хэвшлийн сургуулиудын дунд зохиогддог оюутны "Универсиад-2017" их наадамд шилдэг баг бэлтгэж тэргүүн байр	2017 он	Сургуулийн төсвөөс 20 сая төгрөг	Календарчилсан төлөвлөгөөний дагуу хариуцсан багш, дасгалжуулагч нар бэлтгэж, оролцуулах
15	Төгсөгчдийн мэргэжлийг дээшлүүлэх орон тооны алба байгуулах	2017 он	Сургуулийн төсвөөс	Судалгааны үндсэн дээр, төв орон нутагт зохион байгуулах
3.Сургалтын орчин, үйлчилгээ				
16	Спорт сургалтын цогцолборын барилга барих төсөл боловсруулах, холбогдох зураг эскиз хийлгэх, хөрөнгө оруулалтын эх үүсвэрийг шийдэхэд, Интерконслатинг группын мэргэжлийн багаар ТЭЗҮ, зах зээлийн судалгаа зэргийг хийлгэсэж зөвлөгөө авсан 32,85 сая	2016-2018 он	Сургуулийн төсөвөөс 40,0 сая төгрөг зарцуулав	Экспертээр батлагдсан барилгын БА, ББ, эскиз зураг төсөл бэлэн болсон байна. Интерконслатинг группын мэргэжлийн багаар ТЭЗҮ, зах зээлийн


				судалгаа зэргийг хийлгэж зөвлөгөө авсан 32,85 сая авсан бөгөөд Зээл тусламжийн, хөрөнгө оруулалтыг авах бичиг баримт бүрдсэн байна.
17	Спортын сургалтын цогцолборын дэргэдэх биеийн тамир, эмчилгээ, нөхөн сэргээлтийн эмнэлэг байгуулах	2019 оноос	Хандив, зээл, тусламж, сургуулийн төсвөөр	Сургуулийн төсөв, хувийн хэвшил, бизнесийн хамтын ажиллагаанаа с олсон орлого, ивээн тэтгэгч нарын хандив, зээл тусламж
18	Тэнхимүүдийн харьяа лаборатори, дадлагын ажлын төвүүдийг байгуулж, судалгааны ажлын чадамж, үр дүнг нэмэгдүүлэх	2017-2021	Сургуулийн төсөв	Ажлын хэсэг
19	Багш ажилчдын нийгмийн баталгааг дэмжих	2017-2021	Хандив, зээл, тусламж	Тодорхой төлөвлөгөөний дагуу зохион байгуулах

Хавсралт 2


Хүснэгт 4.1.УБТДС-ийн багш нарын докторын зэрэг хамгаалсан он, докторын ажлын сэдэв

№	Овог нэр	Боловсролын зэрэг	Хамгаалсан он	Хамгаалсан сургууль	Хамгаалсан сэдвийн нэрс	Спортын зэрэг цол
1	Г.Алтанцэцэг	Шинжлэх ухааны доктор (ScD), профессор	2014 он	ОХУ-ын Биенийн тамир, спорт, аялал жуулчлал, залуучуудын бодлогын их сургууль	Боловсрол судлалын шинжлэх ухааны докторын зэрэг хамгаалсан	Гимнастикийн ОУХМ
2	Г.Гүндэгмаа	доктор (Ph.D), дэд профессор	2009 он	ОХУ-ын Ломносовын нэрэмжит Москвагийн Их сургууль, Антропологийн хүрээлэнд докторын зэрэг хамгаалсан.	Сэдэв: Монголын оюутан залуучуудын биеийн бүтэц, үйл ажиллагааны онцлог орчны болон удамшлын хүчин зүйлсээс хамаарах нь	
3	Д.Бордух	доктор (Ph.D), профессор	1977 он	ЗХУ-ын Коммунист намын төв хорооны дэргэдэх Нийгмийн ухааны академид удирдахуйн ухааны дэд докторын зэрэг хамгаалсан.	Сэдэв: Хөдөлмөрийн хамт олны нийгмийн хөгжлийг төлөвлөх нь үйлдвэрлэлийн үр ашгийн дээшлүүлэх хүчин зүйл мөн	
4	Р.Ганбаатар	доктор (Ph.D) профессор	1997 он	ОХУ, Москва хот Бүх оросын биеийн тамир, спортын эрдэм шинжилгээний хүрээлэнд докторын зэрэг хамгаалсан.	Сэдэв: Монгол улсын цэргийн насны бие бялдрын бэлтгэлжилтийн хяналтын нормын шинжлэх ухааны үндэслэл	Гимнастикийн ОУХМ
5	И.Сэржхүү	Доктор (Ph.D), профессор	2013 он	Үндэсний батлан хамгаалах их сургууль, Цэргийн эрдэм шинжилгээний хүрээлэнгийн аюулгүй байдлын албанд докторын зэрэг хамгаалсан	Сэдэв: Улсын хил хамгаалалтад зэвсэгт хүчний анги, салбаруудаар дэмжлэг үзүүлэх зарим асуудал	
6	Р.Түвшинжаргал	Доктор (Ph.D)	2018 он	МУБИС	Сэдэв: Тархины саатай хүүхдийн хөдөлгөөнийг засахад биеийн тамирын дасгал хэрэглэсэн үр дүн, арга зүйн судалгаа	
7	Д.Баасанхүү	Доктор (Ph.D)	2015 он	БНХАУ-ын ӨМӨЗО-ны Өвөр Монголын их сургуульд докторын зэрэг хамгаалсан .	Сэдэв: Олноо өргөгдсөн Богд хаант Монгол улсын гаалийн яамны түүхийн судалгаа	
8	Н.Мягмарзул	Доктор (Ph.D)	2016 он	МУЭИС, Бизнесийн удирдлагын доктор	Сэдэв: Хоршооны санхүүгийн менежментийг сайжруулах нь (Баруун бүсийн жишээн дээр)	Ушгу-ын спортын мастер

Зураг 4.1. Доктор зэрэгтэй багш нарын тоо (2014-2018 оноор)



Спортын зэрэг, цолтой багш нарын тоо (2016-2018 оноор)





**ҮНДЭСНИЙ БИЕЙН ТАМИРЫН
ДЭЭД СУРГУУЛИЙН ЗАХИРЛЫН
ТУШААЛ**

_____ оны _____ сарын _____ өдөр

Дугаар _____

Улаанбаатар хот

Г _____ Г
Чанарын дотоод баталгаажуулалтын албаны
бүрэлдэхүүнийг шинэчлэн батлах тухай

ТУШААХ НЬ:

2018 оны 12 дугаар сарын 25 - ны өдрийн захиргааны зөвлөлийн хурлын шийдвэрийг үндэслэн ТУШААХ НЬ:

Нэг. "Дотоод чанарын баталгаажуулалтын алба"-ны нэрийг "Чанарын дотоод баталгаажуулалтын алба" болгон өөрчилж, дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай.

Үүнд:

1."Чанарын дотоод баталгаажуулалтын алба"-ны даргаар доктор(Ph.D) И.Сэржүү

Гишүүдэд: 2.Т.Баатар /магистр/

3.Р.Лхагвасүрэн /магистр/

4.Г.Хулан /магистр/

5.Г.Дэлгэрсүрэн /магистр/

Хоёр. Захирлын 2018 оны 10 дугаар сарын 10-ны тушаалыг хүчингүй болсонд тооцсугай

Гурав. "Чанарын дотоод баталгаажуулалтын алба"-ны ажлын төлөвлөгөөг хавсралтаар баталсугай

ЗАХИРАЛ

ДОКТОР(Sc.D), ПРОФЕССОР
Л.АЛТАНЦЭЦЭГ



ҮНДЭСНИЙ БИЕЙН ТАМИРЫН
ДЭЭД СУРГУУЛИЙН ЭРДМИЙН
ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2019 оны 12 сарын 25 өдөр

Дугаар 44

Улаанбаатар хот

“Чанарын бодлого”-ыг батлах тухай

ТУШААХ НЬ:

Нэг. Үндэсний Биеийн Тамирын Дээд сургуулийн чанарын бодлого нь “Монгол Улсын нийт ард ирэгдийн бие бялдрын хөгжил, бэлтгэлжилт болон спортын амжилтыг эрхэмлэн, төгсөгчдөд ажил олгогч төрийн болон төрийн бус байгууллагуудын сэтгэл ханамжийг дээдэлсэн биеийн тамир, спортын боловсролын үйлчилгээг үзүүлж, чанарын удирдлагын тогтолцоог тасралтгүй сайжруулан БМИҮЗ-ийн ДББ-ын магадлан итгэмжлэх шалгуур үзүүлэлтүүдийг хангаж, өөрчлөлт шинэчлэлтийг түгээгч Үндэсний Биеийн Тамирын Их сургууль болно” гэж тодорхойлон баталсугай.

Хоёр. Сургуулийн шинэчлэн батлагдсан “Чанарын бодлого”-ыг алба, нэгж, тэнхимүүд бүх багш ажилтан бүрт хүргэн хэрэгжүүлэхийг “Чанарын дотоод баталгаажуулалтын алба”-нд даалгасугай.

ЗАХИРАЛ



ДОКТОР(Sc.D), ПРОФЕССОР
Л.АЛТАНЦЭЦЭГ

Орос – Монголын хамтарсан баг Монголд онд ирсэн



Хавсралт 6 үргэлжлэл



Японы төслийн зургууд



Хавсралт 6 үргэлжлэл

Тамирчдын судалгаа





ҮНДЭСНИЙ БИЕЙН ТАМИРЫН
ДЭЭД СУРГУУЛИЙН ЗАХИРЛЫН
ТУШААЛ

2018 оны 10 сарын 18 өдөр

Дугаар 39

Улаанбаатар хот

Оюутанд чөлөө олгох тухай

ТУШААХ НЬ:

Нэг. Дасгал хөдөлгөөн нь Монгол хүүхдийн сурах чадвар, танин мэдэхүйн үйл ажиллагаа, бие махбодийн эрүүл мэндийн байдалд үзүүлэх үр нөлөөний талаарх кластер санамсаргүй түүврийн харьцуулсан судалгааны багийн гишүүн доорх нэр бүхий оюутнуудад 2018 оны 10 дугаар сарын 19-26-ны өдрүүдэд хичээлээс чөлөөлсүгэй.

Үүнд:

- | | |
|-------------------|---------|
| 1. Т.Мөнхцэцэг | 2г анги |
| 2. Э.Отгонтуяа | 2г анги |
| 3. Б.Анхбаяр | 2г анги |
| 4. Б.Должин | 3б анги |
| 5. Д.Жагслав | 3б анги |
| 6. Ч.Үенч | 3б анги |
| 7. Б.Дэмүүл | 3в анги |
| 8. А.Цэрэндолгор | 3в анги |
| 9. Э.Доржханд | 3в анги |
| 10. Б.Жүгдэрсүрэн | 3г анги |
| 11. Б.Бүжидмаа | 3г анги |
| 12. Ц.Жавзмаа | 3д анги |
| 13. Э.Нямсүрэн | 3д анги |
| 14. З.Оюун | 3д анги |
| 15. Э.Цогзолмаа | 3д анги |
| 16. Г.Оюунгэрэл | 4а анги |
| 17. М.Бадамханд | 4а анги |
| 18. А.Анударь | 4а анги |
| 19. Б.Мөнхжаргал | 4а анги |

Хоёр. Чөлөөтэй байх хугацаанд хуваарийн дагуу орох хичээл дээр таслалт болон хоцролт тавьж байгаад хяналт тавьж ажиллахыг эмчилгээ арга зүйн тэнхимийн эрхлэгч /Ш.Бат-Эрдэнэ/-д үүрэг болгосугай.

ЗАХИРАЛ



ДОКТОР (Sc.D), ПРОФЕССОР
Л.АЛТАНЦЭЦЭГ

Мэдээлэл боловсруулсан:

магистр М.Мөнхбат

Хянасан:

Захирал Доктор (Sc.D), проф.
Л.Алтанцэцэг